



МОНГОЛБАНК



ЖИЛИЙН ТАЙЛАН 2015

МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ҮГ



Н.ЗОЛЖАРГАЛ
Монголбанкны Ерөнхийлөгч

Эрхэмсэг хатагтай, ноёд оо

Олон улсын санхүүгийн хямралын дараах дэлхийн голлох эдийн засгийн хандлага, Хятад улсын эдийн засгийн бүтцийн өөрчлөлт нь хөгжиж буй улс орнуудын, ялангуяа түүхий эдийн экспорт давамгайлсан эдийн засагт шинэ орчныг бий болгож байна.

Энэхүү шинэ орчинд нэгдүгээрт, өндөр хөгжилтэй болон хөгжиж буй орнуудын эдийн засгийн өсөлтийн потенциал буурч, дэлхийн эдийн засгийн өсөлт ойрын 10 жилд нам түвшинд хадгалагдах хандлагыг юуны өмнө дурдах нь зүйтэй. Хоёрдугаарт, урд хөршийн эдийн засгийн хурдацтай өсөлт саарч, экспорт, хөрөнгө оруулалтад суурилсан эдийн засгийн бүтцээс дотоодын хэрэглээ, үйлчилгээний салбарт тулгуурласан буюу урт хугацааны илүү тогтвортой өсөлтийн загвар руу аажим шилжиж байна. Гуравдугаарт, дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнийн супер циклийн уналтын мөчлөг 2012 оноос эхэлж, эрдэс түүхий эдийн үнэ унаж, бага үнийн түвшин цаашид хадгалагдахаар байна. Дөрөвдүгээрт, олон улсын санхүүгийн хямралын дараагаас Ази, Латин америкийн өсөлттэй эдийн засаг руу чиглэж байсан хөрөнгийн урсгал сүүлийн 3 жилд эргэж, хөгжиж буй орнуудаас хөрөнгө гадагшлах хандлага үргэлжлэхээр байна. Эцэст нь макро эдийн засгийн бодлого, ялангуяа мөнгөний бодлого “уламжлалт бус” хэлбэрт шилжиж, түүний эдийн засаг дахь үүрэг оролцоо нь зөвхөн үнийн тогтвортой байдал, санхүүгийн тогтвортой байдлаар хязгаарлагдахааргүй өргөжиж, энэ нь өндөр хөгжилтэй орон төдийгүй хөгжиж буй орнуудад ч түгээмэл жишиг боллоо.

Сүүлийн 3 жилд бий болсон энэхүү шинэ нөхцөл нь ашигт малтмалын үнэ, гадаадын хөрөнгө оруулалтаас хэт хамааралтай болсон, макро бодлого нь хуримтлалыг гэхээсээ хэрэглээг дэмжиж ирсэн, эдийн засагт хуримтлалтын тогтолцоо буюу хамгаалалтын механизмуудыг бий болгож чадаагүй байсан манайх шиг улс орнуудын эдийн засагт хүчтэй цочрол үүсгэж, макро эдийн засгийн бодлогод хүндхэн сорилт болж байлаа. Монгол Улсын экспортын үнийн индекс 2015 онд 28.5 хувиар буурч гадаад худалдааны нөхцөл 25.1 хувиар муудлаа. Гадаадын шууд хөрөнгө оруулалт цэвэр дүнгээр 2012 онд 4.4 тэрбум ам.доллар байсан бол 3 жилийн дотор 0.1 тэрбум болж огцом буурсан.

Ийм нөхцөлд дотоодын эдийн засаг, санхүүгийн салбарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, богино хугацаанд эдийн засаг огцом агших эрсдэлээс сэргийлэх, санхүүгийн болон макро эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалах үндсэн зорилтууд бүхий бодлогыг 2013-2015 онд амжилттай хэрэгжүүлээ. Дээрх бодлого нь зорилт, агуулга болон цаг хугацааны хувьд: (1) 2013-2014 оны эдийн засгийг “зөөлөн газардуулах” бодлогын арга хэмжээ, (2) макро бодлогын нэгдсэн өөрчлөлтөөр эдийн засгийн тэнцвэрийг дэмжих 2015 оны бодлогын арга хэмжээ гэсэн үе шаттай байв.

Хэрэгжүүлсэн бодлогын үр дүнд инфляцийн зорилтыг хангаж, төлбөрийн тэнцэл, инфляци, өрхийн зардал, нийт эдийн засгийн бүтцэд зайлшгүй шаардлагатай суурь өөрчлөлт, тохиргоонууд хийгдэж, санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалав. Тухайлбал:

- Хэрэглээний үнийн индексээр илэрхийлэгдсэн жилийн инфляци 2012 онд 14.0 хувь байсан бол 2015 оны эцэст 1.9 хувь болж инфляцийн зорилтыг хангав. Ийнхүү ДНБ-ий бодит өсөлт бүхий орчинд нам, тогтвортой инфляцийн эерэг орчныг бүрдүүлэхэд нэгд, өмнө нь инфляцийн 1/3-ийг бүрдүүлдэг байсан нийлүүлэлтийн гаралтай инфляцийн дарамт сүүлийн 3 жилийн дотор тэг болсон, хоёрт, эдийн засгийн гадаад тэнцвэрийг дэмжих мөнгөний бодлогын төлөвийг 2015 оны туршид хадгалснаар нийт эрэлт буурч хэрэглээ хумигдсан, гуравт, төлбөрийн урсгал болон нийт тэнцлийн алдагдал буурч валютын зах

тогтворжихын хэрээр төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн инфляци дахь сөрөг нөлөөлөл буурсан зэрэг нь нөлөөллөө. Цаашид 2016-2018 онд инфляцийн зорилтот 5-7 хувийн түвшинг хангах үндсэн нөхцөл бүрдэв.

- Монгол Улсын төлбөрийн урсгал тэнцлийн алдагдал 2012 онд 3362 сая ам.доллар буюу ДНБ-ий 27 хувьтай тэнцэх хэмжээнд байсан бол 2015 онд 469 сая ам.доллар буюу ДНБ-ий 4 хувь болж буурлаа. Үүнд барааны гадаад худалдааны тэнцэл 2015 онд 883 сая ам.долларын ашигтай болж, 2012 онтой харьцуулахад 3.2 тэрбум ам.доллараар сайжирсан нь шууд нөлөөлөв. Төлбөрийн нийт тэнцэл 2013 онд 1867 сая ам.долларын алдагдалтай гарч байсан бол алдагдлын хэмжээ нь буурсаар 2015 онд 268 сая ам.доллар болж буураад байна. Ийнхүү урсгал тэнцлийн алдагдлыг 3 жилийн дотор 7.2 дахин бууруулж, төлбөрийн тэнцлийн бүтцэд зарчмын эерэг өөрчлөлт гарснаар 2016 оноос эхлэн төлбөрийн нийт тэнцэл алдагдалгүй байх боломж бүрдэж байна.
- Санхүүгийн салбарт системийн шинжтэй эрсдэл үүсэхээс сэргийлж, банкуудын төлбөрийн чадварыг хадгаллаа. 2015 оны эцэст банкны салбарын өөрийн хөрөнгийн харьцаа 17.9 хувь, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 39.7 хувь байсан нь зохистой харьцааны шалгуур үзүүлэлтээс харгалзан 5.9, 14.7 нэгж хувиар өндөр, системийн хэмжээнд эрсдэл даах чадвар өндөр байна. Зээл болон хадгаламжийн долларжилт сүүлийн 3 жилийн дотор харгалзан 8 болон 3 нэгж хувиар буурсан байна. Банкны системийн чанаргүй зээл нийт зээлийн 7.4 хувийг, татан буугдсан банкуудыг хасч тооцсоноор 5.5 хувийг эзэлж байна.
- Гадаад валютын улсын нөөц 2014 оны 05 дугаар сараас хойш 20 сарын турш 1.3-1.7 тэрбум ам.долларын түвшинд тогтвортой байна. 2015 оны эцэст гадаад валютын улсын нөөц 1323 сая ам.доллар байсан нь валютын төлбөртэй импортын сүүлийн 3 сарын дунджаар тооцоход 5.5 сарын импортын хэрэгцээг хангах түвшинд буюу олон улсын жишиг доод түвшнээс өндөр хэвээр байлаа. Цаашид валютын орох урсгалыг нэмэгдүүлэн төлбөрийн нийт тэнцлийг алдагдалгүй байлган, макро эдийн засгийн гадаад тэнцвэрийг бүрэн хангаж чадвал гадаад валютын улсын нөөц өсөх болно.
- Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөрийн үр дүнд сүүлийн 2.5 жилийн дотор ипотекийн зээлийн үлдэгдэл 3.5 дахин өсч 3.4 их наяд төгрөгт, зээлдэгчдийн тоо 2.4 дахин өсч 77.1 мянгад, ипотекийн зээлээр баталгаажсан бондын хэмжээ 2.0 их наяд төгрөгт хүрчээ. Энэхүү хөтөлбөрөөр дундаж давхаргын хуримтлал өсч, өрхийн зардлын бүтцэд эерэг өөрчлөлт гаран, цаашид эрэлтийн гаралтай инфляцийн дарамт бага байхад эергээр нөлөөлнө.

Ийнхүү нам, тогтвортой инфляцийн орчныг бүрдүүлж, эдийн засагт шаардлагатай тохиргоог 2013-2015 онд хийснээр хэрэглээнээс хуримтлалд шилжих зарчмын эерэг өөрчлөлтүүд гарч, 2016 оноос эхлэн макро эдийн засгийн “Шинэ тэнцвэр”-ийн бодлогыг хэрэгжүүлэх суурь нөхцөл бүрдээд байна.

Энэхүү бодлого нь: (1) Нам, тогтвортой инфляцийг хадгалах, (2) Улсын төсвийг нэгдмэл, бодитой, алдагдалгүй болгох, (3) Төлбөрийн нийт тэнцлийг алдагдалгүй байлгах, (4) Санхүүгийн тогтвортой байдлыг хангах, (5) Засгийн газрын өрийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх гэсэн үндсэн зорилт, тулгууртайгаар хэрэгжинэ.


Макро эдийн засгийн энэхүү шинэ тэнцвэрийн бодлогын хүрээнд Төрөөс мөнгөний бодлогын талаар 2016 онд баримтлах үндсэн чиглэлийг “эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлтийн суурь болох макро эдийн засгийн шинэ тэнцвэрийг хангах, банк, санхүүгийн тогтвортой байдлыг хадгалах” хэмээн томъёолж, инфляцийг 2016 онд 7 хувьд, 2017-2018 онд 5-7 хувийн хязгаарт тогтвортой байлгах зорилт дэвшүүлээд байна.



Н. ЗОЛЖАРГАЛ

Монголбанкны Ерөнхийлөгч

МОНГОЛБАНКНЫ БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ (2015)



ГАРЧИГ

1. МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ	9
1.1 Бодит сектор	9
1.2 Гадаад сектор	13
1.3 Мөнгө, санхүүгийн сектор	19
1.4 Улсын төсөв	27
2. ТӨРИЙН МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ	29
2.1 Мөнгөний бодлогын үндсэн зорилт, арга хэмжээ, үр дүн	29
2.2 Банкны салбарын тогтвортой байдлыг хангах бодлогын хэрэгжилт	35
2.3 Гадаад валютын улсын нөөцийн удирдлага	37
2.4 Монгол Улсын төлбөрийн систем	40
2.5 Банк санхүүгийн салбарын хууль тогтоомжийн өөрчлөлт, шинэчлэл	42
2.6 Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр	43
3. МОНГОЛБАНКНЫ МӨНГӨНИЙ ЗАХ ЗЭЭЛ ДЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	47
3.1 Төв банкны үнэт цаас	47
3.2 Төв банкны санхүүжилт	47
3.3 Засгийн газрын үнэт цаас	48
3.4 Гадаад валютын дуудлага худалдаа	49
3.5 Дотоодын зах зээлээс алт худалдан авах үйл ажиллагаа	50
4. МОНГОЛБАНКНЫ БҮТЭЦ, БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА	53
4.1 Монголбанкны бүтэц, зохион байгуулалт, хүний нөөцийн бодлого	53
4.2 Гадаад харилцаа	54
4.3 Олон нийттэй харилцах харилцаа	55
4.4 Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх арга хэмжээ	56
4.5 Дотоод хяналт, үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага	58
4.6 Бэлэн мөнгөний хангалт	59
4.7 Мэдээллийн технологи	60
4.8 Монголбанкнаас 2015 онд баталсан эрх зүйн баримт бичгүүд	60
5. АУДИТААР БАТАЛГААЖСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	63
6. СТАТИСТИКИЙН ХАВСРАЛТУУД	157


1.1 БОДИТ СЕКТОР

Эдийн засгийн бодит өсөлт


Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ий бодит өсөлт 2015 онд 2.3% болж, өсөлтийн хурдац нь 2014 оны гүйцэтгэлээс 5.6 нэгж хувиар саарсан үзүүлэлттэй гарлаа. Эдийн засгийн бодит өсөлтөд хөдөө аж ахуй, уул уурхайн салбарын үзүүлэх хувь нэмэр харьцангуй тогтвортой хадгалагдаж эерэг нөлөө үзүүлсэн бол улсын төсвийн нөлөөлөл буюу бүтээгдэхүүний цэвэр татварын бодит өөрчлөлт 2014 оны 02 дугаар улирлаас эхлэн сөрөг утгатай болж, энэхүү хандлага 2015 оны турш үргэлжилсэн нь ДНБ-ий бодит өсөлтийг бууруулах чиглэлд нөлөөтэй байв.

2015 оны эцсийн байдлаар ДНБ-ий 2.3%-ийн бодит өсөлтийг задаргаагаар нь 2010 оны зэрэгцүүлсэн үнээр авч үзвэл уул уурхайн салбар 2.9 нэгж хувийг, хөдөө аж ахуйн салбар 1.3 нэгж хувийг, үйлчилгээ 0.6 нэгж хувийг, тээвэр ба агуулахын салбар 0.4 нэгж хувийг, боловсруулах үйлдвэрлэлийн салбар 0.1 нэгж хувийг тус тус бүрдүүлсэн бол бүтээгдэхүүний цэвэр татвар -2.4 нэгж хувь, худалдааны салбар -0.5 нэгж хувь, барилгын салбар -0.1 нэгж хувиар бууруулах нөлөө үзүүлжээ (Зураг 1-2).

Зураг 1. ДНБ-ий бодит өсөлтөд үзүүлэх хувь нэмэр



Зураг 2. ДНБ-ийн бодит өсөлтийн задаргаа




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ-ий задаргаанаас харахад нийт хөрөнгө оруулалт 2014 онд эрс багасч, 2015 онд үргэлжлэн буурч байгаа нь эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлсөн байна. Харин эцсийн хэрэглээ харьцангуй тогтвортой түвшинд байж, 2009 оны эдийн засгийн хямралын үеийнх шиг агшиж буураагүй байна. Гадаад худалдааны тэнцэл 2015 онд 872 сая ам.долларын ашигтай гарснаар цэвэр экспорт ДНБ-ий бодит өсөлтөд голлох эерэг нөлөөг үзүүлсэн (Зураг 3-4).


2013 оноос эхлэн цэвэр экспорт ДНБ-ий өсөлтийг нэмэгдүүлэх чиглэлд эерэг, гэвч хөрөнгө оруулалт эдийн засгийн өсөлтийг бууруулах чиглэлд сөрөг нөлөөтэй байсаар байна. Харин өрхийн хэрэглээний ДНБ-д үзүүлэх хувь нэмэр 2014 оны 4 дүгээр улирлаас эхлэн тасралтгүй буурч, өсөлт нь саарсан хэвээр байна.

Зураг 3. ДНБ-ий бодит өсөлтийн задаргаа (эцсийн ашиглалтын аргаар)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо


Зураг 4. ДНБ-ий бодит өсөлтийн задаргаа (эцсийн ашиглалтын аргаар, улирлаар)



Эрдэс баялгийн бус сектор


Эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт 2015 онд -0.6 % болж буурсан нь өмнөх оны гүйцэтгэлээс 4.5 нэгж хувиар саарсан үзүүлэлт юм. Хэдийгээр эдийн засгийн бодит өсөлтөд эрдэс баялгийн бус секторын үзүүлэх хувь нэмэр сүүлийн 4 жил буурч байгаа боловч 2009 оны хямралын жилтэй харьцуулахад огцом буураагүй байна. Харин эдийн засгийн бодит өсөлтөд уул уурхайн салбарын эзлэх хувь сүүлийн жилүүдэд харьцангуй тогтвортой байж 2015 оны гүйцэтгэлээр өсөлт нь 2.9%-д хүрчээ (Зураг 5).

Зураг 5. Эрдэс баялгийн бус салбарын өсөлт



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Зураг 6. ДНБ-ий бодит өсөлтийн задаргаа (үйлдвэрлэлийн бүрэлдэхүүн салбаруудын өсөлт)



Эрдэс баялгийн бус салбарын өсөлтийн голлох хувийг хөдөө аж ахуйн салбарын 1.3 нэгж хувийн өсөлт бүрдүүлсэн. Харин өмнөх онуудад дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтөд голлох хувь нэмрийг оруулж байсан үйлчилгээний салбарын өсөлт 2015 онд 0.6 нэгж хувьд хүрч, өмнөх оноос өсөлт нь 1.5 нэгж хувиар саарсан байна. Тайлант онд бүтээгдэхүүний цэвэр татвар -2.4 нэгж хувиар, худалдааны салбар -0.5 нэгж хувь буурсан нь эрдэс баялгийн бус салбар буурахад голлох нөлөөг үзүүлжээ (Зураг 6). Уул уурхайн бус салбарын бодит өсөлт 2015 оны 02 дугаар улирлаас эхлэн сөрөг утгатай болсон.


Үйлдвэрлэлийн зөрүү

Нийт үйлдвэрлэлийн зөрүү (бодит ДНБ – потенциал ДНБ) 2015 оны 02 дугаар улирлаас эхлэн 4 улирал дараалан сөрөг утгатай байна. 2009 оны хямрал болон ОУВС-гийн хөтөлбөртэй байх үед нийт үйлдвэрлэлийн зөрүү 2008

оны 4 дүгээр улирлаас 2011 оны 1 дүгээр улирлыг дуустал буюу дараалсан 10 улирал сөрөг утгатай байв (Зураг 7).

Үйлдвэрлэлийн зөрүүг салбараар авч үзвэл хөдөө аж ахуй болон барилга угсралтын салбарт нейтраль, харин боловсруулах үйлдвэрлэл, худалдаа болон үйлчилгээний салбарт тус тус сөрөг утгатай байна. Энэ нь эдийн засгийн тэнцвэрийг хангасан орчинд эдгээр салбарын өсөлтийг дэмжих шаардлага байгааг харуулж байна (Зураг 8).


Зураг 7. Нийт үйлдвэрлэлийн зөрүү (2000-2015)




Эх суралж: Монголбанк

Зураг 8. Үйлдвэрлэлийн зөрүү (салбараар)


Хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэлийн зөрүү




Барилгын салбарын үйлдвэрлэлийн зөрүү



Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийн зөрүү



Худалдаа, үйлчилгээний салбарын үйлдвэрлэлийн зөрүү




Эх суралж: Монголбанк


Ажил эрхлэлт

Хөдөлмөрийн насны хүн амын тоо өмнөх оноос 3.0%-аар өсч, 2015 оны эцсийн байдлаар 1925.6 мянгад хүрсэн байна. Үүнээс эдийн засгийн идэвхтэй хүн ам буюу нийт ажиллах хүч 60.5%-ийг эзэлж байгаа бөгөөд ажиллах хүчний оролцооны түвшин¹ өмнөх оноос 0.2 нэгж хувиар нэмэгджээ (Зураг 9). Харин нийт ажиллагсдын тоо 2014 оноос 26.8 мянгаар өсч 1067.6 мянгад хүрсэн бол нийт ажилгүйчүүдийн тоо 9.4 мянгаар нэмэгдэж, ажилгүйдлийн түвшин 8.3%-д хүрсэн байна (Зураг 10).

Зураг 9. Ажиллах хүчний оролцооны түвшин



Зураг 10. Ажилгүйдлийн түвшин




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Нийт ажилчдын тоог эдийн засгийн гол салбаруудын ангиллаар авч үзвэл 2015 онд 334.9 мянга буюу 32.3% нь хөдөө аж ахуйн салбарт, 207.3 мянга буюу 20.0% нь аж үйлдвэрлэлд, 525.3 мянга буюу 50.6% нь үйлчилгээний салбарт тус тус ажиллаж байна (Зураг 11).


Нийт ажилчдыг хөдөлмөр эрхлэлтийн хэв шинжээр авч үзвэл 508.1 мянга буюу нийт ажилчдын 47.6% нь цалин хөлстэй ажилчид байгаа бол 12.3 мянга буюу 1.2% нь ажил олгогчид байна. Харин хувиараа хөдөлмөр эрхлэгчид 210.1 мянга буюу 19.7%, өрхийн үйлдвэрлэл үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч 22.8 мянга буюу 2.1% байгаа бол мал аж ахуй эрхлэгчид 313.7 мянга буюу нийт ажилчдын 29.4%-ийг бүрдүүлж байна (Зураг 12).

Цаашид 2016 оноос макро эдийн засгийн “шинэ тэнцвэр”-ийг бүрэн хангахгүй бол мөнгөний нийлүүлэлтийг хувийн хэвшлийн зээлээр нэмэгдүүлэх боломж хязгаарлагдмал хэвээр байх, агшилт бүхий эдийн засгийн салбарууд улам агших, ингэснээр ажилгүйдлийн түвшин өсөх эрсдэлтэй байна.

Зураг 11. Ажилчдын тоо (эдийн засгийн салбараар)



Зураг 12. Ажилчдын тоо (хөдөлмөр эрхлэлтийн хэв шинжээр)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо


¹ Ажиллах хүчний оролцооны түвшин нь эдийн засгийн идэвхтэй хүн амын нийт хөдөлмөрийн насны (15-с дээш) хүнд эзлэх хувийг илэрхийлнэ.

1.2 ГАДААД СЕКТОР

Төлбөрийн тэнцэл


Төлбөрийн тэнцлийн статистикийн 2015 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр урсгал данс 469 сая ам.долларын алдагдалтай, хөрөнгө ба санхүүгийн данс 382 сая ам.долларын ашигтай, статистикийн алдаа ба орхигдуулга -180.8 сая ам.доллар гарснаар нийт тэнцэл 268 сая ам.долларын алдагдалтай гарч, алдагдлын хэмжээ 2014 оноос 43%-аар буюу 203 сая ам.доллараар буурсан үзүүлэлттэй байна.

Зураг 13. Төлбөрийн тэнцлийн гүйцэтгэл



Эх сурвалж: Монголбанк


Зураг 14. Урсгал тэнцлийн бүтэц



Урсгал тэнцлийн алдагдал 2015 онд өмнөх оноос 67%-аар буюу 936 сая ам.доллараар буурсан бөгөөд үүнд барааны гадаад худалдааны ашиг 18%-аар буюу 184 сая ам.доллараар өсч, үйлчилгээний худалдааны алдагдал 45%-аар буюу 696 сая ам.доллараар буурсан нь голлох нөлөөг үзүүлсэн.


Урсгал тэнцлийн алдагдлын ДНБ-д эзлэх хувь 2011-2013 онд дунджаар 26% байсан бол 2014 онд 11%, 2015 онд 4% болж буураад байна.

Зураг 15. Хөрөнгө ба санхүүгийн тэнцлийн бүтэц



Эх сурвалж: Монголбанк

Зураг 16. Гадаадын шууд хөрөнгө оруулалтын бүтэц



Хөрөнгө ба санхүүгийн тэнцлийн ашиг 2015 онд өмнөх оноос 64%-аар буюу 680 сая ам.доллараар буурч 382 сая ам.долларт хүрсэн. Энэ нь зээлийн данс цэвэр дүнгээр 51%-аар буюу 361 сая ам.доллараар буурч 345 сая ам.доллар болсноор голлон тайлбарлагдаж байна.

Барааны гадаад худалдаа

Монгол Улсын барааны гадаад худалдааны тэнцэл 1990 оноос хойшхи хугацаанд 1994, 1995, 2006, 2014 болон 2015 онуудад ашигтай, бусад онд алдагдалтай гарч байв. Тайлант 2015 онд гадаад худалдааны тэнцэл 872 сая ам.долларын ашигтай байсан нь өнгөрсөн оноос 334 сая ам.доллараар сайжирсан үзүүлэлт юм.

Хүснэгт 1. Барааны гадаад худалдааны гүйцэтгэл (сая ам.доллар)

Төрөл	2013	2014	2015	Өөрчлөлт (15'/14')	
				Мөнгөн дүн	Хувь
Эргэлт	10,627	11,011	8,467	-2,545	-23%
Экспорт	4,269	5,775	4,669	-1,105	-19%
Импорт	6,358	5,237	3,797	-1,439	-27%
Тэнцэл	-2,089	538	872	334	

Эх сурвалж: Гааль, татварын ерөнхий газар


Үүнд импортын 27%-ийн бууралт нь экспортын 19%-ийн бууралтаас мөнгөн дүнгээр илүү байсантай холбоотой бөгөөд улмаар гадаад худалдааны нийт эргэлт 8,467 сая ам.долларт хүрч, өмнөх оноос 23%-аар буурсан байна.

Экспорт: 2015 онд экспорт 19%-аар буюу 1.1 тэрбум ам.доллараар буурсан нь чулуун нүүрс 294 сая, зэсийн баяжмал 293 сая, боловсруулаагүй нефть 247 сая, төмрийн хүдрийн экспорт 219 сая ам.доллараар тус тус буурсантай холбоотой байна. Хэдийгээр зэсийн баяжмал болон түүхий нефтийн экспортын биет хэмжээ өсөлттэй байсан ч, дэлхийн зах зээлд түүхий эдийн эрэлт болон үнэ буурсан нь экспортыг бууруулах нөлөө үзүүлжээ.

Алтны үнэ: АНУ-ын Холбооны нөөцийн банк мөнгөний тэлэх бодлогыг хумьж, бодлогын төлөвийг чангаруулах чиглэлд өөрчлөх төлөвтэй болсон нь ам.долларын ханш чангарахад нөлөөлж, алтанд хөрөнгө оруулалт хийх сонирхолыг бууруулах нөлөө үзүүлсэн ба Блүмберг агентлагийн шинжээчид БНХАУ, Энэтхэг улсын биет алтны эрэлт сүүлийн 2 жилийн турш буурсан нь алтны үнэд нөлөөлсөн гэж үзсэн. Улмаар алтны үнийн индекс 2015 онд 11%-аар буурсан.

Зэсийн үнэ: Дэлхийн зэсийн хэрэглээний 45-50 хувийг бүрдүүлдэг БНХАУ-ын эдийн засгийн өсөлт 2015 онд үргэлжлэн удааширнаас аж үйлдвэрлэл суларч, суурь металлын эрэлт буурсан. Түүнчлэн сүүлийн хэдэн жилд нийлүүлэлт тогтмол өндөр байснаас агуулахад хадгалагдаж буй нөөц хангалттай байгаа нь зэсийн үнэд сөргөөр нөлөөлсөн байна. Дээрх хүчин зүйлсээс шалтгаалан Лондонгийн металлын бирж дэх цэвэршүүлсэн зэсийн үнэ өмнөх оноос 28%-аар буурчээ.

Зураг 17. Дэлхийн зах зээл дэх түүхий эдийн үнийн индекс (2010/12=1.0)



Эх сурвалж: Блүмберг

Коксжих нүүрсний үнэ: БНХАУ-д хийгдэж буй эдийн засгийн бүтцийн өөрчлөлттэй холбоотойгоор тус улсын хөрөнгө оруулалтын хэмжээ буурсан нь гангийн үйлдвэрлэл буурах, улмаар түүний эрэлтээр тодорхойлогдох коксжих нүүрсний эрэлт буурахад нөлөөлсөн. Түүнчлэн хүлэмжийн хийн ялгаралыг бууруулах, агаарын бохирдолттой тэмцэх зорилгоор эрчим хүчний нүүрсний хэрэглээг бууруулж байгаа зэргээс шалтгаалан Монгол Улсаас нийлүүлж буй бүх төрлийн нүүрсний хилийн үнийн индекс 2015 оны эцэст өмнөх оноос 15%-аар буурлаа.

Төмрийн хүдрийн үнэ: Дэлхийн эдийн засгийн өсөлт удааширч, аж үйлдвэрлэлийн өсөлт сулрах хандлага үргэлжилж буй сөрөг орчинд төмрийн хүдрийн үнэ 2015 онд 40%-аар буураад байна.

Түүхий нефтийн үнэ: Боловсруулаагүй нефтийн үнийн индекс 2015 онд 39%-аар буурсан нь нефтийн эрэлт 1.7 хувиар өсч сүүлийн таван жилийн хамгийн өндөр өсөлтийг үзүүлсэн² хэдий ч ОПЕК-ийн орнууд болон ОХУ нийлүүлэлтээ нэмэгдүүлсэн, Ираны эсрэг тавигдсан хориг цуцлагдсанаар нийлүүлэлт нэмэгдэх төлөвтэй байгаатай холбоотой байв.

² IMF "World economic outlook" October 2015

Хүснэгт 2. Экспорт, голлох ангиллаар (сая ам.доллар)

Төрөл	2014			2015			Өөрчлөлт	
	Тоо хэмжээ (мян. нэгж)	Дүн	%	Тоо хэмжээ (мян. нэгж)	Дүн	%	Дүн	Өсөлт
1. Уул уурхай		5,184	90%		4,092	88%	(1,092)	-21%
1.1. Зэсийн хүдэр, баяжмал	1,378	2,574	45%	1,478	2,280	49%	(293)	-11%
1.2. Чулуун нүүрс	19,480	849	15%	14,426	555	12%	(294)	-35%
1.3. Боловсруулсан нефть	6,885	635	11%	8,135	387	8%	(247)	-39%
1.4. Төмрийн хүдэр, баяжмал	6,324	446	8%	5,065	227	5%	(219)	-49%
1.5 Мөнгөжөөгүй алт /кг/	10,041	405	7%	11,343	421	9%	15	4%
1.6. Цайрын хүдэр, баяжмал	99	113	2%	84	102	2%	(12)	-10%
1.7. Жонш, лейцит, нефелинт	314	72	1%	280	65	1%	(6)	-8%
1.8. Молибдений хүдэр, баяжмал	4	36	1%	5	29	1%	(6)	-17%
1.9. Гянтболдын хүдэр, баяжмал	2	20	0%	2	14	0%	(6)	-30%
1.10. Мөнгө /тонн/	42	33	1%	54	10	0%	(22)	-68%
1.11. Бусад	18	3	0%	53	2	0%	(1)	
2. Мал аж ахуй		361	6%		329	7%	(32)	-9%
2.1. Амьд мал, малын мах	3	7	0%	5	14	0%	6	88%
2.2. Арьс, шир	298	36	1%	340	33	1%	(3)	-8%
2.3. Малын өлөн гэдэс	0	8	0%	0	9	0%	1	10%
2.4. Ноолуур	7	294	5%	7	252	5%	(42)	-14%
2.5. Ноос, бусад үс хялгас	9	15	0%	14	21	0%	6	36%
2.6. Бусад	0	0	0%	0	1	0%	0	140%
3. Газар тариалан		29	0%		27	1%	(2)	-5%
3.1. Үр тариа, рапс	85	27	0%	67	25	1%	(3)	-9%
3.2. Жимс, самар, хүнсний ногоо	5	1	0%	1	1	0%	0	55%
3.3. Бусад	0	0	0%	9	1	0%	1	157%
4. Аж үйлдвэрлэл		199	3%		218	5%	19	10%
4.1. Хүнс	1	6	0%	4	26	1%	20	357%
4.2. Ноолууран эдлэл	1	24	0%	1	25	1%	1	4%
4.3. Бусад хувцас, гутал, эдлэл	1	8	0%	1	10	0%	2	x5
4.4. Уул уурхай	20	58	1%	35	78	2%	21	36%
4.5. Цахилгаан, электрон бараа	0	4	0%	0	4	0%	(0)	-6%
4.6. Машин механик, тоног төхөөрөмж, эд анги	2	92	2%	1	69	1%	(23)	x3
4.7. Бусад	192	8	0%	185	6	0%	(2)	-21%
5. Бусад		2	0%		2	0%	(0)	-5%
5.1. Эрчим хүч	0	1	0%	0	1	0%	0	43%
5.2. Хог хаягдал	1	2	0%	1	2	0%	(0)	-18%
Нийт дүн		5,775			4,669		(1,106)	-19%

Эх сурвалж: Гааль, татварын ерөнхий газар, Монголбанк

Импорт: 2015 онд импорт 27%-аар буюу 1.4 тэрбум ам.доллараар буурахад дараах хүчин зүйлс голлон нөлөөлөв. Үүнд:

- Хэрэглээний барааны импорт 278 сая ам.доллараар буюу 16%-аар буурсан, үүнээс түргэн эдэлгээтэй бараа 16%-аар, удаан эдэлгээтэй бараа 25%-аар тус тус буурчээ. Түргэн эдэлгээтэй барааны хувьд хүнсний импортын бууралт 87 сая ам.доллар байсан нь голлох хувийг эзэлж байгаа бөгөөд энэ өөрчлөлтийн 50 сая ам.доллар нь үнийн өөрчлөлтөөс, 37 сая ам.доллар нь биет хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалсан байна. Удаан эдэлгээтэй бараанаас авто машин, түүний сэлбэг хэрэгслийн импорт 94 сая ам.доллараар буурчээ;
- Монгол Улсад орох хөрөнгө оруулалтын хэмжээний бууралт, мөн уул уурхайн салбарын удаашралтай холбоотойгоор машин, механик тоног төхөөрөмж, эд ангийн импорт 33%-аар буурсан бол дотоодын барилгын материалын үйлдвэрлэл нэмэгдсэнээс шалтгаалан барилгын материалын импорт 38%-аар тус тус

буурснаар хөрөнгө оруулалтаар санхүүжигддэг бүтээгдэхүүний импорт 31%-аар буюу 654 сая ам.доллараар буурчээ;

- Нефтийн бүтээгдэхүүний импорт 447 сая ам.доллараар буурсан нь дэлхийн зах зээл дээрх нефтийн бүтээгдэхүүний үнэ буурсан, уул уурхайн салбарын үйлдвэрлэл буурсантай уялдан тус салбарт ашиглагдах нефтийн бүтээгдэхүүний хэрэглээ багассантай холбоотой байна.

Хүснэгт 3. Импорт, голлох ангиллаар (сая ам.доллар)

Төрөл	2014		2015		Өөрчлөлт	
	Дүн	Нийт импортод эзлэх хувь	Дүн	Нийт импортод эзлэх хувь	Дүн	Хувь
Хэрэглээний бүтээгдэхүүн	1,379	26%	1,101	29%	(278)	-20%
Түргэн эдэлгээтэй	764	15%	643	17%	(121)	-16%
Хүнс	531	10%	445	12%	(87)	-16%
Тамхи	57	1%	59	2%	2	4%
Сахар, какао, шоколад	111	2%	85	2%	(26)	-23%
Согтууруулах болон согт.биш ундаа	54	1%	39	1%	(15)	-28%
Гурил, будаа, гурилан бүтээгдэхүүн	75	1%	67	2%	(8)	-10%
Хүнсний ногоо, жимс, жимсгэнэ	53	1%	47	1%	(6)	-11%
Сүү, сүүн бүтээгдэхүүн	34	1%	20	1%	(13)	-40%
Төрөл бүрийн өөх тос	31	1%	27	1%	(4)	-14%
Мах, махан бүтээгдэхүүн	26	0%	19	1%	(6)	-24%
Бусад хүнсний бүтээгдэхүүн	91	2%	81	2%	(11)	-12%
Эм, тариа	82	2%	75	2%	(7)	-8%
Бусад түргэн эдэлгээтэй бараа	151	3%	123	3%	(27)	-18%
Удаан эдэлгээтэй	615	12%	459	12%	(157)	-25%
Гутал, хувцас, цүнх	58	1%	49	1%	(9)	-15%
Гэр ахуйн цах.хэрэгсэл ба тавилга	137	3%	94	2%	(43)	-32%
Авто машин, түүний сэлбэг хэрэгсэл	348	7%	254	7%	(94)	-27%
Бусад удаан эдэлгээтэй бараа	73	1%	62	2%	(11)	-15%
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн	2,098	40%	1,443	38%	(654)	-31%
Машин, механик тоног төхөөрөмж, эд анги	1,114	21%	749	20%	(364)	-33%
Суудлаас бусад тээврийн хэрэгсэл, эд анги	281	5%	113	3%	(169)	-60%
Машин механик, тоног төхөөрөмж, эд анги	832	16%	637	17%	(196)	-23%
Барилгын материал	756	14%	473	12%	(284)	-38%
Төмөр, ган, метал эдлэл	357	7%	204	5%	(154)	-43%
Хуванцар эдлэл	49	1%	33	1%	(16)	-34%
Цемент, тоосго, барилгын чулуун эдлэл	128	2%	71	2%	(57)	-45%
Мод, модон эдлэл	67	1%	52	1%	(15)	-23%
Керамик эдлэл	10	0%	10	0%	0	2%
Бусад барилгын материалууд	144	3%	103	3%	(41)	-29%
Хөрөнгө оруулалтын бусад бараа	228	4%	222	6%	(6)	-3%
Аж үйлдвэрлэлийн орц	592	11%	516	14%	(76)	-13%
Хүнсний орц	32	1%	28	1%	(4)	-12%
Химийн бүтээгдэхүүн	93	2%	89	2%	(4)	-4%
Даавуу, утас, арьс, савхин эдлэл	17	0%	16	0%	(0)	-3%
Цахилгаан эрчим хүч	130	2%	129	3%	(1)	-1%
Металлын хүдэр, баяжмал болон хаягдал	0	0%	1	0%	1	212%
Бусад аж үйлдвэрлэлийн зориулалтат	320	6%	252	7%	(68)	-21%
Нефтийн бүтээгдэхүүн	1,155	22%	707	19%	(447)	-39%
Дизель түнш	656	13%	377	10%	(280)	-43%
АИ-92, АИ-95	320	6%	228	6%	(92)	-29%
А-80 болон бусад	178	3%	103	3%	(76)	-42%
Бусад	14	0%	29	1%	16	116%
Нийт дүн	5,237		3,797		(1,439)	-27%

Эх сурвалж: Гааль, татварын ерөнхий газар, Монголбанк

Үйлчилгээний гадаад худалдаа

Үйлчилгээний гадаад худалдааны алдагдал 2015 онд өмнөх оноос 45%-аар буурч 857 сая ам.долларт хүрсэн.

Барааны импорт буурсантай уялдан тээврийн үйлчилгээний алдагдал өмнөх онтой харьцуулахад 45%-аар буурч -250 сая ам.доллар, аялал жуулчлалын үйлчилгээний алдагдал 48%-аар буурч 171 сая ам.доллар, бизнесийн удирдлагын зөвлөх үйлчилгээний алдагдал 64%-аар буурч -103 сая ам.доллар болсон нь үйлчилгээний алдагдал буурахад нөлөөлсөн гол хүчин зүйлс байв.

Хүснэгт 4. Үйлчилгээний гадаад худалдаа (сая ам.доллар)

Үйлчилгээний гадаад худалдааны дансны нэр төрөл	2013	2014	2015	Өөрчлөлт (15'/14')	
				Дүн	%
1. Тээвэр	-683	-458	-250	-208	-45%
2. Аялал жуулчлал	-210	-328	-171	-157	-48%
3. Харилцаа холбоо	-69	-75	-45	-29	-39%
4. Барилга	-169	-69	-66	-3	-5%
5. Даатгал	-55	-31	-38	7	22%
6. Санхүүгийн үйлчилгээ	-30	-99	-52	-47	-47%
7. Компьютер, мэдээлэл	-28	-26	-26	0	2%
8. Патент, тэмдэгт, лицензийн хураамж	-13	-11	-13	2	23%
9. Хуулийн зөвлөгөө, төлөөлөл	-8	-8	-17	9	117%
10. Нягтлан бодох бүртгэл, аудитын	-18	-7	-7	0	4%
11. Бизнесийн удирдлагын зөвлөх	-31	-284	-103	-181	-64%
12. Архитектур, инженер, техникийн	-9	-144	-78	-66	-46%
13. Бусад үйлчилгээ	9	-13	10	-23	-174%
Нийт үйлчилгээ	-1314	-1553	-857	-696	-45%

Эх сурвалж: Монголбанк

Гадаад хөрөнгө оруулалтын позиц

Монгол Улсын гадаад хөрөнгө оруулалтын позиц 2015 оны эцэст -24,645 сая ам.долларын үлдэгдэлтэй байна. Монгол Улсаас гадагш хийсэн нийт хөрөнгө оруулалтын дүн буюу гадаад актив 3,218 сая ам.доллар, үүний 41%-ийг гадаад валютын улсын нөөц, 40%-ийг бусад хөрөнгө оруулалтын актив, 12%-ийг шууд хөрөнгө оруулалт, 7%-ийг багцын хөрөнгө оруулалт бүрдүүлж байна.

Монгол Улсад оруулсан нийт хөрөнгө оруулалтын дүн 27,863 сая ам.доллар, үүний 60%-ийг гадаадын шууд хөрөнгө оруулалт, 29%-ийг бусад хөрөнгө оруулалтын пассив, 11%-ийг багцын хөрөнгө оруулалт тус тус бүрдүүлж байна. Гадаадын шууд хөрөнгө оруулалтын 36% буюу 6,063 сая ам.долларыг хувь нийлүүлэгчийн дүрмийн сан дахь хөрөнгө оруулалт, 64% буюу 10,690 сая ам.долларыг охин компанийн толгой компаниасаа авсан зээл буюу компани хоорондын өглөг, санхүүжилт эзэлж байна.

Хүснэгт 5. Монгол Улсын гадаад хөрөнгө оруулалтын позиц, 2015 оны эцэст (сая ам.доллар)

А. ГАДААД АКТИВ		3,218	Б. ГАДААД ПАССИВ		27,863
1. Шууд хөрөнгө оруулалт (гадаад руу)	377		1. Шууд хөрөнгө оруулалт (гадаадаас)		16,753
2. Багцын хөрөнгө оруулалт	227		2. Багцын хөрөнгө оруулалт		2,956
3. Санхүүгийн дериватив	8		3. Санхүүгийн дериватив		13
4. Бусад хөрөнгө оруулалт	1,283		4. Бусад хөрөнгө оруулалт		8,142
5. Нөөц актив	1,323				
			В. ПОЗИЦ		-24,645

Эх сурвалж: Монголбанк

Гадаад хөрөнгө оруулалтын позиц 2015 онд өмнөх онтой харьцуулахад 4%-аар буюу 956 сая ам.доллараар нэмэгдсэн байна. Үүнд дараах хүчин зүйлс голлон нөлөөлжээ:

- Гадаад актив 6%-аар буюу 219 сая ам.доллараар буурч, гадаад пассив 3%-аар буюу 736 сая ам.доллараар нэмэгдсэн;
- Гадаадын шууд хөрөнгө оруулалтын богино позиц 37 сая, бусад хөрөнгө оруулалтын богино позиц 495 сая, багцын хөрөнгө оруулалтын богино позиц 95 сая ам.доллараар өссөн;
- Гадаад валютын улсын нөөц 20%-аар буюу 327 сая ам.доллараар буурсан.

Хүснэгт 6. Гадаад хөрөнгө оруулалтын позицын өөрчлөлт (сая ам.доллар)

Үзүүлэлтүүд	2013	2014	2015	Өөрчлөлт (15'/14')	
				Дүн	%
ГШХО-ын позиц	-15,471	-16,338	-16,375	37	0%
Багцын ХО-ын позиц	-2,083	-2,633	-2,728	95	4%
Санхүүгийн үүсмэл хэрэгслийн позиц	0	-3	-5	-2	
Бусад ХО-ын позиц	-5,134	-6,365	-6,860	495	8%
ГВУН-ын үлдэгдэл	2,248	1,650	1,323	-327	-20%
Нийт позиц	-20,440	-23,689	-24,645	956	4%

Эх сурвалж: Монголбанк

Гадаад өр

Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл³ 2015 оны эцэст 21,829 сая ам.доллар болж, өмнөх оноос 4%-аар буюу 887 сая ам.доллараар өсөв. Нөлөөлсөн хүчин зүйлс нь:

- Банкуудын гадаадын банк, санхүүгийн байгууллагаас урт хугацаат зээл авснаар хадгаламжийн байгууллагын гадаад өр 26%-аар буюу 416 сая ам.доллараар өссөн;
- Үндэсний мөнгөн тэмдэгтийг харилцан солилцох своп хэлцэл болон бусад хүчин зүйлсийн нөлөөгөөр Төв банкны гадаад өглөг 392 сая ам.доллараар нэмэгдсэн;
- Компани хоорондын зээллэг буюу охин компани нь толгой компаниасаа авсан хөрөнгө оруулалт 61 сая ам.доллараар буюу 1%-аар өссөн байна.

Хүснэгт 7. Монгол Улсын нийт гадаад өр (сая ам.доллар)

Үзүүлэлт	2013	2014	2015	Өөрчлөлт (15'/14')	
				Дүн	%
Нийт гадаад өр	19,022	20,942	21,829	887	4%
I. Засгийн газар	3,684	3,610	3,648	38	1%
Засгийн газрын гадаад өр/ДНБ (%)	0%	0%	31%	31%	
II. Төв банк	1,065	1,568	1,960	392	25%
III. Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)	1,298	1,629	2,045	416	26%
Богино хугацаат	200	315	331	16	5%
Урт хугацаат	1,098	1,314	1,714	400	30%
IV. Бусад сектор	2,633	3,522	3,501	-21	-1%
Богино хугацаат	406	562	409	-153	-27%
Урт хугацаат	2,228	2,960	3,093	133	4%
V. Хөрөнгө оруулагчаас авсан зээл (Компани хоорондын зээллэг)	10,341	10,615	10,676	61	1%

Эх сурвалж: ЗГ-ын мэдээллийг Сангийн яам, бусад мэдээллийг Монголбанк боловсруулав.

Харин хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагууд гадаад зээлийн эргэн төлөлтөөс шалтгаалан бусад секторын гадаад өр 2015 онд өмнөх оноос 1%-аар буюу 21 сая ам.доллараар буурсан байна.

Засгийн газрын гадаад өрийн ДНБ-д эзлэх хувь хэмжээ 2013-2015 онуудад 29%-31% хооронд тогтвортой түвшинд байна (олон улсын аргачлалын дагуу Хөгжлийн банкны гадаад өрийг бусад сектор хэсэгт ангилсан).

³ Засгийн газар, хувийн хэвшил, бусад сектор бүгд


1.3 МӨНГӨ, САНХҮҮГИЙН СЕКТОР

Инфляци


Монголбанкны үндсэн зорилт нь үнийн тогтвортой байдлыг хангах буюу инфляцийг нам тогтвортой түвшинд байлгах явдал билээ. Төрөөс мөнгөний бодлогын талаар 2015 онд баримтлах үндсэн чиглэлд инфляцийн дунд хугацааны зорилтыг 7 хувь гэж тодорхойлсон. Тайлант онд хэрэглээний үнийн индексээр хэмжсэн жилийн инфляци улсын хэмжээнд 1.9 хувь, Улаанбаатар хотын хэмжээнд 1.1 хувь гарлаа. Үүнийг 2014 оны эцсийн түвшинтэй харьцуулан үзвэл харгалзан 9.1, 9.6 нэгж хувиар буурсан үзүүлэлт юм. Ийнхүү инфляцийн түвшин 2015 оны эцэст зорилтот түвшнээс доогуур, нам түвшинд хүрэхэд дараах хүчин зүйлс голлон нөлөөлсөн: (1) Эдийн засгийн гадаад тэнцвэрийг дэмжих зорилгоор мөнгөний бодлогын хүүг 2014 оны 7 сард 1.5 нэгж хувиар, 2015 оны 1 дүгээр сард 1 нэгж хувиар нэмэгдүүлж 13% болгосон бөгөөд 2015 оны туршид мөнгөний бодлогын хатуу төлөвийг хадгалсан нь дотоод эрэлт, хэрэглээ хумигдахад нөлөөлж, эрэлтээс шалтгаалах инфляцийн дарамт буурсан, (2) Нийлүүлэлтийн гаралтай инфляцийн дарамт 3 жилийн дотор арилсан, (3) Төлбөрийн тэнцэлд шаардлагатай бүтцийн тохиргоо хийгдэж валютын зах тогтворжихын хэрээр төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн инфляци дахь сөрөг нөлөөлөл буурсан зэрэг болно.

Өндөр хэлбэлзэлтэй бараа, бүтээгдэхүүнийг хэрэглээний сагснаас хасч тооцдог суурь индексийн жилийн өөрчлөлт 2015 оны эцэст 4.8 хувь гарлаа. Суурь инфляци ийнхүү 2014 онтой харьцуулвал 7.9 нэгж хувиар буурсан ба сүүлийн 1.5 жилийн хугацаанд тасралтгүй буурсаар байна. Суурь инфляцийн тооцоонд ордоггүй мах, сүү, хүнсний ногооны үнийн өөрчлөлт бага түвшинд байгаа нь суурь инфляци ерөнхий инфляциас өндөр байх шалтгаан болж байна. Түүнчлэн мах, сүү, хүнсний ногооны дундаж үнэ 2015 оны сүүлийн 5 сар дараалан буурсан нь суурь инфляци болон ерөнхий инфляцийн хоорондын зөрүү нэмэгдэхэд нөлөөлөв (Зураг 18).

Зураг 18. Улаанбаатар хотын сарын болон жилийн инфляци, суурь инфляци



Зураг 19. Улаанбаатар хотын жилийн инфляцийн задаргаа




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Улаанбаатар хотын 2015 оны жилийн инфляци (1.1%)-ийг бүтцээр нь задлан үзвэл мах, махан бүтээгдэхүүн -2.66, махнаас бусад хүнсний бүтээгдэхүүн 0.53, төрийн зохицуулалттай үйлчилгээ 1.45, бусад бараа, бүтээгдэхүүн 1.82 нэгж хувийг тус тус бүрдүүлж байна. Уг бүлгүүдийн үнийн өөрчлөлтийн жилийн инфляцид эзлэх хувь, хэмжээг 2014 онтой харьцуулбал тус бүр харгалзан 2.60, 1.67, 0.13 болон 5.08 нэгж хувиар буурчээ (Зураг 19).

Оны эцэст хүнсний үнийн өөрчлөлт жилийн инфляцид -2.13 нэгж хувийн нөлөө үзүүлсэн ба үүнийг 2014 онтой харьцуулан үзвэл 4.27 нэгж хувиар буурсан үзүүлэлт юм. Үүнд оны сүүлийн хагаст махны нийлүүлэлт их байснаас үнэ огцом буурсан нь голчлон нөлөөлсөн. Оны сүүлийн хагаст мах, махан бүтээгдэхүүний үнэ нийтдээ 36.2 хувиар буурсан бөгөөд тодруулбал, уг хугацаанд хонь ба үхрийн махны үнэ 2900-3500 төгрөгөөр хямдарчээ. Харин хүнсний бус бараа, бүтээгдэхүүний үнийн өөрчлөлт 2015 оны инфляцид 3.26 нэгж хувийн нөлөө үзүүлсэн нь 2014 оноос 5.28 нэгж хувиар бага байна. Үүний гол шалтгаалан нь суурь үеийн өндөр өсөлтийн нөлөөнөөс гадна дотоод эрэлт хумигдсантай холбоотой. Ирэх саруудад хүнсний үнэ улирлын чиг хандлагаа дагаад нэмэгдэхээр байгаа ч, жилийн инфляцийг бууруулах нөлөө нь үргэлжлэхээр байна. Харин хүнсний бус бараа, бүтээгдэхүүний

үнийн инфляцид үзүүлэх дарамт ирэх саруудад буурч, 01-03 дугаар улирлуудад инфляци үргэлжлэн буурах, харин 4 дүгээр улирлаас эргэн өсөх хандлагатай байна (Зураг 20).

Зураг 20. Хүнс ба хүнсний бус бүтээгдэхүүний инфляцид үзүүлэх нөлөө



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо


Мөнгө, зээлийн үзүүлэлтүүд

Мөнгөний нийлүүлэлтийн гадаад эх үүсвэрийн бүрэлдэхүүн хэсэг 2015 онд үргэлжлэн буурсантай зэрэгцэн дотоод эх үүсвэрийн өсөлт саарснаар M2 мөнгө өмнөх жилээс 5.5 хувиар буурлаа. Үүнтэй уялдан банкны салбарын зээлийн үлдэгдэл 2015 оны эцэст 6.5 хувиар багаслаа.

Мөнгөний нийлүүлэлтийг актив талаас авч үзвэл хөрөнгийн дотогшлох урсгал татарснаас банкны системийн гадаад цэвэр актив (ГЦА) үргэлжлэн багасч 2015 онд жилийн өмнөх түвшнээсээ 2.3 дахин буурсан. Гадаадын шууд хөрөнгө оруулалт ДНБ-ий 1 хувьд ч хүрэхгүй болж багассаныг даган эдийн засгийн дотоод идэвхжил саарч байгаа нь дотоод цэвэр актив (ДЦА)-ын жилийн өсөлт 2015 онд 44.7 хувиас 13.1 хувь болж буурахад нөлөөлж байна.

Эдийн засаг дахь мөнгөний нийлүүлэлт ийнхүү буурч байгаа нь нөгөө талаас банкны системийн эх үүсвэрүүд багассантай холбоотой. 2015 оны эцсийн байдлаар төгрөгийн хадгаламжаас бусад төрлийн харилцах, хадгаламж буурсан. Мөн хамгийн өндөр хөрвөх чадвартай мөнгө болох M1 мөнгө 2015 онд жилийн өмнөх түвшнээсээ буурсан хэвээр байгаа нь мөнгөний нийлүүлэлт хумигдахад нөлөөлж байна.


Зураг 21. M2 мөнгөний жилийн өсөлтийн бүрэлдэхүүн: актив, пассив



Эх сурвалж: Монголбанк

Мөнгөний нийлүүлэлтийг бүтцээр нь авч үзвэл сүүлийн жилүүдэд өсөлттэй байсан валютын харилцах, хадгаламжийн үлдэгдэл төгрөгийн ханш сулрахтай зэрэгцэн 2015 оны эцсийн байдлаар жилийн 14 хувиар буурсан. Актив талаас нь авч үзвэл дотоод цэвэр актив (ДЦА)-ын M2 мөнгөний нийлүүлэлтэд эзлэх хувь нэмэгдсээр 2015 оны эцсийн байдлаар M2 мөнгөний 140.5 хувийг бүрдүүлж байгаа бол гадаад цэвэр актив (ГЦА) үргэлжлэн багассаар өмнөх оны эцсээс 2.3 дахин буураад байна.

Зураг 22. M2 мөнгөний нийлүүлэлтийн бүтэц: актив, пассив




Эх сурвалж: Монголбанк

Санхүүгийн байгууллагуудын⁴ зээлийн жилийн өсөлт сүүлийн 2 жил дараалан саарсаар 2015 оны эцэст 8 хувьд хүрсэн. Нийт санхүүгийн байгууллагуудын зээлийн үлдэгдэл 2015 оны эцэст 17.9 их наяд төгрөг байгаа ба үүний 61 хувийг банкуудын өөрийн эх үүсвэрийн зээл, 24 хувийг Хөгжлийн банк, 11 хувийг орон сууцны ипотекийн зээл эзэлж байна. Санхүүгийн байгууллагуудын зээлийн өсөлтийг орон сууцны ипотекийн зээл болон Хөгжлийн банкнаас олгож буй санхүүжилтүүд голчлон бүрдүүлсэн. Харин банкуудын өөрийн эх үүсвэрийн зээл 2015 оны эцэст нийт санхүүгийн байгууллагуудын зээлийг бууруулах нөлөө үзүүлж байна.


Банкуудын шинээр олгосон зээл 2015 оны эцэст жилийн 22 хувиар саарсан. Банкуудын шинээр зээл олголт ийнхүү хумигдаж байгаа нь нийт эрэлт буурсан, банкуудын эх үүсвэр багассан, эдийн засаг, бизнесийн идэвхжил саарсан, бизнесийн эрсдэл өндөр байгаа зэрэгтэй холбоотой. Өмнөх жилийн эцэстэй харьцуулахад уул уурхайгаас бусад салбаруудад шинээр олгосон зээл буурсан. Салбарууд дотроос барилга, үл хөдлөх хөрөнгийн салбарт олгосон зээл харгалзан жилийн 37, 43 хувиар буурсан нь банкуудын шинээр олгосон зээлийг 9 нэгж хувиар сааруулах нөлөө үзүүлжээ.

Зураг 23. Санхүүгийн байгууллагуудын зээлийн жилийн өсөлт, бүрэлдэхүүнээр



Эх сурвалж: Монголбанк

Зураг 24. Банкуудын шинээр олгосон зээлийн жилийн өсөлт, салбараар




Банкуудын шинээр олгосон зээл буурахын зэрэгцээ банкуудын чанаргүй зээл 2015 онд өмнөх жилээс 2 нэгж хувиар өсч 7 хувь, хугацаа хэтэрсэн зээл 5 нэгж хувиар өсч 7 хувь болжээ. Хугацаа хэтэрсэн зээлийн хэмжээ ихээр нэмэгдэж байгаа нь ирээдүйд чанаргүй зээл нэмэгдэж болзошгүйг илэрхийлж байна. Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийг эдийн засгийн салбараар нь ангилбал уул уурхайн салбарт олгосон зээл дийлэнхийг эзэлж байна.

Банкуудын валютаар олгосон зээлийн чанар нийт төгрөгийн зээлтэй харьцуулахад 2015 онд илүү муудсан байна. Валютын хугацаа хэтэрсэн зээл 2014 оны эцэстэй харьцуулахад хурдацтай нэмэгдэж 7 дахин өссөн бол валютын чанаргүй зээлийн эзлэх хувь өсч 12 хувьд хүрсэн байна.

⁴ Санхүүгийн байгууллагууд нь банк, хадгаламж, зээлийн хориоо, МИК, Хөгжлийн банк болон банк бус санхүүгийн байгууллагуудаас бүрддэг.

Зураг 25. Банкуудын чанаргүй болон хугацаа хэтэрсэн зээл, салбарын нийт зээлд эзлэх хувиар



Эх сурвалж: Монголбанк

Санхүүгийн салбар

Монгол Улсын санхүүгийн салбарт банкны салбарын эзлэх хувь өндөр хэвээр байна. Улс орнуудын санхүүгийн салбарыг бүтцээр нь авч үзвэл банк эсвэл хөрөнгийн зах зээл төвлөрсөн байдаг бөгөөд банк, банк бус санхүүгийн байгууллага, даатгал, хадгаламж зээлийн хоршоо, үнэт цаасны мэргэжлийн оролцогч компаниудын нийт актив, тайлант хугацааны ашиг, өөрийн хөрөнгө зэрэг олон үзүүлэлтийг ашиглан энэхүү бүтцийг тодорхойлдог. Манай улсын хувьд санхүүгийн салбарын бүтцийг сүүлийн 2 жилийн тоон мэдээлэлд үндэслэн дээрх үзүүлэлтээр тодорхойлбол банкны салбар нь 2015 оны эцсийн байдлаар санхүүгийн салбарын нийт активын 95.7 хувь, нийт ашгийн 79.9 хувь, нийт өөрийн хөрөнгийн 80.1 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 8. Санхүүгийн салбарын бүтэц (тэрбум төгрөг)

	Актив		Ашиг		Өөрийн хөрөнгө	
	Дүн	Эзлэх хувь	Дүн	Эзлэх хувь	Дүн	Эзлэх хувь
2015 он						
Банк	21,521	95.7%	218	79.9%	2,427	80.1%
ББСБ	623	2.8%	46	17.0%	424	14.0%
Даатгал	173	0.8%	7.1	2.6%	94	3.1%
ХЗХ	98	0.4%	2.2	0.8%	21	0.7%
Үнэт цаасны оролцогч	68	0.3%	-0.7	-0.3%	62	2.0%
2014 он						
Банк	22,582	96.6%	326	88.5%	2,134	81.7%
ББСБ	508	2.2%	36	9.9%	332	12.7%
Даатгал	153	0.7%	2.2	0.6%	75	2.9%
ХЗХ	81	0.3%	4.0	1.1%	19	0.7%
Үнэт цаасны оролцогч	56	0.2%	-0.2	-0.1%	53	2.0%

Эх сурвалж: Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо

Банкны салбарын зуучлалын түвшин хөгжингүй болон бүрэлдэж буй эдийн засагтай орнуудын дунджаас өндөр байна. Хөгжингүй болон бүрэлдэж буй эдийн засагтай орнуудын санхүүгийн зах зээлийн бүтцийг санхүүжилтийн эх үүсвэрийн харьцаагаар⁵ тооцож үзэхэд санхүүгийн зах зээл дэх банкны салбарын оролцоо 20-80 хувь орчимд хэлбэлздэг байна. Хөрөнгийн зах зээл хөгжсөн АНУ-ын хувьд энэ үзүүлэлт 20 орчим хувьтай


⁵ Банкны салбарын санхүүжилтийг банкны салбарын санхүүжилт дээр хувицаа, бондын зах зээлийн үнэлгээг нэмж харьцуулсан харьцаа. Уг харьцаа өндөр байх тусам тухайн улсын санхүүгийн зах зээл банк төвтэй, бага байх тусам хөрөнгийн зах зээл төвтэй болохыг илэрхийлнэ.

Зураг 26. Банкуудын валютын чанаргүй болон хугацаа хэтэрсэн зээл, валютын зээлд эзлэх хувиар



байдаг бол Австри, Унгар, Шинэ Зеланд зэрэг улсуудад энэхүү харьцаа 80 орчим хувь буюу банкны санхүүжилт давамгайлдаг байна. Харин Монгол Улсын хувьд дээрх үзүүлэлтийг бондын зах зээлийн үнэлгээг оруулалгүйгээр тооцоход дунджаар 83 хувьтай байгаа нь мөн санхүүгийн секторт банкны салбар давамгайлж буйг илтгэнэ.

Зураг 27. Банкны салбарын зээлийн нийт санхүүжилтийн эх үүсвэрт эзлэх хувь*



Эх сурвалж: BIS (2014), “Financial structure and growth”.

Тэмдэглэл: *Нийт санхүүжилтийн эх үүсвэрийг банкны салбарын зээл, хувьцаа болон бондын зах зээлийн үнэлгээ (Market Capitalization)-ний нийлбэрээр авсан. AR-Аргентин, AT-Австри, AU-Австрали, BE-Бельги, BR-Бразил, CA-Канад, CH-Швейцарь, CL-Чили, CN-Хятад, CO-Колумб, DE-Герман, DK-Дани, EG-Египет, ES-Испани, FI-Финлянд, FR-Франц, GB-Англи, HK-Хонконг, HU-Унгар, ID-Индонез, IE-Ирланд, IS-Израйл, IN-Энэтхэг, IT-Итали, JP-Япон, KR-Солонгос, MX-Мексик, MY-Малайз, MN-Монгол, NL-Нидерланд, NO-Норвеги, NZ-Шинэ Зеланд, PE-Перу, PL-Польш, RU-Орос, SA-Саудын Араб, SE-Швед, SG-Сингапур, TH-Тайланд, TR-Турк, US-АНУ, ZA-Өмнөд Африк.

Технологийн дэвшил, олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтын харилцан хамаарал зэрэг олон хүчин зүйлсээс шалтгаалан сүүлийн 20 жилийн хугацаанд олон улсын санхүүгийн зах зээлийн бүтэц ихээхэн хувьсан өөрчлөгдсөн бөгөөд ялангуяа бүрэлдэж буй эдийн засагтай орнуудын хөрөнгийн зах зээлийн эдийн засагт гүйцэтгэх үүрэг сүүлийн жилүүдэд ихээр нэмэгдэж байна. Харин хөгжингүй улс орнуудын хувьд сүүлийн 20 жилийн хугацаанд энэхүү үзүүлэлт харьцангуй тогтвортой байна.


Санхүүгийн салбарт ийнхүү банкны системд давамгайлж байгаа нь санхүүгийн салбарын бүтцийг тодорхойлох суурь шалтгаантай холбоотой байна. Өндөр хөгжилтэй орнуудын санхүүгийн зах зээл нь банкны салбараас харьцангуй хамаарал багатай, хөрөнгийн зах зээл төвтэй байх нийтлэг зүй тогтол ажиглагддаг. Олон улсын төлбөр тооцооны банк (BIS)-ны судалгаагаар энэхүү бүтэц бүрэлдэхэд дараах үндсэн 4 суурь хүчин зүйлс нөлөөлдөг байна.

- *Иргэдийн санхүүгийн боловсрол*: иргэдийн санхүүгийн боловсрол өндөр байх нь хөрөнгийн зах зээлийн бүтээгдэхүүний хэрэгцээ шаардлагыг нэмэгдүүлж, хөгжлийнх нь үндэс суурь болдог;
- *Институцийн хөгжил*: өмчлөх эрхтэй холбоотой эрх зүйн орчин нь найдвартай, зохицуулалт сайтай байх нь хөрөнгийн зах зээлийн хөгжлийг дэмждэг;
- *Мэдлэгт суурилсан эдийн засгийн салбар*: хөгжингүй орнуудад уг салбар өндөр түвшинд хөгжсөн байдаг. Энэ салбарын онцлог нь биет хөрөнгөөс илүүтэйгээр хүмүүн капиталын нөөцийг ашигладаг ба банкнаас зээл авахад үйл ажиллагаанд нь биет хөрөнгө түлхүү шаарддаг бусад салбартай харьцуулахад барьцаа хөрөнгө муутай байдаг. Иймд мэдлэгт суурилсан салбарын хувьд хөрөнгийн зах зээлээс санхүүжилт босгох нь илүү хялбар, зардал багатай арга юм;
- *Компаниудын хэмжээ*: компаниудын хэмжээ болон санхүүгийн систем дэх банкны салбарын давамгайл байдал нь хоорондоо сөрөг хамааралтай байдаг. Учир нь жижиг компаниудад хөрөнгийн зах зээлд хувьцаагаа санал болгох нь харьцангуй зардал өндөртэй байдаг тул банкны зээлээс хамаарал өндөр байдаг байна.⁶

⁶ BIS (2014), “Financial structure and growth”.

Банкны салбарын гүнзгийрэлтийн үзүүлэлт зохистой байгаа хэдий ч, хөрөнгийн зах зээлийн гүнзгийрэлтийн үзүүлэлт олон улсын дунджаас доогуур байна. Олон улсын төлбөр тооцооны банк (BIS)-наас 2014 онд хийсэн судалгааны үр дүнгээс үзэхэд: банкуудын зээл, ДНБ-ий харьцаа 40 хувь хүртэл, хөрөнгийн зах зээлийн эргэлтийн харьцаа 95 хувь хүртэл өсөх нь эдийн засгийн өсөлтийг хурдасгах нөлөөтэй бөгөөд дээрх түвшингүүдээс давах нь эдийн засгийн өсөлтийн хурдцыг удаашруулах нөлөө үзүүлдэг байна.

Зураг 28. Монгол Улсын санхүүгийн салбарын гүнзгийрэлт




Эх сурвалж: Монголбанк, Монголын хөрөнгийн бирж.

Банкны салбарын төлөв байдал

Банкны салбарт тайлант оны эцсийн байдлаар нийт 14 банк, 1482 салбар нэгжтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Нийт хадгаламж эзэмшигчдийн тоо 2.8 саяд хүрч 2014 оны эцэстэй харьцуулахад 120.2 мянгаар нэмэгдсэн бол нийт зээлдэгчдийн тоо 846.0 мянгад хүрч 43.0 мянгаар нэмэгдлээ. Банкны салбарын нийт активын хэмжээ 2015 оны эцэст 20.8 их наяд төгрөгт хүрч өмнөх оны эцсээс 3.1 хувиар буюу 665.9 тэрбум төгрөгөөр буурлаа. Нийт активын 52.8 хувь нь зээл, 17.0 хувь нь мөнгөн хөрөнгө, 9.8 хувь нь богино хугацаат хөрөнгө оруулалт, 11.7 хувь нь урт хугацаат хөрөнгө оруулалт, үлдэх 8.8 хувь нь бусад төрлийн хөрөнгө байна.

Зураг 29. Банкны салбарын нийт актив хөрөнгийн бүтэц, жилийн өөрчлөлт



Эх сурвалж: Монголбанк

Активын өсөлт буурахад банкны салбарын зээлийн үлдэгдэл өмнөх оны эцсээс 792.9 тэрбум төгрөгөөр буурч 11.5 их наяд төгрөгт хүрсэн нь нөлөөлжээ. Банкуудын тогтвортой эх үүсвэр болох харилцах, хадгаламжийн хэмжээ төдийлөн өсөөгүйн зэрэгцээ гадаадын зах зээлээс эх үүсвэр татан төвлөрүүлэх нөхцөл сайжраагүй, эдийн засгийн голлох салбаруудад олгосон зээлийн чанар муудаж байгаа зэрэг нь зээл олголтыг буурууллаа.


Нийт зээлийн өрийн үлдэгдлийн 86.2 хувь буюу 10.0 их наяд төгрөгийн зээл хэвийн ангилалд, 7.4 хувь буюу 850.5 тэрбум төгрөгийн зээл хугацаа хэтэрсэн ангилалд, 5.5 хувь буюу 633.4 тэрбум төгрөгийн зээл чанаргүй ангилалд

Орон сууцны борлуулалт удааширсны улмаас зарим барилгын компаниудын үйл ажиллагаа доголдож эхэлсэн нь барилгын салбарт олгосон зээлийн эргэн төлөлтөд сөргөөр нөлөөлж байна. Барилгын салбарт олгосон нийт зээлийн 9.5 хувь нь хугацаа хэтэрсэн ангилалд ангилагдсан байгаа бөгөөд цаашид чанаргүй ангилалд шилжих эрсдэлтэй байна. Мөн бөөний болон жижиглэнгийн худалдаа, боловсруулах үйлдвэрлэлийн салбарт олгосон зээлийн чанар системийн дунджаас доогуур байна.


Харин нийт зээлийн багцын 40.9 хувийг бүрдүүлж буй иргэдэд олгосон хэрэглээний болон орон сууцны ипотекийн зээлийн эргэн төлөлт харьцангуй сайн буюу чанаргүй зээлийн хувь нь харгалзан 2.5, 0.6 хувьтай байна.

Банкны салбарын нийт эх үүсвэрийн хэмжээ тайлант оны эцэст 18.2 их наяд төгрөгт хүрч өмнөх оны эцсээс 5.2 хувиар буюу 556.2 тэрбум төгрөгөөр буурлаа. Эх үүсвэрийн өсөлтийн хувь өмнөх оноос 14.6 нэгж хувиар буурахад нэг талаас эдийн засагт орж ирэх гадаад валютын урсгал бүрэн сэргээгүй, гадаад активт мэдэгдэхүйц эерэг өөрчлөлт гараагүй, нөгөө талаас Монголбанкнаас өмнөх жилүүдэд хэрэгжүүлсэн орон сууцны ипотекийн болон бусад хөтөлбөрийн зээлүүд хуваарийн дагуу эргэн төлөлтөөрөө буурч, эдийн засгаас цэвэр дүнгээрээ төгрөгийн нийлүүлэлт багассаар байгаа нь нөлөөлж байна. Нийт эх үүсвэрийн 60.5 хувийг иргэд, аж ахуй нэгж, төрийн байгууллагуудаас татан төвлөрүүлсэн харилцах хадгаламж, 21 хувийг банк санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр, үлдэх 18.5 хувийг банкнаас гаргасан үнэт цаас, төслийн зээлийн санхүүжилт зэрэг бусад төрлийн эх үүсвэрүүд бүрдүүлж байна.

Зураг 33. Эх үүсвэрийн бүтэц (тэрбум төгрөг)



Зураг 34. Эх үүсвэрийн жилийн өсөлт




Эх сурвалж: Монголбанк


Банкны салбарын өөрийн хөрөнгө болон төлбөрийн чадварын үзүүлэлтүүд

Банкны системийн эрсдэл даах чадварыг тодорхойлдог өөрийн хөрөнгө тайлант онд 14.3 хувиар буюу 331.7 тэрбум төгрөгөөр нэмэгдэн 2.5 их наяд төгрөгт хүрлээ. Мөн банкны салбарын нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт 13.7 хувь, нийт өөрийн хөрөнгө хүрэлцээний үзүүлэлт 18.3 хувь байгаа нь Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтээс харгалзан 4.7, 6.3 нэгж хувиар өндөр байна.

Зураг 35. Банкны системийн өөрийн хөрөнгийн хүрэлцээ



Зураг 36. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа



Эх сурвалж: Монголбанк

Харин банкны салбарын нийт түргэн борлогдох активын хэмжээ 2015 оны эцэст 7.1 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 646.7 тэрбум төгрөгөөр буурсан боловч системийн төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа Монголбанкнаас тогтоосон доод хязгаарлалтаас 14.7 нэгжээр илүү буюу 39.7 хувь байна. Өөрөөр хэлбэл, банкны систем нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн 40 орчим хувийг харилцагчийн анхны шаардлагаар төлбөр, тооцоо хийхэд ашиглагдах хөрвөх чадвар өндөртэй актив, хөрөнгөд байршуулсан байна.

Гадаад валютын ханшийн савалгаанаас үүсч болох алдагдлыг банкны эрсдэл даах чадвартай нь уялдуулах зорилгоор тэдгээрийн гадаад валютын нээлттэй позиц, өөрийн хөрөнгийн харьцаанд нэг валютын хувьд +/-15 хувиас, нийт валютын хувьд +/-40 хувиас тус тус хэтрэхгүй байх зохистой харьцааг Монголбанкнаас мөрдүүлдэг бөгөөд тайлант оны эцэст эдгээр үзүүлэлтүүд харгалзан 2.0 хувь, -3.3 хувь байна.

1.4 УЛСЫН ТӨСӨВ

Засгийн газрын санхүү

Эдийн засгийн өсөлт саарч, бизнесийн идэвхжил удааширсантай холбоотойгоор 2015 оны нэгдсэн төсвийн орлого бүрдэлт хүндрэлтэй байлаа. Орлогын тасалдалтай холбоотойгоор 2015 онд 2 удаа тодотгол хийж төсвийн зардлыг бууруулсан. Монгол Улсын нийт тэнцвэржүүлсэн төсвийн орлого, тусламжийн дүн 2015 оны урьдчилсан гүйцэтгэлээр 5973.8 тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 7136.9 тэрбум төгрөг болж, төсвийн алдагдал 1163.1 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 5 хувьтай тэнцэх хэмжээнд гарав.

Төсвийн орлого

Нийт тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн дүн 5973.8 тэрбум төгрөг болж төлөвлөсөн хэмжээнээс (Тодотгол 2) 1.6 хувь буюу 100.6 тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 5.4 хувь буюу 340.4 тэрбум төгрөгөөр бага байлаа.

Төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн 86.1 хувийг татварын орлого, үлдсэн 13.9 хувийг татварын бус орлого бүрдүүллээ. Төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн өнгөрсөн оноос буурахад татварын бус орлого 288.5 тэрбум төгрөгөөр буурсан нь голлох нөлөөг үзүүлжээ. Татварын бус орлого 85.2 хувийн гүйцэтгэлтэй гарсан нь нийтлэг татварын бус орлого, тэр дундаа хувьцааны ногдол ашиг 12.1 хувийн гүйцэтгэлтэй буюу 86 тэрбум төгрөгөөр, хүүгийн орлого 77.7 хувийн гүйцэтгэлтэй буюу 41.5 тэрбум төгрөгөөр дутсантай холбоотой юм. Хэдийгээр нэмэгдсэн өртгийн албан татварын орлого 86.5 хувийн гүйцэтгэлтэй (161.5 тэрбум төгрөг дутсан) гарсан ч орлогын албан татвар, тэр дундаа аж ахуй нэгжийн орлогын албан татвар 180 тэрбум төгрөгөөр (134.7 хувийн гүйцэтгэлтэй), бусад татвар, төлбөр, хураамж 107.9 тэрбум төгрөгөөр (114 хувийн гүйцэтгэлтэй) давсан нь татварын орлого 100.9 хувийн гүйцэтгэлтэй гарах шалтгаан боллоо. Бусад татвар, төлбөр, хураамж төлөвлөгөөнөөс 107.9 тэрбум төгрөгөөр илүү гарахад ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөвлөгөөнөөс 12.7 хувь буюу 68.9 тэрбум төгрөгөөр илүү байсан нь чухал нөлөөг үзүүлжээ.

Төсвийн зарлага

Төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн төлөвлөсөн хэмжээнээс (Тодотгол 2) 116.2 тэрбум төгрөг буюу 1.6 хувиар бага, өмнөх оны мөн үеэс 7.6 тэрбум төгрөг буюу 0.1 хувиар буурч 7136.9 тэрбум төгрөг байв.

Урсгал зардал (нийт зарлага ба цэвэр зээлийн 80.6 хувь) өмнөх оны мөн үеэс 456.5 тэрбум төгрөг буюу 8.6 хувиар, эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл (нийт зарлага ба цэвэр зээлийн 0.7 хувь) 31 тэрбум төгрөг буюу 38.7 хувиар багассан бол хөрөнгийн зардал (нийт зарлага ба цэвэр зээлийн 18.7 хувь) 433.1 тэрбум төгрөг буюу 24.5 хувиар буурсан байна.

Урсгал зардлыг бүрэлдэхүүн хэсэг тус бүрээр нь авч үзвэл бараа, үйлчилгээний зардал (урсгал зардлын 49.1 хувь) өмнөх оны мөн үеэс 168.7 тэрбум төгрөг буюу 6.4 хувиар, зээлийн үйлчилгээний төлбөр (урсгал зардлын 12.7 хувь) 230.7 тэрбум төгрөг буюу 46.1 хувиар нэмэгдсэн бол татаас ба шилжүүлэг (урсгал зардлын 38.1 хувь) 57.1 тэрбум төгрөг буюу 2.7 хувиар буурчээ.

Алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр

Тайлант хугацаанд гадаад зээлийн үндсэн төлбөрт 121.1 тэрбум, дотоод зээлийн үндсэн төлбөрт 5.3 тэрбум, Засгийн газрын богино хугацаат дотоод бондын үндсэн төлбөрт 1,077.9 тэрбум, урт хугацаат дотоод бондын үндсэн төлбөрт 992.3 тэрбум төгрөгийг тус тус төлж, 294.6 тэрбум төгрөгийн гадаад төслийн, 199.3 тэрбум төгрөгийн гадаад хөтөлбөрийн зээл тус тус авч, Засгийн газрын 1,077.6 тэрбум төгрөгийн богино хугацаат дотоод, 314.4 тэрбум төгрөгийн урт хугацаат гадаад, 1,359.0 тэрбум төгрөгийн урт хугацаат дотоод бондыг тус тус арилжаалсан байна.

Цаашид улсын төсвийн орлогын тасалдал үргэлжилж, алдагдал өсөхөөр байна. Төсвийн алдагдалтай байдал үргэлжлэх нь Засгийн газрын өрийг нэмэгдүүлэх, хувийн хэвшлийг шахах сөрөг нөлөөтэй. Иймд макро эдийн засгийн “Шинэ тэнцвэр”-ийн бодлогын хүрээнд:

- 2016 оны төсвийн зардлыг бууруулах, 2016-2018 онуудад улсын төсвийг алдагдалгүй байлгах,
- Засгийн газрын гадаад өрийн үйлчилгээний дунд хугацааны төлөвлөгөөг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлагатай байна.

ШИГТГЭЭ

Төсвийн тогтвортой байдлын хуулинд өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн газрын өрийн дотоодын нийт бүтээгдэхүүнд харьцуулсан харьцаа 2015 оны төсвийн жилд одоо байгаа түвшинд буюу 58.3 хувиас, 2016 оны төсвийн жилд 55 хувиас, 2017 оны төсвийн жилд 50 хувиас, 2017 оны төсвийн жилээс эхлэн 40 хувиас тус тус хэтрүүлэхгүй байхаар заасан. Харин нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлыг 2015 онд тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний 5 хувиас, 2016 онд тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний 4 хувиас, 2017 онд тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний 3 хувиас, 2018 оны төсвийн жилээс эхлэн тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувиас тус тус хэтрүүлэхгүй байхаар заасан.


2.1 МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ҮНДСЭН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ, ҮР ДҮН

Жилийн инфляци 2015 оны эцэст улсын хэмжээнд 1.9%, Улаанбаатар хотод 1.1% болж, өнгөрсөн оноос харгалзан 9.1, 9.6 нэгж хувиар буураад байна. Үнийн өндөр хэлбэлзэлтэй бараа, бүтээгдэхүүнийг хасч тооцсон суурь инфляци 2014 оны эцэст 12.6% байсан бол 2015 оны эцэст 4.8% болж буурчээ. Ийнхүү инфляцийн түвшин 2015 оны эцэст улсын болон Улаанбаатар хотын хэмжээнд огцом буурч, зорилтот түвшинд гарлаа.

2015 оны эцсийн Улаанбаатар хотын жилийн инфляци (1.1%)-ийг бүтцээр нь задлан үзвэл мах, махан бүтээгдэхүүн -2.66, махнаас бусад хүнсний бүтээгдэхүүн 0.53, төрийн зохицуулалттай бараа, үйлчилгээ 1.45, бусад бараа, үйлчилгээ 1.82 нэгж хувийг тус тус бүрдүүлж байна. Өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнийн ерөнхий төлөвийг харвал 2015 онд махны үнэ өмнөх оноос огцом буурч инфляцийг бууруулах нөлөө үзүүлж байгаа бол бусад бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт бүрэлдэхүүн тус бүрээр саарч байгаа хандлага үргэлжилсээр байна.

Инфляци нам түвшинд хүрсэн нь нэг талаас “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөр”-ийн үр дүнд нийлүүлэлтийн гаралтай инфляцийн дарамт 2013-2014 онуудад эрс буурч, 2015 оны эхнээс арилсантай холбоотой юм. Тухайлбал, үнэ тогтворжуулах хөтөлбөрт хамрагдсан бараа, үйлчилгээний үнэ 2012 онд жилийн инфляцийн 4.2 нэгж хувийг бүрдүүлж байсан бол хөтөлбөр хэрэгжсэнээр 2013 онд жилийн инфляцид эзлэх хувь 1.2 нэгж хувь, 2014 онд -0.4 нэгж хувь, 2015 онд -2.45 нэгж хувь болж буурсан байна. Төрийн зохицуулалттай бараа, үйлчилгээний үнийн жилийн инфляцид эзлэх хувь хэмжээ хэвээр байгаа бол импортын болон дотоодын бусад бараа, үйлчилгээний үнэ буурах хандлага үргэлжилж байна.

Зураг 37. Жилийн инфляци (голлох 4 ангиллаар)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Макро бодлогын өөрчлөлтийн нэгдсэн төлөвлөгөө (СМАР)-ний хүрээнд мөнгөний бодлого нь 2015 онд эдийн засгийн гадаад тэнцвэрийг дэмжихэд чиглэсэн. Ингэснээр төлбөрийн тэнцэл сайжрах, валютын зах тогтворжих, төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн инфляци дахь сөрөг нөлөөлөл үргэлжлэн буурах, улмаар төгрөгийн тогтвортой байдал буюу төгрөгөөр илэрхийлэгдсэн бараа, үйлчилгээний үнийн тогтвортой байдал хангагдах нөхцөл бүрдэнэ.

Эдийн засгийг зөөлөн газардуулах, тогтворжуулах, гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлтийг нам, тогтвортой түвшинд байлгах зорилгоор 2012 оны 04 дүгээр улирлаас эхлэн хэрэгжүүлсэн бодлогын арга хэмжээний

үр дүнд хөтөлбөрт хамрагдах барааны үнийн өсөлтийн инфляцид үзүүлэх шууд нөлөөлөл эрс буурч, 2010-2012 оны дунджаар нийлүүлэлтийн гаралтай инфляци нийт инфляцийн 1/3-ийг эзэлдэг байсан бол 2013 онд 1/6, 2014 онд 1/20 болж буурсан. 2015 оны эцэст жилийн инфляци 1.9 хувь болж буурсан бөгөөд үүнд нэг талаас хөтөлбөрт хамрагдсан барааны үнэ буурсан нь, нөгөө талаас нийт эрэлт буурч, хэрэглээ агшсанаар эрэлтийн гаралтай инфляци буурсан нь шууд нөлөө үзүүлэв.

2014 оны эхний хагаст гадаадын шууд хөрөнгө оруулалт, гадаад цэвэр актив буурсан хандлага үргэлжилж, төсөвтэй адилтгах хөрөнгө оруулалтын зарцуулалтууд буурахгүй, гадаад валютын орох урсгал, төлбөрийн тэнцлийг сайжруулах арга хэмжээний үр дүн хангалттай бус байсан тул Монголбанк 2014 оны 07 дугаар сараас эхлэн мөнгөний бодлогын төлөвийг алгуур чангаруулах чиглэлд өөрчилж, мөнгөний бодлогын хүүг 1.5 нэгж хувиар нэмэгдүүлэн 12% болгосон. Мөнгөний бодлогын зөвлөл 2015 оны 01 дүгээр сард мөнгөний бодлогын хүүг 1.0 нэгж хувиар нэмэгдүүлэн 13% болгосон бөгөөд 2015 оны 4 болон 07 дугаар сарын зөвлөлийн ээлжит хурлаар мөнгөний бодлогын хүүг өөрчлөлгүй хэвээр хадгалах шийдвэрийг тус тус гаргасан байна. Ийнхүү 2014 оны 07 дугаар сараас хойш 18 сарын туршид мөнгөний бодлогын хатуу төлөвийн хадгалав.

Мөнгөний бодлогын төлөвийг ийнхүү 2014 оны сүүлийн хагасаас эхлэн үе шаттай, алгуур чангаруулсан нь гадаад худалдааны нөхцөл сайжирч, гадаад валютын орох урсгал нэмэгдэх хүртэл макро эдийн засгийн гадаад тэнцвэрийг дэмжих зорилгоор төгрөгийн өгөөжийг нэмэгдүүлсэн бодлогын арга хэмжээ байв. Эдийн засгийг зөөлөн газардуулах зорилгоор 2013-2014 онуудад хэрэгжүүлсэн мөнгөний “уламжлалт бус” бодлогын үр дүнд нийлүүлэлтийн гаралтай инфляцийн дарамт эрс буурсны зэрэгцээ мөнгөний уламжлалт арга хэрэгслээр эдийн засгийн гадаад тэнцвэрийг дэмжсэн нь нийт эрэлтийг хумих, төлбөрийн тэнцлийн урсгал дансны алдагдал 2015 оны урьдчилсан гүйцэтгэлээр өмнөх оны мөн үеэс 857 сая ам.доллараар буюу 2.6 дахин буурах, жилийн инфляци 2015 оны эцэст 1.9% болж 2014 оны эцсийн гүйцэтгэлээс 9.1 нэгж хувиар буурах, санхүүгийн болон макро эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалахад тус тус эерэгээр нөлөөлж байна.


ШИГТГЭЭ 1. ГОЛ НЭРИЙН БАРАА, БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНИЙГ ТОГТВОРЖУУЛАХ ДУНД ХУГАЦААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

Монгол Улсад инфляцийн түвшин түүхэн хугацаанд байнга өндөр, хэлбэлзэл ихтэй байж ирсэн. Энэ нь эдийн засаг савлагаа ихтэй нэг салбар (уул уурхайн олборлох үйлдвэрлэл), гадаад зах зээлээс хэт хамааралтай болсны зэрэгцээ эдийн засагт эрсдэл үүсэхэд түүнийг зөөллөх хамгаалалтын механизмууд буюу хуримтлалгүй явж ирсэнтэй холбоотой байв.

2007-2015 онд инфляци ердөө 2 тохиолдолд нь нэг оронтой тоонд орсон байдаг. Эхнийх нь 2009 оны санхүү, эдийн засгийн хямралаар ДНБ-ий бодит өсөлт 2008 оны +8.9%-аас 2009 онд -1.3% болж агшихад инфляци 22.1%-аас 4.2% болж буурч байжээ. Харин 2015 онд ДНБ-ий бодит өсөлт 2.3% байхад инфляци 1.9% болж бууран зорилтот түвшнээс доогуур гарлаа.

2010-2012 онуудад инфляци 13.0%, 10.2%, 14.0% буюу байнга хоёр оронтой тоонд байсан. Нийт эрэлт өссөнөөс гадна Засгийн газрын болон хувийн хэрэглээ огцом тэлсэн нь эрэлтийн гаралтай инфляцийг нэмэгдүүлж байв. Түүнчлэн инфляцийн 1/3-ийг нийлүүлэлтийн гаралтай инфляци, түүний дотор хүнс, махны үнийн өсөлт дангаар бүрдүүлж байжээ. Зөвхөн махны үнэ 2010-2012 онд жил бүр дунджаар 34%-аар, 2012 онд 44%-аар өсч байсан байна.

Зураг 38. ДНБ-ий бодит өсөлт ба жилийн инфляци (2007-2015)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Энэ нь бага, дундаж орлоготой иргэдийн бодит орлогод 20-80%-ийн сөрөг нөлөө, ачаалал бий болгож, нийгмийн дундаж давхаргыг дунджаас доогуур, эмзэг, ядуу бүлэг рүү шахах сөрөг нөлөөтэй байсан юм. Иймд инфляцийг бууруулж, нам, тогтвортой түвшинд байлгах зайлшгүй шаардлага гарсан.

1. Хөтөлбөр хэрэгжүүлэхийг даалгасан УИХ-ын шийдвэрүүд

Ийм учраас УИХ-аас 2012 оны №57, 2013 оны №62, 2014 оны №34, №69 дүгээр тогтоол гэх мэтээр шаардлагатай шийдвэрүүдийг тухай бүр гаргаж байв. Эдгээр тогтоол шийдвэрээр дараах арга хэмжээ авахыг Засгийн газар, Монголбанкинд даалгасан байдаг:

- (1) Иргэдийн өргөн хэрэглээний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах үр дүнтэй арга хэмжээ авах;
- (2) Нийлүүлэлтийн гаралтай инфляцийн нөлөөллийг хязгаарлах хамтарсан бодлого баримтлах;
- (3) Үнийг тогтворжуулах цогц механизм боловсруулж хэрэгжүүлэх;
- (4) Хөтөлбөрт иж бүрэн дүн шинжилгээ хийж, түүний үр өгөөжийг нэмэгдүүлэх;
- (5) Хөтөлбөрийн арга хэрэгслийг зах зээлийн механизмд суурилсан хэлбэрт шат дараатай шилжүүлэх;
- (6) Хөтөлбөрт хяналтын тогтолцоог сайжруулах, хөтөлбөр хэрэгжиж байгаа салбарт өрсөлдөөний шударга бус орчин бий болохоос урьдчилан сэргийлэх, ил тод, нээлттэй байдлыг хангаж ажиллах;
- (7) Хөтөлбөрт иж бүрэн дүн шинжилгээ хийж, УИХ-д танилцуулан, цаашид хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх эсэхийг шийдвэрлүүлэх;
- (8) Нийлүүлэлтийн гаралтай инфляцийг аймаг, нийслэлийн түвшинд нам, тогтвортой байлгах арга хэмжээ авах;
- (9) Хөтөлбөрийг зах зээлийн зарчимд шилжүүлэх замаар иргэдийн хэрэглээний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтийн тогтвортой тогтолцоог бий болгох;
- (10) Хөтөлбөрөөс үе шаттай гарах арга замыг сонгож хэрэгжүүлэх.


2. Хөтөлбөрийг хэрэгжүүлсэн ерөнхий схем

Хөтөлбөрийг хувийн хэвшлийн зээл (агуулах дахь бүтээгдэхүүний нөөц буюу хөдлөх хөрөнгийг барьцаалсан банкны зээл буюу агуулахын санхүүжилтийн арга хэрэгсэл)-ээр санхүүжүүлсэн. Хөтөлбөр дараах дэс дараатай хэрэгжсэн. Үүнд:

- Засгийн газраас хөтөлбөрт хамрагдах ААН-ийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулна.
- ААН агуулах дахь бүтээгдэхүүн (мах, улаан буудай, шатахуун)-ий нөөцөө барьцаалж банкинд хөнгөлөлттэй хүүтэй зээл авах хүсэлт гаргана.
- Банк ААН-ийн хүсэлтийг судалж, эрсдэлийг нь үнэлэн, зээлийн хорооны шийдвэрээ бие даан гаргана.
- Монголбанкнаас банкинд зээл олгоно. Банк Монголбанкнаас авсан зээлийн эх үүсвэрээр ААН-д хөтөлбөрийн зээл олгохдоо агуулах дахь бүтээгдэхүүний нөөц болон бусад хөрөнгийг нь барьцаална. Зээл бүрийн цаана барьцаа хөрөнгө байна. ААН-д олгосон зээлийн эрсдэлээ банк хариуцна.
- ААН банкинд вексель бичиж өгнө.
- ААН банкнаас авсан зээлийн эх үүсвэрээр агуулах дахь бүтээгдэхүүний нэмэлт нөөцийг бүрдүүлнэ.
- Агуулах дахь бүтээгдэхүүний нөөцийг хөтөлбөрт заасан нөхцөл, Засгийн газар ААН хооронд байгуулсан гэрээний дагуу зах зээлд улирлын чанартай борлуулна.
- ААН борлуулалтын орлогоос банкны зээлийн төлбөрийг бүрэн төлж барагдуулна.
- Монголбанк банкинд олгосон зээлийг хугацаанд нь бүрэн төлүүлнэ. Ингэхдээ хөтөлбөрийг хэрэгжүүлэгч ААН банкинд зээлээ төлсөн эсэхээс үл хамааран Монголбанк дахь банкны харилцах данснаас суутгаж болно.
- Хөтөлбөрийн зээлийн эх үүсвэрийг анх Монголбанк банкинд олгосон зээл хэлбэрээр 2012-2013 онд 100% шийдвэрлэж байсан бол 2013-2014 онд 80%, 2014-2015 онд 60% болгон бууруулж, үлдсэн 20% болон 40%-ийг банк өөрийн эх үүсвэрээр санхүүжүүлсэн болно.
- Монголбанк 2015 онд хөтөлбөрийн өмчлөл, зээлийн үлдэгдлийг Засгийн газарт шилжүүлж, хөтөлбөрөөс бүрэн гарсан.

3. Хөтөлбөрийн үр дүн

Зураг 39. Монгол Улсын жилийн инфляци, түүний бүтэц дэх өөрчлөлт (2007-2015)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Хөтөлбөрийн үр дүнд нийлүүлэлтийн гаралтай инфляци 3 жилийн дотор тэг (0.0) болсон. Хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх жилийн инфляци 3 жилийн дотор 14.0%-аас 1.9% болж буурсан бөгөөд цаашид инфляци нам, тогтвортой түвшинд хадгалагдах нөхцөл бүрдсэн.

4. Хөтөлбөрийн зээлийн үлдэгдэл

Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөрийн хүрээнд нийт 5 дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж дууссан.

Дээрх 5 дэд хөтөлбөрийн хүрээнд банкуудаас олгосон зээлийн нийт үлдэгдэл 2013 оны эцэст 714 тэрбум төгрөг байсан. Хөтөлбөрийн зээлүүд гэрээнд заасан хуваарийн дагуу эргэн төлөгдсөөр зээлийн нийт үлдэгдэл 2014 оны эцэст 634 тэрбум төгрөг, 2015 оны эцэст 232 тэрбум төгрөг, 2016.06 сарын байдлаар 126 тэрбум төгрөг болж буурсан. Хөтөлбөрийн зээлийн үлдэгдэл хуваарийн дагуу эргэн төлөгдсөөр 2016 оны эцэст 27 тэрбум төгрөг, 2017 оны эцэст 0 болно.

Хүснэгт 9. Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн дэд хөтөлбөрүүдийн зээлийн үлдэгдэл, тэрбум төгрөгөөр (хугацааны эцэст)

		2013	2014	2015.06.30	2015.12.31	2016.12.31	2017.12.31
“Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөр	Махны нөөц бүрдүүлэх, үнийг тогтворжуулах	61.6	17.3	30.2	-	-	-
	Гурилын үнийг тогтворжуулах	12.5	47.0	21.2	-	-	-
	Хүнсний бүтээгдэхүүний зоорь, агуулахыг нэмэгдүүлэх, эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх	99.0	132.2	111.1	82.2	7.6	-
“Шатахууны жижиглэнгийн худалдааны үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөр		192.0	176.1	92.2	-	-	-
“Өргөн хэрэглээний импортын бараа, бүтээгдэхүүний өртгийг бууруулах” дэд хөтөлбөр		12.0	15.9	7.7	1.3	-	-
“Барилгын салбарыг дэмжих, улмаар орон сууцны үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөр	Барилгын гол нэр төрлийн материалын дотоодын нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах	169.7	211.7	200.8	147.9	19.1	-
	Зайлшгүй импортлох шаардлагатай барилгын материалын нийлүүлэлтийн хязгаарлалтыг арилгах	99.4	-	-	-	-	-
	Дэвшилтэт технологи бүхий байгаль орчинд ээлтэй барилгын материал үйлдвэрлэх төслүүдийг дэмжих	-	-	-	-	-	-
“Нүүрсний аюулгүйн нөөц бүрдүүлэх, түлш, эрчим хүчний салбарын өвөлжилтийн бэлтгэл хангах, эрчим хүчний үнэ, тарифыг тогтворжуулах” дэд хөтөлбөр		67.9	33.6	12.2	0.3	-	-
Нийт		714.1	633.8	475.4	231.7	26.7	-

Эх сурвалж: Монголбанк

5. Тайлагнал, ил тод байдал

- Монголбанкнаас УИХ-ын 2012 оны №57, 2013 оны №62, 2014 оны №69 дүгээр тогтоолууд, Төрөөс мөнгөний бодлогын талаар 2013, 2014, 2015 онд баримтлах үндсэн чиглэлийн биелэлтийг УИХ-ын Эдийн засгийн байнгын хороонд улирал бүр, нийт 12 удаа албан бичгээр хүргүүлсэн.
- Монголбанкнаас Төрийн мөнгөний бодлого, мөнгөний бодлогод сөрөг нөлөөтэй хүчин зүйлс, эрсдэлийн тухай, мөн Хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албанд жилд 4 удаа, 2013-2015 онд нийт 12 удаа хүргүүлсэн.
- Монголбанк Хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнгийн талаар УИХ-ын нэгдсэн чуулган, УИХ-ын холбогдох байнгын хороод, УИХ дахь намын бүлгүүдийн хуралдаанд шаардлагатай үед тухай бүр сонсгол, мэдээлэл хийж, хэрэгжилтийг тайлагнаж, холбогдох мэдээллийг хүргүүлж ажилласан.
- Монголбанк Хөтөлбөрт хийсэн дүн шинжилгээний тайланг УИХ-ын Эдийн засгийн байнгын хороонд 2014 оны 05 дугаар сард, Хөтөлбөрийн үнэлгээ, дүгнэлт, зөвлөмжийг Засгийн газарт 2015 оны 03 дугаар сард тус тус хүргүүлсэн.


- Монголбанк Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц байдлыг олон нийтэд, өөрийн цахим хуудасны <https://www.mongolbank.mn/pricestability.aspx> гэсэн холбоосоор болон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол тайлагнасан.

ШИГТГЭЭ 2. ОРОН СУУЦНЫ САНХҮҮЖИЛТИЙН ТОГТВОРТОЙ ТОГТОЛЦООГ БИЙ БОЛГОХ ХӨТӨЛБӨР

Ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бий болгох талаар хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичгийг Монголбанк Засгийн газартай 2013 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр байгуулсан. Энэ хүрээнд Монголбанкнаас 2013 оны 06 дугаар сарын 14-ний өдөр баталсан “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн журам”-ын дагуу ерөнхий гэрээг банкууд болон МИК-тай байгуулж, өмнө олгосон орон сууцны ипотекийн зээлийг дахин санхүүжүүлэхэд болон шинээр ипотекийн зээл олгоход зориулж 2015 оны байдлаар 3.0 их наяд төгрөгийг банкуудад байршуулсан болно.

Орон сууцны ипотекийн санхүүжилтийн хөтөлбөрийн хүрээнд банк ипотекийн зээл олгож энэхүү зээлийг багцлан Тусгай зориулалтын компани /МИК ОССК ХХК/-д худалдаж шинээр олгох ипотекийн зээлийн эх үүсвэрийг бүрдүүлнэ. Харин Тусгай зориулалтын компани орон сууцны ипотекийн зээлийг багцлан ипотекийн зээлээр баталгаажсан бондыг хөрөнгийн зах зээлд гарган эх үүсвэр татна.

Зураг 40. Орон сууцны санхүүжилтийн систем




Эх сурвалж: Монголбанк

Энэхүү хөтөлбөр хэрэгжиж эхэлснээр орон сууцны ипотекийн зээлийн үлдэгдэл 2015 онд 3.4 их наяд төгрөгт хүрч, нийт 77,105 зээлдэгч орон сууцны ипотекийн зээл аваад байна. Тайлант оны байдлаар зээлийн жигнэсэн дундаж хүү жилийн 8.8 хувьд хүрсэн. Үүнээс 2015 онд 11,731 зээлдэгчид нийт 701.8 тэрбум төгрөгийн орон сууцны ипотекийн шинэ зээл олгогдож, 74.1 тэрбум төгрөгийн 8 хувийн ипотекийн зээл буцаан төлөгдсөн байна.

Ийнхүү орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бий болгосноор Монгол Улс хэрэглээний эдийн засгаас хуримтлалтай эдийн засагт шилжих, нийгмийн дундаж давхаргын хуримтлал, бүтээмжийг нэмэгдүүлэх, хөдөлмөрийн зах зээлийн ил тод байдлыг сайжруулах, нийгмийн даатгалын сангийн орлогыг нэмэгдүүлэх эерэг нөлөөллүүд бий болно. Уг тогтолцоо нь урт хугацаанд эргээд инфляцийг бууруулахад эерэгээр нөлөөлж, эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлтийн зорилтыг хангах болно.

Зураг 41. Орон сууцны ипотекийн зээл (хөтөлбөр эхэлснээс хойшхи хугацаанд)



Эх сурвалж: Монголбанк

2.2. БАНКНЫ САЛБАРЫН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ

Монголбанк 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 12 банкинд иж бүрэн болон хэсэгчилсэн шалгалтыг хууль тогтоомжийн хүрээнд хийж, илэрсэн зөрчилд улсын байцаагчийн акт тогтоох, шийтгэвэр ногдуулах зэрэг арга хэмжээг авч ажиллав. Шалгалтын мөрөөр гарсан Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалын биелэлтэд тогтмол хяналт тавьж байна.

Банкны тухай хууль, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2010 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 460 дугаар тушаалаар батлагдсан “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”, Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын 2010 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн 475/182 дугаар тушаалаар батлагдсан “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам” болон холбогдох бусад хууль, тогтоомжуудын хүрээнд банкуудын үйл ажиллагаанд зайнаас тогтмол хяналт тавин ажиллаж байна.

Монголбанкнаас санхүүгийн салбарыг болзошгүй эрсдэлээс сэргийлэхэд чиглэсэн мөчлөг сөрсөн бодлого хэрэгжүүлж, дотоод актив чанаргүйдэх эрсдэлийг бууруулах арга хэмжээ авч ажиллаж байна.

Монголбанк 2015 оны 01-02 дугаар сард “Системийн хяналт болон болзошгүй хямралаас урьдчилан сэргийлэх чадварыг сайжруулах” чиглэлээр ОУВС-гаас техник туслалцаа авсан. ОУВС-гийн техник туслалцааны зөвлөмж, Дэлхийн банкны Ажлын хэсгийн Хөгжлийн бодлогын зээл (DPL)-ийн матрицын төсөлд тусгагдсан зөвлөмжүүдэд үндэслэн Монголбанк “Санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, Базель-III стандартыг хангахад чиглэсэн эхний шатны арга хэмжээ”-ний төслийг боловсруулаад байна.

Чанаргүй активын эргэн төлөлтийг гүйцэтгэх чиглэлд мэргэшсэн, мэргэжлийн байгууллага байгуулан ажиллах эхний судалгааг гүйцэтгэж, түүнийг байгуулах боломж, суурь эрх зүйн орчинг тодорхойлсон. Энэхүү байгууллагыг санхүүгийн системд нэвтрүүлснээр чанаргүй активын хоёрдогч зах зээл хөгжиж, санхүүгийн салбарын зардлыг бууруулах, эрсдэлийн удирдлагын оновчтой тогтолцоо бүрдэх боломжийг олгоно. Мөн системийн хэмжээнд активын чанар алдагдах тохиолдолд санхүүгийн зуучлалыг хэвийн үргэлжлүүлэх суурь нөхцөлийг хадгалах давуу тал бүрдэнэ гэж үзэж байна.

Банкны хяналт шалгалтын Базелийн хорооноос тогтоосон зарчим, олон улсад мөрдөгддөг жишгийн дагуу банкны нэгдсэн хяналт шалгалтыг хэрэгжүүлэхэд Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөж байгаа Банкны тухай хууль болон бусад хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэх талаар Монголбанкнаас нэгдсэн хяналт шалгалтын зарчим, шалгуур үзүүлэлт тус бүрээр судалж, урьдчилсан дүгнэлтийг гаргаад байна. Монголбанк нь энэхүү ажлын хүрээнд Азийн хөгжлийн банкны олон улсын зөвлөлтэй хамтран ажилласан бөгөөд энэ хүрээнд Банкны тухай хуулийн 3 болон

43 дугаар зүйлд тодорхойлсон банкны нэгдэл, банкны нэгдсэн хяналт шалгалт, түүнийг хэрэгжүүлэх журмын зохицуулалтуудыг сайжруулах, банкны нэгдлийн хэмжээнд санхүүгийн зохистой шалгуур үзүүлэлт тогтоох, нэгдсэн хяналт шалгалтын дагуу банкны нэгдэлд авах албадлагын арга хэмжээ, хянан шалгагчийн бүрэн эрхтэй холбоотой хууль эрх зүйн зохицуулалтыг судалсан. Банкны нэгдсэн хяналт шалгалтын талаарх судалгааны эцсийн үр дүнд үндэслэн хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээг Банкны хууль тогтоомжийн хүрээнд судлан, хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай эсэхийг тогтоохоор ажиллаж байна.

Олон улсын жишгээр хяналт шалгалтын аргачлал нь гүйцэтгэлд суурилсан аргачлалаас эрсдэлийн үнэлгээнд суурилсан хяналт шалгалтын аргачлалд шилжих хандлагатай болсон тул банкуудын ирээдүйд хүлээж болзошгүй эрсдэлийг урьтаж илрүүлэх, оновчтой тооцоолох, хяналт шалгалтын нөөц, чадавхийг эрсдэл өндөртэй гэж үзсэн үйл ажиллагааны чиглэлд түлхүү хуваарилах, улмаар системийн эрсдэл үүсэх сөрөг үр дагаврын далайцыг бууруулах зохицуулалтын дэвшилтэт аргачлалыг нэвтрүүлэхэд Монголбанкны зүгээс онцгой анхааран ажиллаж байна. Тус ажлын хүрээнд шинэ аргачлалыг хэрэгжүүлэхэд шаардлагатай журам, гарын авлага боловсруулахаар тус асуудлаар мэргэшсэн олон улсын зөвлөхтэй хамтран ажиллаж, эрсдэлд суурилсан хяналт шалгалтын журмын төслийг урьдчилсан байдлаар боловсруулаад байна.

ОУВС-гийн мэргэжилтнүүдийн өгсөн техник туслалцаа, зөвлөмжийн дагуу банкны хяналт шалгалт хийх бүтэц зохион байгуулалтыг сайжруулан, эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлэхэд тохиромжтой байдлаар шинэчлэх асуудлыг хэлэлцэж байна.

“Банкны хяналт шалгалтын дунд хугацаанд хэрэгжүүлэх стратеги” төслийг баталж, ойрын 5 жилд банкны хяналт шалгалтын хүрээнд хийгдэх онцлох арга хэмжээнүүдийг шат дараатайгаар авч хэрэгжүүлэхээр дунд хугацааны төлөвлөгөөнд тусгасантай холбогдуулан Базел стандартад шилжих стратеги хөтөлбөрийн анхны хувилбарыг олон улсын зөвлөх боловсруулан, ойрын 5 жилийн хугацаанд Базел III стандартад шилжихэд Монголбанкны зүгээс баримтлах бодлого, авах арга хэмжээг энэхүү хөтөлбөрт тусгалаа. Энэхүү цуврал стандартыг нэвтрүүлснээр нийт банкны салбарын эрсдэл даах чадварыг сайжруулахын зэрэгцээ хяналт шалгалтын олон улсад мөрдөгдөх стандартад нийцсэн хяналт, зохицуулалтын аргачлалыг ашиглах боломж бүрдэнэ.

Түүнчлэн банкуудад мөрдөгдөж буй нягтлан бодох бүртгэлийн багц материалыг санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн шинэчлэн боловсруулж, 2015 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн А35/20 дугаар тушаалаар Сангийн яамтай хамтран баталж, банкуудаас тайлан хүлээн авах програм хангамжийг шинэчилсэн болно.

Банкуудын олон нийтэд тайлагнадаг мэдээллийн стандарт загвар, зөвлөмжийг шинэчлэх ажлын хүрээнд Монголбанк, Нидерландын хөгжлийн банк, Олон улсын санхүүгийн корпораци болон Монголын банкны холбооноос хамтран зохион байгуулсан “Компанийн засаглалын хэлэлцүүлэг”-ийн үр дүнд холбоотой этгээдийн зээл болон хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхлын зөрчилдөөний асуудлуудыг хэрхэн амжилттай удирдан шийдвэрлэх талаар олон улсын шилдэг туршлагад нийцүүлсэн зөвлөмжийн төслийг боловсруулаад байна. Банкны тухай хууль болон банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журмын дагуу банкууд зарим мэдээллийг олон нийтэд цахим хуудсаараа дамжуулан тайлагнах үүрэгтэй. Энэхүү үүргийн хүрээнд банкуудын олон нийтэд тайлагнадаг мэдээллийг стандарт загварыг боловсруулан Монголбанкны Ерөнхийлөгчийн 2015 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн А-200 дугаар тушаалаар батлуулсан.

Сүүлийн жилүүдэд банкны салбарын эрсдэл даах чадварыг хадгалах, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, зах зээлийн дэд бүтцийг хөгжүүлэх тодорхой зорилтуудыг Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлд тогтмол тусган, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тайлант онд дараах томоохон бодлогын арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүллээ. Үүнд:

- **Банкуудын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг 50 тэрбум төгрөг болгон нэмэгдүүллээ.**

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2015 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн А-58 дугаар тушаалаар банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг 50 тэрбум төгрөг байхаар шинэчлэн тогтоолоо. Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг 1991 онд 50 сая төгрөгөөр анх тогтоож эхэлсэн бол 1995 онд 400 сая төгрөг, 1999 онд 2 тэрбум төгрөг, 2001 онд 4 тэрбум төгрөг, 2006 онд 8 тэрбум төгрөг, 2011 онд 16 тэрбум төгрөгөөр тус тус тогтоож байсан. Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийг ийнхүү нэмэгдүүлснээр банкны салбарын эрсдэл даах чадвар сайжрахын зэрэгцээ, банкууд томоохон төслүүдийг бие даан санхүүжүүлэх чадавхийг нэмэгдүүлэх, хувь нийлүүлэгчдийн санхүүгийн хариуцлагыг дээшлүүлэх, цаашлаад жижиг банкуудын үйл ажиллагааг идэвхжүүлэн банкны салбарт шударга өрсөлдөөнийг бүрэлдүүлэх зэрэг олон давуу талыг бий болгоно.

- **Санхүүгийн салбарын активын удирдлагын бүтцийг төрөлжүүлэх, хоёрдогч зах зээлийг хөгжүүлэх ажлыг эхлүүлээ.**

Тайлант онд активын удирдлагын үр ашигтай, байнгын ажиллагаатай тогтолцоог бүрдүүлэхэд Монголбанкны баримтлах бодлого, оролцоо, үүсгэн байгуулагдах институцийн бүтэц, зохион байгуулалтын судалгааг гүйцэтгэж, хувийн салбарын оролцоотой Активын удирдлагын компанийг үүсгэн байгуулах саналыг 2015 оны 10 дугаар сард банкуудад танилцуулсан. Улмаар хамтран ажиллах ерөнхий гэрээг байгуулан, компанийг үүсгэн байгуулах гэрээ, дүрмийг боловсруулан, үүсгэн байгуулагчийн анхдугаар хурлыг хуралдуулж, Төлөөлөн удирдах зөвлөлийг бүрдүүлээд байна.

Мөн Активын удирдлагыг үр ашигтай гүйцэтгэхэд шаардлагатай эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор Азийн хөгжлийн банкнаас санхүүгийн болон техник туслалцаа авахаар тохиролцож харилцан ойлголцлын санамж бичиг байгуулан, цаашид энэ чиглэлд хамтран ажиллахаар болоод байна.

- **Банкны нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэв.**

Банкны санхүүгийн тайлагналыг олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэх зорилгоор сүүлийн 3 жилд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд 2015 оны 02 дугаар сард Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайд хамтран “Банкны нягтлан бодох бүртгэлийн багц материал”-ыг шинэчлэн баталсан.

Энэ багц материалтай уялдах банкны сарын тайлангийн шинэ загварыг турших, сайжруулах, мэдээллийн агууллагыг баяжуулах үйл ажиллагааг 2015 онд банкуудтай хамтран гүйцэтгэсэн бөгөөд 2016 оны эхнээс олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тайланд үндэслэн банкуудын эрсдэл даах чадварыг үнэлж эхлээд байна.

- **Чанаргүй активыг тэнцлээс хасах эрх зүйн орчныг сайжрууллаа.**

Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн Сайдын 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн А-182/324 дүгээр хамтарсан тушаалаар “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-д өөрчлөлт оруулан банкууд муу активыг тэнцлээс хасахдаа шүүхийн шийдвэрт үндэслэдэг байсан зохицуулалтыг өөрчлөн Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр хасах боломжийг нээлээ. Ингэснээр цаашид төлөгдөхгүй нь тодорхой болсон, төлбөр хариуцагч нь сураггүй болсон зэрэг зээлийг тэнцлээс шуурхай хасах боломжтой болж банкны зардлыг бууруулах боломж бүрдсэн.

- **Эрсдэлийн үнэлгээнд суурилсан хяналт шалгалтын аргачлалыг хөгжүүлэх арга хэмжээг үргэлжлүүлж байна.**

Хяналт шалгалтын аргачлалыг гүйцэтгэлд суурилсан аргачлалаас эрсдэлийн үнэлгээнд суурилсан хяналт шалгалтын аргачлалд шилжүүлэн, хяналт шалгалтын нөөцийг оновчтой хуваарилах, хүлээж болзошгүй эрсдэлийг урьтаж илрүүлэх, бодлогын арга хэмжээг тухай бүр авах замаар системийн эрсдэлийг бууруулахад Монголбанкнаас онцгой анхаарал хандуулж байна.

Энэ арга хэмжээний хүрээнд тайлант онд банкинд газар дээрх хяналт шалгалт хийх аргачлалыг боловсронгуй болгох судалгааг гүйцэтгэн, эрсдэлд суурилсан аргачлалд тулгуурласан журмыг боловсруулан Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлан, үйл ажиллагаандаа мөрдөж эхлэв.

2.3 ГАДААД ВАЛЮТЫН УЛСЫН НӨӨЦИЙН УДИРДЛАГА

Монголбанк Гадаад валютын улсын нөөц (ГВУН)-ийн удирдлагыг хэрэгжүүлэхдээ “Төв банк (Монголбанк)-ны тухай” хуулийн 5, 21 дүгээр зүйлд заасны дагуу нөөцийн гадаад төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, найдвартай байдлыг хангаж зөвхөн дээрх нөхцөлүүд бүрэн хангагдсан тохиолдолд нөөцийн үр өгөөжийг нэмэгдүүлэх зарчмыг баримтлан ажилладаг билээ.

2015 онд Монголбанк хүлээн зөвшөөрөгдөхүйц эрсдэлийн түвшинд гадаад валютын улсын нөөцийн бүтцийг баталж, түүний хүрээнд нөөцийн активын бүтэц, хөрөнгө оруулалтын тохиромжтой хугацаа, хөрөнгө оруулалтын боломжит хэрэгслүүдийг тус тус тодорхойлон ажилласан. Түүнчлэн ГВУН-ийн хөрөнгө оруулалтуудын зах зээлийн үнэлгээг тогтмол хийж, зах зээлийн эрсдэлүүдийг тооцох, зээлийн эрсдэл болон холбогдох хязгаарлалтуудад хяналт тавих, дэлхийн зах зээлийн нөхцөл байдлыг тогтмол ажиглан судалж, холбогдох мэдээ тайлан бэлтгэх ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

2015 онд Монголбанкнаас ГВУН-ийг зээлийн эрсдэл харьцангуй бага, дэлхийн эдийн засагт тэргүүлэгч АНУ, Япон, Франц, Англи гэх мэт орнуудын төв банкууд, Олон улсын төлбөр тооцооны банк (BIS) зэрэг зээлжих зэрэглэл өндөртэй банкуудад харилцах, хадгаламж хэлбэрээр байршууллаа.

Дэлхийн эдийн засгийн өсөлт тайлант онд удаашралтай хэвээр байсан нь БНХАУ-ын эдийн засгийн өсөлт саармагжсан, газрын тосны үнийн уналт болон ам.долларын ханшийн чангаралт зэргээс голчлон шалтгааллаа. АНУ-ын Холбооны нөөцийн банк (ХНБ)-ны Нээлттэй зах зээлийн хорооны 12 дугаар сарын хурлаар 0-0.25 хувийн хооронд байсан бодлогын хүүг 25 суурь нэгжээр нэмж 0.25-0.5 хувь болгосон. Ийнхүү ХНБ бодлогын хүүгээ нэмэгдүүлэн үнэт цаас худалдан авах хөтөлбөрөө бүрэн зогсоосон тул Засгийн газрын богино, урт хугацаат үнэт цаасанд хөрөнгө оруулалтын үргэлжлэх хугацааг нэмэгдүүлэлгүй дээд тал нь 3 жил байхаар тооцоолж хөрөнгө оруулав.


Европын төв банкнаас инфляцийн эсрэг мөнгөний зөөлөн бодлого явуулж хүүгийн түвшинг тэгээс доош түвшинд хүргэсэн нь еврогийн ханшийг ам.долларын эсрэг сулруулж ГВУН-ийн еврогийн хөрөнгө оруулалтын өгөөжийг буурахад хүргэв. Мөн Хятадын ардын банкнаас мөнгөний зөөлөн бодлогыг хэрэгжүүлж юанийн ам.долларын эсрэг ханшийг чөлөөлж эхэлсэн ба ОУВС-гаас юанийг зээлжих тусгай эрхийн нөөцийн багцад оруулах шийдвэр гаргасан нь 2015 оны эцэст юанийн ам.доллартай харьцах ханш 4.62 хувиар сулрахад нөлөөлсөн.

Монгол Улсын ГВУН 2015 оны эцэст 1323.2 сая ам.долларт хүрч оны эхнээс 19.8 хувиар буюу 326.8 сая ам.доллараар буурсан. Энэ нь олон улсын жишиг доод түвшин болох валютын төлбөртэй импортын 3 сарын буюу 12 долоо хоногийн хэрэгцээг дараах байдлаар бүрэн хангаж байгаа үзүүлэлт юм. Үүнд:

- 2015 оны 12 дугаар сарын валютын шууд төлбөртэй импортын дүнгээр авч үзвэл 5.2 сарын буюу 20.9 долоо хоногийн хэрэгцээг хангах түвшинд,
- Валютын шууд төлбөртэй импортын сүүлийн 3 сарын дундаж гүйцэтгэлээр авч үзэхэд 5.4 сарын буюу 21.7 долоо хоногийн хэрэгцээг хангах түвшинд тус тус байв (Зураг 42).

ГВУН оны эхнээс 19.8 хувиар буурахад: i) банкуудын гадаад валютын ностро харилцах данс болон бэлэн валютын зузаатгал, ii) Сангийн Яам, Монголбанкны гадаад төлбөр, iii) ГВУН-ийг бүрдүүлэгч голлох валютуудын ханш ам.долларын эсрэг суларсан зэрэг нь голлон нөлөөлсөн.

Зураг 42. Гадаад валютын улсын нөөц (сая ам.доллар) ба импортын хэрэгцээг хангах түвшин (сараар)




Эх сурвалж: Монголбанк

Монгол Улсын Их Хурлын 2015 оны 41 дүгээр тогтоолоор батлагдсан “Эдийн засгийн хүндрэлээс гарах арга хэмжээний хөтөлбөр”-ийн 7.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 94 дүгээр тогтоолын 1 дүгээр заалт, Засгийн газрын 2015 оны 311 дүгээр тогтоолын дагуу алт олборлолтыг дэмжих замаар ГВУН-ийг нэмэгдүүлэх зорилгоор Монголбанк, Сангийн яам, Уул уурхайн яам хамтарч “Алт худалдан авах урьдчилгаа санхүүжилтийн арга хэмжээ”-г баталсан. Уг арга хэмжээний хүрээнд алт олборлогч аж ахуйн нэгжүүдэд эргэлтийн хөрөнгийн санхүүжилтийг олгох юм. Түүнчлэн экспортын санхүүжилтийн тогтолцоог бэхжүүлэх, алтны салбарын санхүүжилтийн тогтолцоог төгөлдөржүүлэх ажлын хүрээнд гадаад зах зээлээс “Sumitomo Mitsui

Banking Corporation”, “the Bank of Tokyo-Mitsubishi UFJ, Ltd”, “Samsung C&T Corporation”-тай алт эргүүлэн төлөх нөхцөлтэй гэрээ байгуулах замаар эх үүсвэр бүрдүүлсэн.

2014 онд “Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль” батлагдсанаар алт тушаалт нэмэгдэж, 2015 онд Монголбанкинд нийт 15.1 тонн алт тушаасан байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 18.7 хувиар өссөн үзүүлэлт юм (Зураг 43).

Зураг 43. Монголбанкны худалдан авсан алтны хэмжээ (жилээр)



Эх сурвалж: Монголбанк

Төв банкны тухай хуулийн 5 болон 21-т заасны дагуу Монголбанк гадаад валютын улсын нөөцийн аюулгүй байдлыг хангах, хөрвөх чадварыг хадгалах үүрэг хүлээдэг бөгөөд дээрх нөхцөлүүд бүрэн хангагдсан тохиолдолд нөөцийн өгөөжийг нэмэгдүүлэх зорилготой.

Тайлант онд Монголбанк улсын гадаад валютын нөөцийн бүтцийг боловсруулан батлаж, түүний хүрээнд ажиллаа. Батлагдсан бүтцийн хүрээнд нөөцийн активын хуваарилалт, хөрөнгө оруулалтын зохистой хугацаа, боломжит санхүүгийн хэрэгслүүдийг тодорхойлсон. Мөн нөөцийн зах зээлийн үнэлгээг тогтмол хийж, зах зээлийн болон санхүүгийн эрсдэлийг тооцоолох, холбогдох эрсдэлийн хязгаарлалтуудад хяналт тавих, олон улсын санхүүгийн орчин, захуудын өөрчлөлтийг ажиглах, холбогдох мэдээ тайлан бэлтгэх гэх мэт ажлуудыг гүйцэтгэлээ.

Тайлант оны 12 сарын 16-нд, Холбооны нөөцийн банк бодлогын хүүгээ 25 суурь нэгжээр өсгөсөн нь сүүлийн найман жил үргэлжилсэн мөнгөний тэлэх бодлогын эргэх цэг болов. Европын төв банк болон Японы төв банкнаас явуулж буй мөнгөний тэлэх бодлого нь жилийн турш улам эрчимжсэн нь цаашид голлох төв банкуудын мөнгөний бодлогын чиглэлд хазайлт үүсэх хүлээлтийг нэмэгдүүлж дэлхийн санхүүгийн захууд болон валютын ханш дагаж хөдлөхөд хүргэв. Улмаар санхүүгийн захын оролцогчид ам.долларын ханш чангарах хүлээлттэй болсон юм. Тайлант онд еврогийн ханш ам.долларын эсрэг 10 хувиар суларсан ба АНУ-ын Сангийн яамны үнэт цаасны өгөөж, Германы Засгийн газрын үнэт цаасны өгөөж хоёрын зөрүү 200 суурь нэгжид дөхсөн байна. Ам.долларын чангаралт болон түүхий эдийн үнийн уналт нь хөгжиж буй орнуудын валютын ханшинд дарамт үзүүлж, улмаар эдийн засгийн өсөлтийг удаашруулах, санхүүгийн тогтворгүй байдлыг нэмэгдүүлэх зэрэг сөрөг нөхцөл байдлыг үүсгэх эх үүсвэр болсон байна.

Иймд нөөцийн батлагдсан лимитийн хүрээнд, найдвартай байдлыг хангах зорилгоор Төв банкууд болон Олон улсын төлбөр тооцооны банкны харилцах, хадгаламжийн данс, АНУ-ын Засгийн газрын богино болон дунд хугацаат үнэт цаас, Японы засгийн газрын болон Олон улсын төлбөр тооцооны банкны богино хугацаат үнэт цаас, алтны харилцах дансанд /нөөцийг/ байршуулав.

Тайлант хугацаанд харилцагч банк, санхүүгийн байгууллагын санхүүгийн чадавхи муудсан, зээлжих зэрэглэл буурсан зэрэг шалтгаанаар алдагдал хүлээгээгүй ба зээлийн эрсдэлийн лимит зөрчигдсөн тохиолдол гараагүй байна.

Бусад төв банкуудын туршлага, Дэлхийн банкны зөвлөмжийн дагуу нөөц хөрөнгийг 0-1 жилийн төлбөр түргэн гүйцэтгэх хугацаатай багц ба 0-3 жилийн үргэлжлэх хугацаатай хөрөнгө оруулалтын багц болгон ангилж батлагдсан бенчмаркын дагуу удирдсан болно. 2015 оны эцсийн байдлаар гадаад валютын нөөц 1422.8 сая ам.доллартай

тэнцэж байсан нь оны эхнээс 13.6% буюу 224.1 сая ам.доллараар буурсан үзүүлэлт юм. Нийт нөөцийн 93 хувийг төлбөр түргэн гүйцэтгэх багц, үлдсэн 7% хувийг хөрөнгө оруулалтын багцад тус тус байршуулсан ба нийт нөөцийн дундаж үргэлжлэх хугацаа 8 сар байв. Энэ нь нөөцийн төлбөр түргэн гүйцэтгэх нөхцөлийг бүрэн хангасан үзүүлэлт болно.

Гадаад валютын улсын нөөцийн удирдлагыг сайжруулах, туршлага судлах зорилгоор бусад орны Төв банкууд болон Дэлхийн банктай хамтран ажиллав.

2.4 МОНГОЛ УЛСЫН ТӨЛБӨРИЙН СИСТЕМ

Монголбанк нь Монгол Улсын төлбөрийн системийг удирдан зохион байгуулах, хяналт тавих, системийн үр ашигтай, найдвартай, тасралтгүй ажиллагааг хангах, бэлэн бус төлбөр тооцоог дэмжих бодлогыг баримтлан ажиллаж байна.

Монгол Улсын төлбөрийн системийг хөгжүүлэх стратегийн бодлогын баримт бичгийг шинэчлэх, хууль эрх зүйн орчныг сайжруулах, төлбөрийн системд тавих хяналтын чадавхийг бэхжүүлэх үндсэн зорилгын хүрээнд Монголбанк нь Дэлхийн банкнаас техник туслалцааг авч эхэлсэн бөгөөд үүний үр дүнд Монгол Улсын төлбөрийн системийн дунд хугацааны (2015-2020) стратегийн баримт бичиг болон Үндэсний төлбөрийн системийн хуулийн төслийг боловсруулж, эрх бүхий бусад байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

Төлбөрийн системийн найдвартай, үр ашигтай ажиллагааг хангах зорилтын хүрээнд Монголбанк нь төлбөрийн системийн оператор, оролцогчийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж, төлбөрийн хэрэгслийн зөвшөөрөл олгон ажиллахын зэрэгцээ оператор болон оролцогчийн мөрдөн ажиллавал зохих “Төлбөрийн системд мөрдөх мэдээллийн технологийн тасралтгүй, найдвартай ажиллагааны журам”, “Төлбөрийн систем, түүний оролцогчийн үйл ажиллагаанд газар дээр нь шалгалт хийх журам”-ыг тус тус батлан гаргалаа. Түүнчлэн, их болон бага дүнтэй төлбөр тооцооны систем, картын нэгдсэн сүлжээ, тэдгээрийн оролцогчийн үйл ажиллагаанд газар дээр хийх төлөвлөгөөт шалгалтыг хуваарийн дагуу хийж, иргэд болон банкуудаас ирүүлсэн гомдлын мөрөөр гэнэтийн шалгалтуудыг хийж гүйцэтгэлээ.

Төлбөр тооцооны системийн хороо болон Үнэт цаасны хороодын олон улсын байгууллагын теникийн зөвлөлөөс тодорхойлон гаргасан “Санхүүгийн зах зээлийн дэд бүтцийн зарчмууд”-ын хэрэгжилт холбогдох системүүдийн түвшинд хэрхэн хангагдаж байгааг тодорхойлж, хэрэгжилтийн түвшинг ахиулж, тогтмол хангуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор “Үнэт цаасны төлбөр тооцооны системийн үнэлгээ”, “Их дүнтэй төлбөр тооцооны системийн үнэлгээ”, “Бага дүнтэй төлбөр тооцооны системийн үнэлгээ”-г тус тус хийж гүйцэтгэсэн. Энэхүү үнэлгээг хийснээр системүүдийн үйл ажиллагаа нь олон улсын стандартад нийцэж буй эсэхийг тодорхойлох, өөрсдийн түвшинг тогтоох ач холбогдолтой юм. Үнэлгээгээр төлбөрийн системийг зохицуулах, хяналт тавих тусгайлсан хууль буюу Үндэсний төлбөрийн системийн хууль зайлшгүй шаардлагатай болохыг баталгаажуулсан болно.

Хүснэгт 10. Банк хоорондын 2012-2015 оны гүйлгээний тоо, дүн (мянган ширхэг, их наяд төгрөг)

	2012		2013		2014		2015	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
I улирал	914.9	5.7	3846.3	9	4 513.4	13.3	5 231.4	12.0
өсөлт (%)	14.6	53.8	320.4	58.4	17.3	48.1	15.9	-9.7
II улирал	1 249.4	7.5	4 664.10	13.3	5 087.2	15	5 824.7	15.9
өсөлт (%)	16	38.5	273.3	77.7	9.1	12.7	14.5	5.8
III улирал	1 018.5	8.4	4 524.50	16.1	4 789.2	13.9	5 844.0	17.7
өсөлт (%)	12.7	40.2	344.2	91.7	5.8	-13.6	22.0	27.5
IV улирал	3 954.9	9	4 780.10	17.5	5 466.5	22.8	5 313.9	14.1
өсөлт (%)	247.1	8.4	20.9	94.2	14.4	30.4	-2.8	-38.3
Нийт	7 137.8	30.6	17 815.00	55.9	19 856.3	65.0	22 213.9	59.7
өсөлт (%)	82.1	30.7	149.6	82.8	11.5	16.3	11.9	-8.2

Эх сурвалж: Монголбанк

Зураг 44. Банк хоорондын гүйлгээний өсөлт (2012-2015)



Эх сурвалж: Монголбанк

Тайлант хугацаанд хийгдсэн банк хоорондын нийт гүйлгээний тоо 2012 оноос хойш тогтмол өссөөр 2015 онд 22.2 сая ширхэг гүйлгээ хийгдэж, 11.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Харин банк хоорондын нийт гүйлгээний дүн 59.7 их наяд төгрөг болж, өмнөх оныхтой харьцуулахад 8.2 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Энэ нь өмнөх оны 04 дүгээр улиралд гүйлгээний дүн огцом өсөж, тайлант хугацаанд буцаж буурсантай холбоотой.

Төлбөрийн карт

Төлбөрийн картны хэрэглээний үзүүлэлт жил тутамд өсөж байгаа нь иргэдийн бэлэн бус төлбөрийн хэрэгслийг өдөр тутмын төлбөр тооцоонд ашиглах сонирхол өндөр байгааг харуулж байна. Банкууд Виза, Мастеркарт, Юнионпэй, Ү карт болон Американ экспресс гэсэн 5 төрлийн төлбөрийн картыг өөрийн оноосон нэрээр гаргаж байна. Тайлант хугацаанд нийт картны 53.3 хувийг үндэсний брэнд Ү карт дангаар эзэлж, зах зээлд түлхүү ашиглагдаж байна.

Хүснэгт 11. Төлбөрийн картны хэрэглээ

Картны хэрэглээний тоо		2013	2014	2015	Орон нутаг	Өсөлт (%)
Идэвхтэй ашиглагдаж буй картны тоо	Картны тоо/сая ширхэг/	3.5	3.6	4.1	1.2	13.0
	/сая ширхэг/	1.3	1.4	2.3	0.7	68.2
Төхөөрөмжийн тоо		2013	2014	2015	Орон нутаг	Өсөлт (%)
ПОС	ПОС	9 535	12 015	14 780	3 177	23.0
	МПОС	-	2 084	4 381	241	110.2
	ПОБ	2 765	1 848	1 930	1 014	4.4
	АТМ	1 032	1 229	1 545	315	25.7
	Бусад	314	24	41	-	70.8
Гүйлгээний тоо, дүн		2013	2014	2015	Орон нутаг	Өсөлт (%)
ПОС	Тоо/сая ширхэг/	13.6	24.1	38.1	6.8	58.3
	Дүн/тэрбум төгрөг/	738.7	1 099.0	1 571.9	161.5	43.0
МПОС	Тоо/сая ширхэг/	0.0	0.0	0.2	0.0	2380.9
	Дүн/тэрбум төгрөг/	0.0	0.9	4.6	0.1	406.3
ПОБ	Тоо/сая ширхэг	1.4	3.8	1.0	0.4	-73.4
	Дүн/тэрбум төгрөг	422.5	972.9	191.2	31.6	-80.3
АТМ	Тоо/сая ширхэг/	57.0	103.1	117.2	24.0	13.7
	Дүн/тэрбум төгрөг/	4 647.5	6 392.1	6 863.5	1 091.0	7.4
Нийт	Тоо/сая ширхэг/	72.0	131.0	156.6	31.2	19.5
	Дүн/тэрбум төгрөг/	5 808.7	8 464.9	8 631.1	1 284.2	2.0

Эх сурвалж: Монголбанк

2.5 БАНК, САНХҮҮГИЙН САЛБАРЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ӨӨРЧЛӨЛТ, ШИНЭЧЛЭЛ

Тайлант онд УИХ-аас банк, санхүүгийн салбарт холбогдох хууль тогтоомжийг сайжруулах хүрээнд Төв банк / Монголбанк/-ны тухай хууль, Банкны тухай хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль, Зээлийн батлан даалтын сангийн тухай хууль, Зээлийн мэдээллийн тухай хууль, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль, Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Валютын зохицуулалтын тухай хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Эрдэнэсийн сангийн тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, Банкин дахь мөнгөн хадгаламжид баталгаа гаргах тухай хуулинд тус тус нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийг батлан гаргажээ.

Төв банк /Монголбанк/-ны тухай хууль:

Өрийн удирдлагын тухай хууль 2015 оны 02 дугаар сарын 18-ны өдөр батлагдсанаар өрийн удирдлагын бодлого, зохицуулалтын хүрээнд өрийн зохистой түвшинг хангах, дунд хугацааны стратегийг хэрэгжүүлэх, Засгийн газар, орон нутаг зээллэг хийх замаар өр үүсгэх, дамжуулан зээлдүүлэх, Засгийн газрын өрийн баталгаа гаргах, тэдгээрийг бүртгэх, тайлагнах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулжээ. Энэхүү хууль батлагдсанаар Төв банк / Монголбанк/-ны тухай хууль тогтоомжийн бүрэлдэхүүнд Өрийн удирдлагын тухай хууль орсон ба Монголбанк Засгийн газрын санхүүгийн зуучлагчийн үүрэг гүйцэтгэхдээ улсын нийт гадаад өрийн үлдэгдлийг улирал тутам санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран гаргах, олон нийтэд мэдээлэх, Засгийн газрын хийх зээллэгийн хэмжээ нь Монгол Улсын мөнгөний болон валютын зах зээлд нөлөөлөхүйц байх тохиолдолд тухай бүр холбогдох санал зөвлөмжийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх үүргийг хүлээхээр заасан.

Банкны тухай хууль:

1. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль 2015 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр шинэчлэн батлагдсанаар Банкны тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт “энэ хууль гэсний өмнө Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль гэж, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт “Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 16, 20 дугаар зүйлд гэснийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 17.1 дэх хэсэг, 21 дүгээр зүйлд гэж” тус тус нэмэлт, өөрчлөлт оруулсан.
2. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль 2015 оны 06 дугаар сарын 19-ний өдөр шинэчлэн батлагдсанаар **Банкны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсгийг** “Банкны санхүүгийн тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу **банкны санхүүгийн тайлан нь санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, санхүүгийн тайлангийн тодруулга гэсэн бүрэлдэхүүнтэй байхаар өөрчлөлт оруулсан.**
3. **Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль** 2015 оны 07 дугаар сарын 09-ний өдөр шинэчлэн батлагдсантай холбоотойгоор Банкны тухай хуулийн 11 дүгээр зүйлд “Нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын орлогыг олгох үйлчилгээнд төлбөр тооцооны үйлчилгээний хөлс тооцохгүй.” гэсэн 11.6 дахь хэсгийг нэмж оруулав. Дээрх нэмэлт орсоноор банкууд нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын орлогыг олгох үйлчилгээнд төлбөр тооцооны үйлчилгээний хөлс тооцохгүй байхаар зохицуулсан байна.
4. Гааль, татварын ерөнхий газрын эрх зүйн байдлын тухай хууль 2015 оны 12 дугаар сарын 18-ны өдөр шинэчлэн батлагдсантай холбоотойгоор Банкны тухай хуулийн 7 дугаар зүйлд “Гааль, татварын алба хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан шаардсан” гэсэн 7.2.8 дахь заалт нэмсэнээр мэдээлэл авах эрх бүхий этгээдэд Гааль, татварын албыг хамааруулав.

Валютын зохицуулалтын тухай хууль:

Өрийн удирдлагын тухай хууль 2015 оны 02 дугаар сарын 18-ны өдөр батлагдсантай холбоотойгоор Валютын зохицуулалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт “Сангийн яам хөтөлнө” гэснийг “холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хөтөлнө” гэж өөрчлөлт оруулж, 14.2-14.5 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсон.

Дээрх хуульд өөрчлөлт орсоноор гадаад орон болон олон улсын банк, санхүүгийн байгууллагаас Засгийн газрын шугамаар авсан гадаад зээл тусламжийн нэгдсэн бүртгэлийг Сангийн яам хөтөлдөг байсныг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хөтлөхөөр болсон.

Ашигт малтмалын тухай хууль:

Ашигт малтмалын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсгийн “0,1 америк доллар” гэснийг “145 төгрөг” гэж, “0,2 америк доллар” гэснийг “290 төгрөг” гэж, “0,3 америк доллар” гэснийг “435 төгрөг” гэж, “1,0 америк доллар” гэснийг “1450 төгрөг” гэж, “1,5 америк доллар” гэснийг “2175 төгрөг” гэж, “5 америк доллар” гэснийг “7250 төгрөг” гэж, 32.3 дахь хэсгийн “15 америк доллар” гэснийг “21750 төгрөг” гэж, “5 америк доллар” гэснийг “7250 төгрөг” гэж, 34 дүгээр зүйлийн 34.5 дахь хэсгийг “Энэ хуульд америк доллароор илэрхийлсэн зардлын тооцоог хийхдээ тухайн өдрийн Монголбанкнаас тогтоосон албан ёсны ханшийг баримтална.” гэж өөрчлөлт оруулсанаар хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөрийг америк доллараар бус төгрөгөөр тооцох, америк доллараар илэрхийлсэн зардлын тооцоог хийхдээ тухайн өдрийн Монголбанкнаас тогтоосон албан ёсны ханшийг баримтлахаар болсон.

Банкин дахь мөнгөн хадгаламжид баталгаа гаргах тухай хууль

Эрүүгийн хууль 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр шинэчлэн батлагдсантай холбоотойгоор Банкин дахь мөнгөн хадгаламжид баталгаа гаргах тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалтад “Эрүүгийн хуульд заасан банк, санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой гэмт хэрэг, авлига, албан тушаалын гэмт хэрэг, түүнчлэн терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр нотлогдсон этгээдийн өөрийн болон бусдын нэр дээр байршуулсан мөнгөн хадгаламж.” гэж өөрчлөлт оруулав.

Эрүүгийн хууль батлагдсантай холбоотойгоор Эрүүгийн хуулийн 20 дугаар бүлэгт заасан банк, санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой гэмт хэрэг, 28 дугаар бүлэгт заасан албан тушаалын гэмт хэрэг гэсэн заалтыг Эрүүгийн хуульд заасан банк, санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой гэмт хэрэг, авлига, албан тушаалын гэмт хэрэг гэж өөрчилсөн байна.

Зөрчлийн тухай хууль

Зөрчлийн тухай хууль 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдөр батлагдсантай холбоотойгоор Банкны тухай хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, Төв банк /Монголбанк/-ны тухай хууль, Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль, Зээлийн батлан даалтын сангийн тухай хууль, Зээлийн мэдээллийн тухай хууль, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль, Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Валютын зохицуулалтын тухай хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Эрдэнэсийн сангийн тухай хууль, Банкин дахь мөнгөн хадгаламжид баталгаа гаргах тухай хуулинд “Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.”, “Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.” гэж тус тус өөрчлөлт оруулав.

Зөрчлийн тухай хууль нь хууль, захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг зөрчилд тооцох, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах, шударга ёсны тогтолцоог бэхжүүлэхэд оршиж байгаа бөгөөд дээр дурдсан хуулиудыг зөрчсөн тохиолдолд Төрийн албаны тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэхээр болсон.

2.6 ОЛОН НИЙТИЙН САНХҮҮГИЙН СУУРЬ МЭДЛЭГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР (2015)

Хөтөлбөрийн үндэслэл

Санхүүгийн тогтвортой байдал нь иргэдээс санхүүгийн зах зээлд итгэх итгэлийг бататгах, бүх нийтийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх, санхүүгийн зах зээлд оролцогчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалах, санхүүгийн гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг багасгах гэсэн хоорондоо нягт уялдаа бүхий зорилтуудыг хэрхэн хангаж байгаагаар тодорхойлогддог. Санхүүгийн тогтвортой байдлыг дунд, урт хугацаанд хангах, санхүүгийн зах зээлийг хөгжүүлэхэд иргэдийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх асуудал ач холбогдол өндөртэй хэвээр байна. Зах зээл өргөжин тэлж, дэвшилтэт технологи олноор нэвтэрч, банк, санхүүгийн салбар хөгжин, санхүүгийн зуучлал гүнзгийрэхийн

хэрээр санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл төрөлжин олширсоор байна. Манай улсад иргэн, өрх гэрийн түвшинд санхүүгийн суурь мэдлэг хангалттай бус байгаагаас санхүүгийн буруу шийдвэр гаргаж эрсдэлд орох, энэ нь санхүүгийн салбарт сөрөг нөлөөлөл үүсгэх эрсдэлтэй байгаа нь энэхүү хөтөлбөрийг өргөн цар хүрээтэй, үр өгөөжтэй хэрэгжүүлэх шаардлагыг зүй ёсоор бий болгож байгаа юм.

Хөтөлбөрийн тухай

Иймээс Монголбанк, Сангийн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Санхүүгийн зохицуулах хороо хамтран Дэлхийн банкны техник туслалцааны хүрээнд “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх дунд хугацааны хөтөлбөр”-ийг боловсруулан Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөр 2015 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр дэмжин улмаар 10 дугаар сарын 07-ны өдрийн хамтарсан тушаалаар баталсан нь энэхүү хөтөлбөрийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх эхлэлийг амжилттай тавиад байна. Хөтөлбөрийг боловсруулахад дэлхийн хөгжлийн чиг хандлага, олон улсын туршлага төдийгүй өөрийн орны онцлог байдал, хүн амын санхүүгийн мэдлэгийн түвшинг харгалзан үзэж хөтөлбөрийн тэргүүлэх чиглэл, зорилго, үйл ажиллагааны төлөвлөгөө зэргийг тодорхойлов. Хөтөлбөрийг сургуулийн насанд санхүүгийн мэдлэг олгох, залуу үед санхүүгийн мэдлэг олгох, хөдөө орон нутгийн иргэдэд санхүүгийн мэдлэг олгох, цахим хуудас, олон нийтийн мэдээллийн хэрэгслэлээр санхүүгийн мэдлэг олгох дөрвөн тэргүүлэх чиглэлд хэрэгжүүлнэ.

Хөтөлбөрийн ач холбогдол

Иргэдийн санхүүгийн мэдлэг сайжрах нь эдийн засгийн бодит өсөлт болон ядуурлыг бууруулахад чухал нөлөөтэйгөөс гадна хэрэглэгчид, санхүүгийн үйлчилгээний салбар, засгийн газар, төв банк, бусад санхүүгийн зохицуулах үүрэг бүхий байгууллагууд, боловсрол олгогчид, ажил олгогч, ажиллагчид болон сайн дурын байгууллагууд зэрэг олон оролцогч талуудад ашиг тусаа өгөх юм.

Иргэдийн санхүүгийн боловсрол нэмэгдсэнээр дараах гол үр дүн гарна:

- Иргэдийн мэдлэг дээшилснээр санхүүгийн бүтээгдэхүүний худалдан авалт нэмэгдэнэ;
- Иргэд өөрийн хэрэгцээнд тохирсон, зөв бүтээгдэхүүн сонгох боломжтой болно;
- Санхүүгийн залилан, мэхлэлээс урьдчилан сэргийлэх явдал нэмэгдэж, түүнд өртөх иргэдийн тоо буурна;
- Иргэдийн хадгаламж нэмэгдэж, өр багасна;
- Хувь хүний ажлын бүтээмж нэмэгдэнэ;
- Хөрөнгийн зах зээлд оролцох иргэдийн тоо өснө;
- Ядуурал, гэмт хэрэг буурна.

Хөтөлбөр дараах 4 чиглэлээр хэрэгжинэ:

1. Сургуулийн насанд санхүүгийн мэдлэг олгох тэргүүлэх чиглэл

Үндэслэл: Хувь хүний санхүүгийн суурь ойлголттой болж, төлөвших нас нь хүүхэд наснаас эхэлдэг тул энэ үед санхүүгийн суурь ойлголтуудын талаар үнэн бодитой, зөв мэдээлэл өгөх нь чухал юм. Манай улсын хувьд дунд сургуульд хамрагдалтын түвшин өндөр байдаг тул хичээлийн хөтөлбөрөөр дамжуулан санхүүгийн мэдлэг олгоход бүхэл бүтэн үеийг хамруулж болох гол ач холбогдолтой. Хүүхдүүдийн санхүүгийн боловсрол дээшлэх нь эцэг эхийн санхүүгийн боловсролд эерэг нөлөө үзүүлдэг байна. Одоогийн байдлаар дунд сургуулийн сургалтын хөтөлбөрт санхүү, эдийн засгийн холбогдолтой сэдвүүд багтаж байгаа боловч харьцангуй макро эдийн засгийн хүрээний асуудлыг хамарсан, өрхийн болон хувийн санхүүг хэрхэн зөв зохистой удирдах талаар бага тусгагдсан. Үндэсний статистикийн хороо (ҮСХ)-оос хийсэн Ерөнхий боловсролын сургууль (ЕБС)-ийн Иргэний боловсролын сургалтад хийсэн үнэлгээ, мониторингийн сурах бичгүүдийн агуулгад хийсэн судалгаанаас харахад эдийн засгийн ойлголтууд дунд сургуулийн ахлах ангиудын сургалтын хөтөлбөрт багтсан байдаг боловч “Үйлдвэрлэгч ба хэрэглэгч”, “Мөнгө”, “Татвар”, “Эдийн засгийн тогтолцоо”, “Эдийн засаг, зах зээлийн эдийн засгийн тухай ойлголт”, “Эрэлт, нийлүүлэлт”, “Үнэ”, “Өрсөлдөөн”, “Ажилгүйдэл”, “Инфляци” зэрэг цөөн тооны макро эдийн засгийн сэдвүүдийг голлон хамарсан байна.

Авах арга хэмжээ:

- Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн хөтөлбөрт бага наснаасаа эхлэн хадгаламжтай болгох, хувийн санхүүгээ удирдаж сурах зэрэг санхүү, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах талаар анхан шатны ойлголт, мэдлэг өгөх агуулгыг багтаах;
- Боловсрол, соёл, шинжлэх ухааны яаманд Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт оруулахад техникийн туслалцаа үзүүлэх болон санхүүжилт олох талаар хамтарч ажиллах;
- Санхүүгийн мэдлэг олгох талаар ерөнхий боловсролын сургуулийн багш нарын чадавхыг нэмэгдүүлэх, мэргэшүүлэх сургалт зохион байгуулах, холбогдох ном, гарын авлагыг боловсруулах ажлуудыг хийх;
- Энэ хүрээнд ерөнхий боловсролын 10-р ангийн хичээлийн хөтөлбөрт “Бизнес судлал” хичээл нэмж оруулахаар БСШУ-ны сайдын 2015 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн А/424 тоот тушаалаар хөтөлбөр боловсруулах ажлыг хийж гүйцэтгэхээр болсон. Үүний дагуу “Бизнес судлал” хичээлийн хөтөлбөрийг БСШУЯ болон Монголбанк хариуцан ажиллаж байна.

2. Залуу үед санхүүгийн мэдлэг олгох тэргүүлэх чиглэл

Үндэслэл: Санхүүгийн голлох шийдвэр гаргаж, санхүүгийн зах зээлд идэвхтэй оролцож эхэлдэг үе нь залуу үе буюу 18-25 насныхан байдаг учраас энэхүү насны бүлэгт санхүүгийн мэдлэг олгох нь ач холбогдол өндөртэй байдаг. Манай улсын хувьд нийт хүн амын 30 гаруй хувийг 18-25 насны залуучууд эзэлж байна. 18-25 насныхны хувь ЕБС-ийн хөтөлбөр болон их сургуулийн сургалтын хөтөлбөрөөс санхүүгийн боловсролын талаар төдийлөн мэдээлэл аваагүйн дээр санхүүгийн бүтээгдэхүүний төрөл, хэрэглээ өргөжиж байгаа энэ үед тус зорилтот бүлэгт анхаарал хандуулах нь зайлшгүй чухал юм. Гэрлэлт, шинэ ажилд орох, шинээр бизнес эрхлэх зэрэг “амьдралын мөчлөгүүд” буюу хүн өөрийн амьдралдаа шууд тусган, шинэ мэдээлэл шингээж чадах үе нь залуу үед голчлон тохиолддог.

Авах арга хэмжээ:

- Оюутан залууст хичээлийн хөтөлбөрөөр дамжуулан санхүүгийн боловсрол олгох, их сургуулийн заавал үзэх суурь хичээлийн хөтөлбөрт санхүүгийн мэдлэг олгох сэдвээр тусгах талаар их сургуулиудтай хамтран ажиллах;
- Залууст зориулсан лекц, соёл, олон нийтийн үйл ажиллагааг хувийн хэвшил, төрийн бус байгууллагуудтай хамтран жил бүр уламжлал болгон зохион байгуулах;
- Шинэ, залуу гэр бүлд санхүүгийн мэдлэг олгох сургалтыг төрийн болон төрийн бус байгууллагаар дамжуулан хийх ажлууд багтана.

3. Хөдөө орон нутгийн иргэдэд санхүүгийн мэдлэг олгох тэргүүлэх чиглэл

Үндэслэл: Орон нутгийн иргэд хот суурин газартай харьцуулахад алслагдсан, мэдээлэл авах боломж бага байдгаас өөрт тохирсон санхүүгийн бүтээгдэхүүн сонгох, санхүүгийн бусад үйл ажиллагаанд оролцох зэрэгт хүндрэлтэй тулгардаг. Тэтгэврийн насанд хүрэх үедээ зориулж хуримтлал үүсгэх, зохистой санхүүгийн бүтээгдэхүүн сонгох талаар хөдөө орон нутагт ажиллаж амьдардаг малчид мэдлэг дутмаг байдаг.

Авах арга хэмжээ:

- Орон нутаг дахь төрийн болон төрийн бус байгууллагын сүлжээг ашиглан орон нутгийн иргэдэд санхүүгийн мэдлэг олгох;
- Санхүүгийн зах зээлтэй холбогдолтой аливаа хууль эрхзүйн мэдлэгийн түвшинг дээшлүүлэх, санхүүгийн суурь мэдлэг олгох, өөрсдийн эрх ашгийг хамгаалах, тохиромжтой санхүүгийн бүтээгдэхүүн сонгох зэрэг ур чадварыг нэмэгдүүлэх талаар тусгай албан бус сургалтын хөтөлбөр боловсруулан, орон нутгийн иргэдэд сургалт явуулах сургагч багш бэлтгэж, тусгайлсан сургалт зохион байгуулах;
- Орон нутаг дахь төрийн болон төрийн бус байгууллагын сүлжээгээр дамжуулан сургалт хийхэд зориулсан сургалтын гарын авлага, тараах материал боловсруулах;
- Санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр уулзалт зохион байгуулж, тухайн орон нутгийн захиргаа, холбогдох мэргэжлийн холбоодтой хамтран ажиллах зэрэг ажлууд хийгдэнэ.

4. Цахим хуудас, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр санхүүгийн мэдлэг олгох тэргүүлэх чиглэл

Үндэслэл: Сүүлийн жилүүдэд интернет хэрэглэгчид, ухаалаг утас хэрэглэгчдийн тоо сүүлийн жилүүдэд эрчимтэй өсч байгаа. Цахим хуудас, олон нийтийн мэдээллийн сүлжээгээр мэдээлэл түгээх нь бага зардлаар олон хүнийг хамруулах ач холбогдолтой байдаг. Санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх нэгдсэн цахим хуудас ажиллуулснаар иргэдийн санхүүгийн боловсролыг сайжруулах мэдээ, мэдээллээс гадна хөтөлбөрийн үйл ажиллагааны хэрэгжилтийг оролцогч талуудад мэдээлэх, үйл ажиллагаанд хяналт тавих боломж олгоно.

Авах арга хэмжээ:

- Цахим хуудсанд санхүүгийн суурь боловсрол олгох бүхий л төрлийн мэдээ, мэдээллүүдийг байршуулна. Энэ нь иргэдийн санхүүгийн чадамжийг дээшлүүлэхэд чиглэсэн мэдээллүүд байна. Түүнчлэн холбогдох төрийн болон төрийн бус байгууллагууд, эдийн засгийн чиглэлийн байгууллагуудаас гарсан төсөл хөтөлбөр, нийтлэл, ярилцлага зэрэг мэдээллүүдийг мөн багтаах юм;
- Холбогдох санхүүгийн тооцоолол хийх програмуудыг боловсруулж, санхүүгийн боловсролыг дэмжих нэгдсэн цахим хуудсанд байрлуулах;
- Цахим хуудсаар дамжуулан иргэдээс тогтмол санал асуулга авч, шаардлагатай мэдээллийн агуулгыг тодорхойлно;
- Телевиз, сонин, сэтгүүл, радио гэсэн уламжлалт хэвлэл мэдээллийн хэрэгслүүдтэй санхүүгийн боловсрол олгох зорилготой нийтлэл, нэвтрүүлэг бэлтгэн явуулах талаар хамтран ажиллах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэнэ.

Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөр хэрэгжсэнээр дараах үр дүнд хүрнэ:

- Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт санхүүгийн суурь мэдлэг олгох агуулгыг багтаах;
- Их, дээд сургуулийн оюутнуудын сургалтын хөтөлбөрт санхүүгийн мэдлэг олгох агуулгыг багтаах;
- Иргэдийн хувийн санхүүгийн талаар мэдлэг буюу хяналттай төсөвлөлт хийх, ирээдүйн хэрэгцээнд зориулж нөөц, хуримтлал үүсгэх, урьтаж байх, ирээдүйн тухай тунгаах чадамж дээшилсэн байна;
- Хадгаламжтай иргэдийн тоо нэмэгдсэн байна;
- Хөрөнгийн зах зээлд иргэдээс оруулж буй хөрөнгө оруулалт нэмэгдэнэ;
- Даатгалтай иргэдийн тоо нэмэгдсэн байна;
- Иргэдийн хугацаа хэтэрсэн, найдваргүй өрийн хэмжээ буурна;
- Нэг хүний хэрэглэх санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний дундаж тоо нэмэгдсэн байна;
- Санхүүгийн бүтээгдэхүүнийг мэдээлэл, мэдлэг дээр үндэслэн зөвөөр сонгох байдал нэмэгдэнэ;
- Санхүүгийн байгууллагуудын үзүүлж буй үйлчилгээний талаарх мэдлэг нэмэгдсэн байна;
- Санхүүгийн зах зээлд оролцогчдын хоорондох мэдээллийн урсгал сайжирсан байна;
- Санхүүгийн залиланд өртсөн иргэдийн тоо буурна гэсэн үр дүнгүүдийг хүлээж байна.

Хөтөлбөрийн үнэлгээ, хяналт

Хөтөлбөрийн үр дүнг үнэлэхдээ зорилтот хөтөлбөр нь зорилтот бүлэгт хүрч санхүүгийн мэдлэгийн түвшин нэмэгдсэн эсэх болон нөөцийг үр ашигтай зарцуулсан эсэхэд хяналт үнэлгээг төвлөрүүлэн хийх ба ингэснээр хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллагуудын үйл ажиллагааг цаашид сайжруулах боломж олгох юм. Мөн хөрөнгө оруулагчдад санхүүжилтийг хэрхэн зарцуулсан талаар мэдээллээр хангаж цаашдын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх ямар төрлийн үйл ажиллагаанд оруулах талаар шийдвэр гаргахад чухал үүрэгтэй.


3.1 ТӨВ БАНКНЫ ҮНЭТ ЦААС (ТБҮЦ)

Монголбанкнаас банкны системийн нөөцийг удирдах гол хэрэгсэл нь ТБҮЦ юм. Монголбанк банкны нөөцийн эрэлт, нийлүүлэлт дээр үндэслэсэн дараах 2 төрлийн ТБҮЦ-ыг банкуудад тогтмол арилжаалж байна. Үүнд:

- 7 хоногийн хугацаатай ТБҮЦ
- 28 хоногийн хугацаатай ТБҮЦ

ТБҮЦ-ны хүүг зах зээлийн зарчимд илүү нийцтэй болгох, төгрөг болон валютын захын өгөөжийн тэнцвэр тогтох боломжийг бүрдүүлэх зорилгоор 2013 оны 3 дугаар сараас эхлэн 7 хоногийн хугацаатай ТБҮЦ-ыг долоо хоногт гурван удаа арилжаалж байгаа бөгөөд 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар ТБҮЦ-ны нийт үлдэгдэл 1,026.8 тэрбум төгрөг байв. Үүний 93% -ийг 7 хоногийн хугацаатай, 7%-ийг 28 хоногийн хугацаатай ТБҮЦ эзэлж байна.

Зураг 45. Банкуудын эзэмшиж буй ТБҮЦ-ны үлдэгдэл (хугацаа, сар бүрээр)



Эх сурвалж: Монголбанк

3.2 ТӨВ БАНКНЫ САНХҮҮЖИЛТ

Монголбанкнаас мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх, банк хоорондын захын хүүг зохистой түвшинд удирдах зорилгоор банкны системд мөнгөн хөрөнгө нийлүүлэхдээ өдрийн зээл, овернайт репо санхүүжилт, репо арилжаа, барьцаат зээл зэрэг хэрэгслүүдийг ашиглаж байна. Эдгээр нь хугацаа, хэлбэр, хүү, зориулалтаараа ялгаатай юм. Монголбанкны санхүүжилтийн хэрэгслүүд бүгд барьцаа шаарддаг бөгөөд барьцаа нь Монголбанкны Эрсдэлийн удирдлагын албанаас гаргасан барьцааны жагсаалтад орсон актив байна. Тайлант онд Монголбанк өөрийн мөнгөний бодлогын хэрэгслүүдээр дамжуулан банкуудад нийт 3.1 их наяд төгрөгийн санхүүжилтийг олгосон бөгөөд үүний 76.6 хувь нь овернайт репо санхүүжилт, 13.6 хувь нь барьцаат зээл, үлдсэн 9.9 хувь нь өдрийн зээл байв.

Өдрийн зээл

Өдрийн зээл нь тухайн өдрөө эргэн төлөгддөг онцлогтой бөгөөд түүнийг төлбөр тооцооны хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор ашигладаг хүүгүй зээл юм. Тайлант онд Монголбанк нийт 322.5 тэрбум төгрөгийн өдрийн зээлийг банкуудад олгосон байна.

Овернайт репо санхүүжилт

Монголбанкнаас олгох овернайт репо санхүүжилт нь мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх, банк хоорондын захын хүүг зорилтот түвшинд хүргэх, банкуудад заавал байлгах нөөцийн шаардлага хангахад дэмжлэг үзүүлэх зорилгоор клирингийн гүйлгээ хаахаас дараагийн ажлын өдрийн клирингийн гүйлгээ нээх хүртэл хугацаагаар банкинд олгож байгаа санхүүжилтийн байнгын хэрэгсэл юм. Овернайт репо хүү нь Төв банкны хүүгийн коридорын дээд хязгаар болох ба бодлогын хүүн дээр 2 нэгж хувийг нэмсэнтэй тэнцүү байдаг бөгөөд 2015 онд нийт 2.5 их наяд төгрөгийн овернайт репо санхүүжилтийг Монголбанкнаас банкинд олгожээ.

Репо арилжаа

Төв банкны репо арилжаа гэж Монголбанкнаас зарласан арилжаагаар банкны эзэмшиж буй үнэт цаасыг тохиролцсон хугацааны эцэст урьдчилан тохиролцсон үнээр буцаан худалдах нөхцөлтэйгөөр худалдан авах хэлцлээр банкинд санхүүжилт олгох нээлттэй захын үйл ажиллагааг хэлнэ. Банкны системд хөрөнгийн дутагдал бий болсон, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар муудсан зэргээс шалтгаалан 7 хүртэл хоногийн хугацаатай санхүүжилтийг репо арилжаагаар олгодог. Тайлант онд Монголбанк репо арилжаагаар санхүүжилт банкуудад олгоогүй байна.

Барьцаат зээл

Монголбанк мөнгөний бодлого хэрэгжүүлэх, банкны төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг богино хугацаанд хангах зорилгоор эцсийн зээлдүүлэгчийн хувьд банкинд барьцаат зээл олгодог. Барьцаат зээлийн хүүг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2014 оны А-134 дүгээр тогтоолоор бодлогын хүү дээр нэмэх 2 хувь байхаар тогтоосон. Монголбанк 2015 онд нийт 443.0 тэрбум төгрөгийн барьцаат зээл олгосон бөгөөд 2015 оны эцсийн байдлаар 285.0 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.


3.3 ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААС (ЗГҮЦ)

Монголбанк нь Сангийн яамтай хамтран ЗГҮЦ-ны төгрөгийн өгөөжийн муруйг (BI1204) 2015 оны 9 дүгээр сард Блүмберг терминалд албан ёсоор байршууллаа. Ингэснээр дотоодын болон гадаадын хөрөнгө оруулагчид Монгол Улсын ЗГҮЦ-ны хугацаа бүрээр өгөөжийн мэдээллийг авах, судалгаа хийх, тус мэдээлэлд үндэслэн хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад дөхөм болж байгаа юм.


Өнөөдрийн байдлаар Худалдаа хөгжлийн банк, Төрийн банк, Улаанбаатар хотын банк, Хаан банк, Капитал банк, Хас банк, Голомт банкууд тус тус ЗГҮЦ-ны худалдах, худалдан авах үнэ болон өгөөжийг гурван хугацааны төрлөөр зах зээлд санал болгож, ЗГҮЦ-ны хоёрдогч захын арилжаанд хувь нэмрээ оруулан ажиллаж байна.

ЗГҮЦ-ны анхдагч захын үйл ажиллагаа

Зураг 46. Жигнэсэн дундаж хүү (12 долоо хоногтой ЗГҮЦ)



Зураг 47. ЗГҮЦ-ны үлдэгдэл



Эх сурвалж: Монголбанк

Хүснэгт 12. ЗГҮЦ-ны хоёрдогч захын үйл ажиллагаа

ЗГҮЦ-ын хоёрдогч захад хийгдсэн арилжааны дүн /багцын тогоор/			
/Огноо	i/ Богино хугацаат	ii/ Урт хугацаат	/i+ii/ Нийт
2015 оны 1 сар	22,500.00	10,000.00	32,500.00
2015 оны 2 сар	20,000.00		20,000.00
2015 оны 3 сар			-
2015 оны 4 сар	14,000.00	198,955.00	212,955.00
2015 оны 5 сар	16,000.00		16,000.00
2015 оны 6 сар	13,077.00		13,077.00
2015 оны 7 сар	10,500.00		10,500.00
2015 оны 8 сар	20,250.00		20,250.00
2015 оны 9 сар	18,088.00		18,088.00
2015 оны 10 сар	-		-
2015 оны 11 сар	5,000.00		5,000.00
2015 оны 12 сар	3,000.00		3,000.00
НИЙТ	142,415.00	208,955.00	351,370.00

Эх сурвалж: Монголбанк

Засгийн газрын санхүүгийн удирдлагыг сайжруулах, мөнгөний бодлогын арга хэрэгслийг нэмэгдүүлэх зорилгоор Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгчийн хамтарсан тушаалаар 2012 онд баталсан “ЗГҮЦ гаргах, арилжаалах журам”-ын дагуу 2015 онд анхдагч зах дээр нийт 77 удаагийн арилжааг зохион байгуулж, тайлант оны эцсийн байдлаар Монголбанкаар дамжуулан арилжаалсан ЗГҮЦ-ны идэвхтэй нийт үлдэгдэл 2.3 их наяд төгрөгт хүрэв. Түүнчлэн Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан тушаалаар 2013 онд батлагдсан “ЗГҮЦ-ыг хоёрдогч зах зээлд арилжих журам”-ын дагуу 2015 онд нийт 351.4 тэрбум төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий ЗГҮЦ хоёрдогч зах дээр арилжаалагдсан байна. Үүнээс 142.4 тэрбум нь Засгийн газрын богино хугацаат, 209.0 тэрбум нь Засгийн газрын урт хугацаат үнэт цаас байв.

3.4 ГАДААД ВАЛЮТЫН ДУУДЛАГА ХУДАЛДАА


Монголбанк төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь макро эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцэж, уян хатан тогтох, төгрөгийн тогтвортой байдал болон үндэсний эдийн засгийн тэнцвэртэй хөгжлийг дэмжих зарчмыг тууштай баримтлан, валютын эрэлт, нийлүүлэлтийн богино хугацааны зөрүүнээс үүссэн ханшийн огцом хэлбэлзлийг зөөлрүүлэх, захад оролцогчдын хүлээлтийг тогтворжуулах зорилгоор валютын захад шаардлагатай үед тухай бүр оролцоогоо идэвхтэй хадгалсаар ирлээ.

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2015 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн А-130 тоот тушаалаар гадаад валютын дуудлага худалдаанд “нэг ханшаар хийх арилжаа”-ны хэлбэрийг амжилттай нэвтрүүлсэн. Өөрөөр хэлбэл Монголбанкнаас гадаад валютын дуудлага худалдааг явуулахдаа “нэг ханшаар хийх арилжаа”, “ялгаатай ханшаар хийх арилжаа”-ны хэлбэрээс тухайн үеийн валютын захын нөхцөл байдалтай уялдуулан сонгох боломжтой болсон. Ингэснээр гадаад валютын дуудлага худалдааны хаалтын ханшаар дохио өгөх сувгийн нөлөөг нэмэгдүүлэх, гадаад валютын дотоодын захад оролцогчдын үйл хөдлөлд эерэгээр нөлөөлөх, улмаар гадаад валютын дуудлага худалдааны үр дүнг сайжруулж, ханшийн хэлбэлзлийг бууруулах ач холбогдолтой байна.


Гадаад валютын спот зах дахь оролцоо

2015 онд Монголбанк нийт 103 удаагийн гадаад валютын дуудлага худалдааг зохион байгуулж цэвэр дүнгээр 795.9 сая ам.доллар, 2,821.4 сая юань буюу 450.0 сая ам.доллартай тэнцэх хэмжээний юань, нийтдээ 1,246.0 сая ам.доллартай тэнцэх хэмжээний гадаад валютыг захад нийлүүлсэн байна. Энэ нь өмнөх онтой хяцуулахад нийт ам.долларын дуудлага худалдаа 39.6 хувь буюу 464.5 сая ам.доллараар, нийт юанийн дуудлага худалдаа 22.7 хувь буюу 132.1 сая ам.доллараар буурч, Монголбанкны валютын зах дахь оролцоо нийтдээ 32.4%-аар буюу 596.6 сам ам.доллараар буурсан байна.

Зураг 48. Ам.долларын дуудлага худалдаа




Зураг 49. Юанийн дуудлага худалдаа



Эх сурвалж: Монголбанк

Гадаад валютын зах дахь санхүүгийн үүсмэл хэрэгслээрх оролцоо

Зураг 50. Гадаад валютын своп хэлцэл



Эх сурвалж: Монголбанк

Монголбанк спот захад оролцохын зэрэгцээ банкууд болон тэдгээрийн харилцагчдын ханшийн эрсдэлийг бууруулах, богино хугацааны төлбөр түргэн гүйцэтгэх чадварт дэмжлэг үзүүлэх, спот зах зээлийн дарамтыг бууруулах зорилгоор банкуудтай богино хугацааны санхүүгийн үүсмэл хэрэгслийг идэвхитэй байгуулж ирсэн. Монголбанк 2015 онд нийт 3.3 тэрбум ам.доллартай хэмжээний төгрөгийн своп, 1.8 тэрбум ам.доллартай тэнцэх хэмжээний ам.долларын своп хэлцэл, 515.0 сая юанийн своп хэлцлийг банкуудтай тус тус байгуулсан байна. Богино хугацаат своп хэлцлийн нийт хэмжээ өмнөх оны мөн үеэс 20.5 хувь буюу 1.3 тэрбум ам.доллараар буурсан байна.


Урт хугацаат своп хэлцэл

2014 оны 1 дүгээр сард Монголбанк гадаад валютын орох урсгалыг нэмэгдүүлэх, зээлийн хүү, гадаад валютын зээлийн өсөлтийг бууруулах, гадаад валютын ханшийн эрсдэлээс хамгаалах тогтолцоог бий болгох зорилгоор урт хугацаат своп хэлцлийг шинээр нэвтрүүлсэн билээ. Энэхүү хэрэгслийн хүрээнд банкуудын гадаад зах зээлээс татсан нэгээс дээш жилийн хугацаатай эх үүсвэрт Монголбанкнаас ам.долларын урт хугацаат своп хэлцэл байгуулж байгаа бөгөөд тайлант онд нийт 745.0 сая ам.долларын дүнтэй урт хугацаат своп хэлцлийг байгуулж 14.0 сая ам.долларын дүнтэй урт хугацаат своп хэлцлийн төлбөр тооцоог гүйцэтгэснээр банкуудаас 731.0 сая ам.долларыг худалдан авч уг дүнгээр ГВУН-ийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүллээ.

3.5 ДОТООДЫН ЗАХ ЗЭЭЛЭЭС АЛТ ХУДАЛДАН АВАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх дотоодын эх үүсвэрүүдийн нэг нь алт худалдан авалт юм. Монголбанк нь дотоодын алт олборлогч аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс худалдан авсан алтыг гадаадын байгууллагуудад олон улсын жишигт хүргэн цэвэршүүлэн мөнгөжүүлж, гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг тогтмол эрхэлж байна. Энэ ажлын хүрээнд тайлант онд Монголбанк 87 аж ахуйн нэгж, 141 иргэнээс нийт 15.1 тонн алтыг 916.4 тэрбум төгрөгөөр худалдан авсан нь өмнөх оноос 2.4 тонн буюу 1.2 дахин өссөн үзүүлэлт юм. 2015 онд Монголбанк нийт 13 тонн алт цэвэршүүлж, гадаад валютын улсын нөөцийг 396.0 сая ам.доллараар нэмэгдүүллээ. (Зураг 51).

Зураг 51. Монголбанкны 2014-2015 онуудад худалдан авсан алтны хэмжээ (кг-аар)



Эх сурвалж: Монголбанк

4.1 МОНГОЛБАНКНЫ БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО

Бүтэц, зохион байгуулалт

- Олон нийтийн мэдээллийн ил тод байдлыг хангах, ард иргэдийн эдийн засгийн боловсролыг дээшлүүлэх зорилго бүхий “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх дунд хугацааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд Монголбанкны Олон нийттэй харилцах хэлтэс Олон нийтийн боловсрол мэдээллийн төв болж бүтцийн өөрчлөлт хийн үйл ажиллагаа, чиг үүргийн хувьд өргөжин тэлээд байна. Энэхүү хөтөлбөр нь Монголбанкны Ерөнхийлөгч Н.Золжаргалын санаачлагаар Монголбанк, Сангийн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам болон Санхүүгийн зохицуулах хорооны хамтарсан тушаалаар 2015 оны 10 дугаар сарын 07-ны өдөр батлагдсан. Хөтөлбөрийг (1) сургуулийн нас, (2) залуу үе, (3) орон нутгийн иргэд болон (4) цахим хуудас, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл гэсэн нийт 4 тэргүүлэх чиглэлд хэрэгжүүлнэ.
- Монголбанкны газар хоорондын албан бичгийн автоматжуулсан ESYS програмыг өөрсдийн инженерүүд боловсруулан нэвтрүүлсэн нь цаасны хэрэглээг багасгасан, цаг хугацаа хэмнэсэн чухал арга хэмжээ болсон. Үүний сацуу орон нутаг дахь Монголбанкны салбар, хэлтсээс хүний нөөцийн e-Office програмд шууд хандан мэдээлэл оруулдаг болсноор байгууллагын үндсэн мэдээллийн сангийн ашиглалт сайжирсан ба эдгээр удирдлага, зохион байгуулалтын оновчтой шийдлийн үр дүнд хөдөлмөрийн бүтээмж дээшилсэн.
- Өмнөговь аймагт шинээр баригдаж ашиглалтанд орсон Монголбанкны хэлтсийн барилга нь агуулахын тоног төхөөрөж, сургалтын өрөө, хурлын танхим зэрэг орчин үеийн банкны барилгын шийдэлтэй тул ажиллах орчин, нөхцөлийг дээд зэргээр бүрдүүлсэн.

Хүний нөөцийн бодлого

Төрийн мөнгөний бодлого боловсруулж, хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцөөр хангах, ажилтнуудыг тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд Монголбанкны хүний нөөцийн бодлого чиглэгддэг. Тайлант хугацаанд боловсон хүчний мэдлэг, ур чадварыг системтэй дээшлүүлэх зорилгоор сургалтын хөтөлбөрийг боловсруулан ажилтнуудаа дотоод, гадаадын сургалт, семинарт хамрууллаа. Ийнхүү сургалтын хөтөлбөрийн дагуу 210 удаагийн богино хугацааны гадаад дотоодын сургалт, семинарт ажилтнуудыг хамруулсан ба 60 удаагийн олон улсын бага болон ээлжит хурал, уулзалтад удирдах ажилтнууд оролцсон.

Орон нутаг дахь хэлтэс, салбарын захирал, хянан шалгагч, нягтлан бодогч, няравуудын сургалтыг тогтмол зохион байгуулдаг бөгөөд 2015 оны хувьд няравуудын семинарыг Польшийн төв банктай, “Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт” сэдэвт сургалтыг Бундесбанкны Техник туслалцаа хамтын ажиллагааны төвтэй хамтран Улаанбаатар хотноо зохион байгуулсан. Эдгээр сургалтын үр өгөөжийг дээшлүүлэх зорилгоор Монголбанкны төв аппарат болон орон нутгийн салбар хэлтсийн ажилтнуудыг оролцуулсан. Үүний сацуу салбарын захирлуудаас Чехийн төв банкинд мөнгөн тэмдэгтийн менежментийн чиглэлээр сургав.

Монголбанкны төлөөлөлөгчид Японы төв банкинд албан айлчлал хийж хоёр талын цаашдын хамтын ажиллагааны чиглэлээр санал солилцон Олон нийтийн боловсрол, мэдээллийн төвийг бэхжүүлэх чиглэлээр хамтран ажиллахаар шийдвэрлэсэн.

Спорт, олон нийтийн хорооноос ажилтнуудын дунд гүйлтийн марафон, цасны баяр, явган аялал зэргийг зохион байгуулсан. Монголбанкны баг тамирчид УИХ-ын харьяа болон банкны системийн байгууллагуудын дунд зохион байгуулагддаг биеийн тамирын уралдаан тэмцээнд амжилттай оролцсон. Банк, санхүүгийн системд үр бүтээлтэй ажилласан ажилтнуудыг Төрийн одон медаль болон Монголбанкны шагналаар урамшууллаа. Холбогдох хууль, журмын дагуу нөхөн олговор, тусламж, тэтгэмжийг олгож байна.

4.2 ГАДААД ХАРИЛЦАА

Монголбанк гадаад харилцааны бодлогын хүрээнд Монголын банк, санхүүгийн тогтолцоог хөгжлийн өндөр түвшинд хүрсэн орнуудын нийтлэг жишигт нийцүүлэн боловсронгуй болгох, олон улсын банк санхүүгийн байгууллагуудтай холбоо тогтоон гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх үүднээс үр ашигтай түншлэлийг бий болгох зорилт тавин ажиллаж байна. Үүний дагуу БНХАУ, ХБНГУ, Япон, БНПУ-ын Төв банк болон олон улсын банк, санхүүгийн байгууллагуудтай харилцаа хамтын ажиллагаагаа өргөжүүлж ажиллаа.

Гадаад харилцааны чиглэлээр хийгдсэн ажлуудыг тоймлон дурдвал:

- Монголбанкны Ерөнхийлөгч 2015 оны 3 дугаар сард БНХАУ-ын Ардын Банкны Ерөнхийлөгч Жоу Шиачуантай уулзаж Төв банкууд хооронд байгуулсан үндэсний мөнгөн тэмдэгт харилцан солилцох своп хэлцлийн гэрээний хэрэгжилт, үр дүнгийн талаар хэлэлцсэн. Свop хэлцэл нь хоёр орны гадаад худалдааг тогтвортой байлгах, бүсчилсэн шинжтэй гарч буй гадаад секторын эрсдэлийн сөрөг нөлөөллийг зөөлрүүлэхэд зохих хувь нэмрээ оруулж байгааг статистик үзүүлэлтүүд баталж байгаа бөгөөд Монголбанк своп хэлцлийг төлбөрийн тэнцлийн хүндрэлтэй үед макро эдийн засгийн гадаад тэнцвэрийг хадгалахад амжилттай ашигласан тухай талууд онцлон тэмдэглэв.

Мөн оны 11 дүгээр сард Монголбанк, Хятадын Ардын Банк (ХАБ)-тай хамтран БНХАУ-ын Шиаман хотноо “Монгол Улс, БНХАУ-ын хил худалдааны төлбөр тооцооны 6 дахь удаагийн дугуй ширээний уулзалт”-ыг амжилттай зохион байгуулсан. Уулзалтад хоёр улсын Төв банкны төлөөлөгчид болон Монголын талаас 8 арилжааны банк, БНХАУ-ын талаас 9 арилжааны банк тус тус оролцож, банк, санхүүгийн салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх, төлбөр тооцооны үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр харилцан санал солилцсон. Уулзалтын үр дүнд олон жилийн турш давтагдаж ирсэн арилжааны банкуудын гадаад гүйлгээний төлбөр тооцоо дахь үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах арга замыг тодорхойлсон бөгөөд шинээр БНХАУ-ын банкуудад төгрөгийн зээл гаргах, зээлийн мэдээллийг харилцан солилцох зэрэг салбарт хамтран ажиллахаар тохиролцоонд хүрсэн нь банк, санхүүгийн салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх томоохон алхам болов.

- “Монгол Улс, ОХУ-ын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг 2011-2015 онд хөгжүүлэх хөтөлбөр”-т хоёр улсын төв банкны хамтын ажиллагааг идэвхжүүлэхээр тусгасны дагуу Монголбанкаас ОХУ-ын төв банктai үндэсний мөнгөн тэмдэгт харилцан солилцох своп хэлцэл байгуулах саналыг 2010 оноос хойш удаа дараа тавьж ирсэн билээ. Энэ ажлын хүрээнд 2015 оны 1 дүгээр сард Монголбанкнаас ОХУ-ын төв банкинд своп хэлцэл байгуулах саналыг хүргүүлсэн боловч уг асуудлаар Сангийн яамтайгаа зөвшилцөх, Засгийн газраас зөвшөөрөл авах шаардлагатай талаар Монголбанкинд мэдэгдсэн.

Үүний дараа 2015 оны 11 дүгээр сард ОХУ-д зохион байгуулагдсан “Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагаа”-ны Монгол Улс, ОХУ-ын Засгийн газар хоорондын комиссын ээлжит 19 дүгээр хуралдаанд Монголбанкны төлөөлөл оролцсон бөгөөд “Үндэсний мөнгөн тэмдэгт солилцох төгрөг, рублийн своп хэлцэл” байгуулах саналыг дахин тавьсан. Энэ үеэр ОХУ-ын төв банк, Сангийн яамнаас ОХУ-ын үндэсний мөнгөн тэмдэгт рублийн ханшийн тогтворгүй, төгрөгийн хэрэглээ хязгаарлагдмал байгаа зэрэг нь ОХУ-д ханшийн эрсдэл, зээлийн эрсдэлийг тус тус бий болгож байгаа тул өнөөгийн нөхцөлд Монгол Улстай “Үндэсний мөнгөн тэмдэгт солилцох своп хэлцэл” байгуулах боломжгүй хэдий ч уг асуудлын талаар хоёр улсын арилжааны банкууд, төв банк хамтарсан дугуй ширээний анхдугаар уулзалтыг ОХУ-д 2016 оны 7 дугаар сард зохион байгуулах үеэр дахин хэлэлцэх боломжтой талаар мэдэгдсэн. Иймд Монголбанкнаас 2016 оны 7 дугаар сард зохион байгуулах дугуй ширээний уулзалтын бэлтгэл ажлыг хангахаар ажиллаж байна.

- Монголбанкны Ерөнхийлөгч 2015 оны 11 дүгээр сард Зүүн өмнөд Азийн төв банкуудын холбоо (ЗӨАТБХ)-ны Ерөнхийлөгч нарын 51 дэх удаагийн дээд хэмжээний зөвлөгөөн болон Холбооны Ерөнхийлөгч нарын Зөвлөлийн 34 дэх удаагийн уулзалтад оролцсон. Уг арга хэмжээнд ЗӨАТБХ-ны гишүүн, ажиглагч нийт 24 орны Төв банкуудын Ерөнхийлөгчид оролцож олон улсын санхүүгийн зах дээр үүсээд байгаа хүндрэл, санхүүгийн эх үүсвэр буурч байгаа байдал, АНУ-ын долларын хүү нэмэгдэх зэрэг эрсдлүүд, байгалийн баялаг экспортлодог орнуудын эдийн засгийн өсөлт суларч, эрэлт хумигдаж байгаа талаарх асуудлуудыг хэлэлцэж Төв банкуудын хамтын ажиллагааг нягтруулах, хүндрэл тулгарах үед ашиглах хэрэгслүүдээ нэмэгдүүлэх нь чухал гэдэгт санал нэгдсэн.
- Монголбанк, Зүүн өмнөд Азийн Төв банкуудын холбооны Судалгаа, сургалтын төвтэй хамтран 2015 оны 6

дугаар сард “Мөнгөний бодлого тодорхойлоход санхүүгийн зах зээлээс мэдээлэл цуглуулах, ашиглах” сэдэвт сургалтыг Улаанбаатар хотноо амжилттай зохион байгуулсан. Санхүүгийн томоохон бодлого тодорхойлоход санхүүгийн мэдээллүүдийг хэрхэн цуглуулах, ашигтай мэдээлэлд дүн шинжилгээ хийсний үр дүнд бодлого боловсруулах, санхүүгийн зах зээлийн оновчтой бодлогыг төлөвлөхөд санхүүгийн мэдээллийг солилцох, ашиглалтыг сайжруулах зорилготой энэхүү сургалтад БНСУ, БНХАУ, Малайз, Тайланд зэрэг 14 орны Төв банкны 30 гаруй төлөөлөл оролцож мэдлэг туршлагаа солилцож, илтгэл хэлэлцүүлсэн.

- Монголбанк, Азийн хөгжлийн банкттай хамтран 2015 оны 11 дүгээр сард “Санхүүгийн салбарын активын удирдлагын бүтцийг төрөлжүүлэх, хоёрдогч зах зээлийг хөгжүүлэх замаар санхүүгийн тогтвортой байдлыг хангах” сэдэвт Олон улсын төрийн өмчийн активын удирдлагын форумыг Улаанбаатар хотноо амжилттай зохион байгуулсан. Монголбанк санхүүгийн салбарын чанаргүй активыг хоёрдогч зах зээлд борлуулах, зөв зохистой удирдах, урт хугацаанд уг үйл ажиллагааг тогтвортой хэрэгжүүлэх бүтцийг бий болгох асуудалд онцгой анхаарал хандуулан ажилладаг. Тус форумд Азийн хөгжлийн банк, БНХАУ, Тайланд, БНСУ-ын хөрөнгийн удирдлагын корпораци, БНСУ-ын хадгаламжийн даатгалын корпорацийн төлөөлөл болон Монголын талаас Сангийн яам, Хадгаламжийн даатгалын корпораци, Монголын банкны холбоо болон арилжааны банкуудын төлөөлөл оролцон активын удирдлагын үйл ажиллагааг Монгол Улсын санхүүгийн салбарын бүтэц, онцлог, хууль эрх зүйн орчин зэрэг хүчин зүйлүүдэд нийцүүлэн хэрхэн оновчтой нэвтрүүлэх талаар хэлэлцсэн.

4.3 ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ ХАРИЛЦАА

Монголбанкны олон нийттэй харилцах харилцаа нь Төв банкны /Монголбанкны/ тухай хуулийн 34 дүгээр зүйл болон хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох хууль тогтоомж түүнд нийцсэн дүрэм, журмаар зохицуулагддаг. 2015 онд төв банкны олон нийтийн харилцааг төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэл, Мөнгөний бодлогын зөвлөл (МБЗ)-ийн шийдвэр гаргалт, Монголбанкны үйл ажиллагааны тайлан мэдээллийг нийтэд тайлбарлан таниулах, ил тод байдлыг шуурхай хангах замаар төв банкинд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлж, инфляцийн хүлээлтийг эерэгээр удирдахад чиглүүлж ажиллаа.

Мөнгөний бодлогын ил тод байдал ба шийдвэр гаргалт

2015 онд МБЗ-ийн 4 удаагийн хурлаас 2015/01; 2015/02; 2015/03 тоот мөнгөний бодлогын мэдэгдэл гаргасныг Монголбанкны цахим хуудсанд тухай бүр англи орчуулгын хамт байршуулан олон нийтэд мэдээлэв. Бодлогын хүү, бусад арга хэрэгслийн өөрчлөлтийг тухай бүр нийтэд мэдээлэхийн зэрэгцээ төв банкны үйл хөдлөлийг таамаглахуйц болгох, санхүүгийн захын шийдвэр гаргах хүлээлтэд эерэг нөлөө үзүүлэх үүднээс тухайн жилийн МБЗ-ийн хурлын тов, хурлын хураангуй тэмдэглэлийг олон нийтэд нээлттэй байршуулдаг уламжлалтай.

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2015 онд баримтлах үндсэн чиглэлийн хэрэгжилтийг улирал бүр УИХ-д тогтмол тайлагнаж, Засгийн газарт хүргүүлж ажиллав. Төсөв мөнгөний бодлогын харилцан уялдаа, санхүүгийн тогтвортой байдал болон Монголбанкны үйл ажиллагааны талаар иргэдэд тайлбарлан таниулах, сурталчлах ажлыг зохион байгуулж ажиллав. Энэ хүрээнд Монголбанк анх удаа эдийн засгийн бодлогын шинжилгээ, төсөөлөл бүхий “Инфляцийн төлөв байдлын тайлан”-г бэлтгэн улирал тутам УИХ-ын ЭЗБХ-нд хүргүүлж, нийтэд мэдээлдэг болсон. Эдийн засгийн чиглэлийн 87 сэтгүүлчийн мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх 10 долоо хоногийн сургалтыг холбогдох газруудтай хамтран зохион байгуулж, идэвхтэй хамрагдсан 37 сэтгүүлчид сертификат олгов. Их дээд болон ерөнхий боловсролын сургууль, албан газруудад зочлон 18 удаа илтгэл, хэлэлцүүлэг хийв. Үүнд давхардсан тоогоор 1300 орчим оюутан, сурагч, иргэд хамрагдаад байна.

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2016 онд баримтлах үндсэн чиглэлийн төслийг УИХ-д хүргүүлж, нэгдсэн хуралдаанд танилцуулсан Монголбанкны Ерөнхийлөгчийн хэлсэн үг, үндсэн чиглэлийн төслийн хамт өөрсдийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд хүргэж ажиллав. Нам, тогтвортой инфляцийг зорьсон мөнгөний бодлогын үндсэн чиглэлийн төслийг боловсруулсан үндэслэл, шалтгаан болон хүлээгдэж буй үр дүнг хэвлэл мэдээллийн байгууллага, санхүүгийн зах зээлийн оролцогч, олон нийтэд таниулах ажлыг зохион байгуулав.

Монголбанкны үйл ажиллагааны тайлан мэдээлэл

Монголбанкны цахим хуудсанд 2015 онд нийт 1.42 сая (давхардсан тоо) хэрэглэгч хандаж, хэрэгцээт мэдээллээ авсан байна. Энэ хугацаанд өөрсдийн цахим хуудасны аюулгүй байдлыг хангаж ажиллахын зэрэгцээ хэрэглэгчийн гар утас, таблет зэрэг төхөөрөмжид зориулсан уян (responsive) хувилбарыг бүтээж, нийтийн хэрэгцээнд нэвтрүүлэв.

Монголбанкны бодлого, үйл ажиллагаатай холбоотой 2800 гаруй цаг үеийн болон статистик мэдээлэл шинээр нэмэгдэж, 50 гаруй тогтмол мэдээлэл шинэчлэгдсэн байна. Цахим хуудсанд шинээр “шилэн данс”, “инфляцийн төлөв байдлын тайлан”, “макро эдийн засгийн статистик мэдээллийн нэгдсэн сан”, “эдийн засаг, санхүүгийн нэр томьёоны тайлбар толь” цэсүүд үндсэн болон дэд байдлаар нэмэгдэв.

Монголбанкны 2014 оны жилийн тайлан, судалгааны ажил-товхимол 10, Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдлын тайлан №05 ба №06, Төрөөс мөнгөний бодлогын талаар 2016 онд баримтлах үндсэн чиглэлийн төсөл, эдийн засаг санхүүгийн нэр томьёоны тайлбар толь, сэтгүүлчдийн сургалтын гарын авлагыг эмхэтгэн хэвлүүлж, УИХ, Засгийн газар, Монголбанкны орон нутгийн хэлтэс, салбар болон холбогдох төрийн болон хувийн хэвшил, банк, санхүүгийн байгууллага, их дээд сургуулиудад түгээж ажиллав. Эдгээр хэвлэмэл бүтээгдэхүүнүүдийг өөрсдийн цахим хуудсанд тухай бүр тогтмол байршууллаа.

- Оюутан залуусын эрдмийн бүтээлийг дэмжих, судалгаа шинжилгээ хийх чадварыг нь хөгжүүлэх зорилт бүхий Монголбанкны нэрэмжит эрдэм шинжилгээний бага хуралд мөнгөний бодлого, инфляци, банк, санхүүгийн чиглэлээр 20 гаруй судалгааны ажлын бүтээл ирсэн. Үүнээс эхний шатанд шалгарсан 10 бүтээлийг 2015.05.25-ний өдөр хэлэлцүүлж, шилдэг эдийн засгийн илтгэлийг шалгаруулав.
- 2015 онд гадаад, дотоодын 2331 иргэн “Монголбанкны үйл ажиллагаатай танилцах экскурс” хөтөлбөрт хамрагдаж, эрдэнэсийн сангийн үзмэртэй танилцахын зэрэгцээ төв банкны ил тод хариуцлагатай хараат бус байдлын ач холбогдлын талаар мэдээлэл авсан болно.
- Мөнгөний бодлого, Монголбанкны үйл ажиллагаа, макро эдийн засгийн цаг үеийн асуудлаар асуудлаар нийт 134 удаа хэвлэл мэдээллийн байгууллагад ярилцлага, тодруулга өгч сэтгүүлчид, олон нийтийг бодит мэдээллээр хангаж ажиллав.
- 2015 онд 1300 гаруй гадаад, дотоодын иргэн, аж ахуй нэгжийн сонирхсон асуултад мэдээлэл, зөвлөгөө өгч, санал хүсэлтийг шийдвэрлэж ажиллав. Эдгээрээс дийлэнхи нь суурин утсаар бидэнтэй холбогдсон бөгөөд биечлэн уулзах, албан бичгээр хандах (123ш), Засгийн газрын 11-11 төвөөр дамжуулан хандах, цахим шуудан (93ш), нийгмийн сүлжээгээр дамжуулан хандах замаар санал хүсэлтээ илэрхийлсэн юм.

4.4 МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ АРГА ХЭМЖЭЭ

Мөнгө угаахтай тэмцэх Ази Номхон далайн бүсийн байгууллагаас 2016 онд Монгол Улсын Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог үнэлэхтэй холбоотой Харилцан үнэлгээнд бэлтгэх, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбогдох Үндэсний эрсдэлийн үнэлгээний тайланг холбогдох эрх бүхий байгууллагуудтай хамтран бэлтгэх ажлын хүрээнд шаардлагатай арга хэмжээг авч ажиллаа.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулиар олгогдсон чиг үүргийг хэрэгжүүлэх болон дээр дурдсан Харилцан үнэлгээ, Эрсдэлийн үнэлгээнд бэлтгэх зорилгоор СМА нь дараах үйл ажиллагааг хийж гүйцэтгэв.

Хяналт шалгалтын чиглэл :

- МУТСТ тухай хяналт шалгалтын тогтолцоог сайжруулах зорилгоор зайнаас хяналт тавих болон газар дээрх хяналт шалгалтын журмыг шинэчлэн батлуулсан.
- ОУВС-ийн техник тусалцааны хүрээнд ХШГ-тай хамтарсан хяналт шалгалтыг бүх арилжааны банкинд хийж гүйцэтгэсэн.
- МУТСТ тогтолцоог үнэлэх зорилготой Монголбанк болон эрх бүхий байгууллагаас бүрдсэн харилцан үнэлгээний ажлын хэсэг, “Үндэсний эрсдэлийн үнэлгээ” хийх дэд ажлын хэсэг тус тус байгуулсан.
- Эрсдэлийн үнэлгээ хийх ажлын хүрээнд мэдээлэх үүрэгтэй этгээдүүдээс холбогдох мэдээллийг цуглуулж сан бүрдүүлэн, мэдээллийг боловсруулж байна.
- Харилцан үнэлгээ хийх үйл ажиллагаатай холбоотой дараах бичиг баримтыг Монгол хэл рүү хөрвүүлэн үнэлгээнд бэлтгэх ажлын хэсэг болон бусад холбогдох байгууллагад хүргүүлж харилцан үнэлгээний бэлтгэлд ашиглаж байна. Тухайлбал:

- о ФАТФ-ын зөвлөмжийн техникийн хэрэгжилт болон МУТСТ тогтолцооны үр дүнтэй байдлыг үнэлэх аргачлал;
- о ФАТФ-ын улс төрд нөлөө бүхий этгээдтэй холбоотой зөвлөмж;
- о ФАТФ-ын ил тод байдал болон эцсийн өмчлөгчтэй холбоотой зөвлөмж.
- ОУВС-ийн техник туслалцааны хүрээнд банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд хийх хяналт шалгалтын тогтолцоог сайжруулах зорилготой төслийг СЗХ дээр хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн.

Дүн шинжилгээ хийх чиглэлд:

- Арилжааны банкнаас ирүүлдэг бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээний тайланг онлайнаар хүлээн авах үйл ажиллагааг нэвтрүүлсэн.
- СМА-ны програм хангамжийг МТГ-тай хамтран боловсруулж байна.
- Эрх бүхий байгууллагуудтай мэдээлэл солилцох болон үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор хамтран ажиллаж байна.

СМА нь хуулийн хэрэгжилтэд хяналт тавих үүргийнхээ хүрээнд 2013-2015 онуудад банкны салбарт газар дээрх хяналт шалгалтыг дараах байдлаар хийсэн. Түүнчлэн СЗХ-той нягт хамтран ажиллаж, шаардлагатай мэдээлэл болон ажлын туршлага солилцон ажиллаж байна.

Хүснэгт 13. МУТСТ чиглэлээр хийсэн хяналт шалгалт

Үзүүлэлт	2013 он	2014 он	2015 он
Банкинд хийсэн хяналт шалгалт	0	10	12
Банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд хийсэн хяналт шалгалт	163	151	116
Банк болон банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд тавигдсан акт	2	151	4
Банк болон банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд өгсөн хугацаат үүрэг даалгавар	77	295	213

Эх сурвалж: Монголбанк, СМА

Тус алба нь МУТСТ тухай шинэчлэн батлагдсан хуулийн дагуу мэдээлэх үүрэгтэй этгээдээс холбогдох тайлангуудыг хүлээн авч ажиллаж байна.

Хүснэгт 14. СМА-нд мэдээлэх үүрэгтэй этгээдээс ирүүлсэн тайлангуудын тоо

Үзүүлэлт	2013 он	2014 он	2015 он
Сэжигтэй гүйлгээний тайлан	285	212	113
Бэлэн мөнгөний гүйлгээний тайлан	755,499	1,962,408	1,223,984
Гадаад төлбөр тооцооны гүйлгээний тайлан	60,274	149,682	86,329
Гаалийн мэдүүлгийн тайлан	3,259	2,347	1,917

Эх сурвалж: Монголбанк, СМА

2015 онд 113 сэжигтэй гүйлгээний тайлан, нийт өссөн дүнгээрээ 964 сэжигтэй гүйлгээний тайлан хүлээн авсан байна. Энэ нь 2014 онтой харьцуулвал 47 хувиар буурсан тоон үзүүлэлттэй байна. Харин бэлэн мөнгөний гүйлгээний тайлан болон гадаад төлбөр тооцооны гүйлгээний тайлангийн нийт тоог өмнөх онтой харьцуулан үзвэл ойролцоогоор 38 хувиар буурсан дүнтэй байна. Уг бууралт нь бэлэн болон гадаад төлбөр тооцооны гүйлгээний тайланг тодорхойлох аргачлалд өөрчлөлт орсонтой холбоотой юм.

Санхүүгийн мэдээллийн албаны үйл ажиллагааны үндсэн чиг үүрэг бол мэдээлэх үүрэгтэй этгээдээс ирүүлсэн сэжигтэй гүйлгээний тайлангуудад дүн шинжилгээ хийж, мөнгө угаах эсвэл терроризмыг санхүүжүүлэх үндэслэлтэй байх тохиолдолд хуулийн байгууллагад шилжүүлж шалгуулах үйл ажиллагаа юм. Тайлант хугацаанд

СМА нь дотоодын хууль сахиулах байгууллагуудын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон бусад гэмт хэргээс олсон орлогыг илрүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн санхүүгийн мэдээлэл солилцож, хуулийн хүрээнд хамтран ажилласан.

Хүснэгт 15. СМА-ны санхүүгийн мэдээлэл солилцсон статистик

Үзүүлэлт	2013 он	2014 он	2015 он
Дүн шинжилгээ хийгдсэн болон хийгдэж буй Сэжигтэй гүйлгээний тайлан	180	275	209
СМА-наас дотоодын хууль сахиулах байгууллагуудад шалгуулахаар шилжүүлсэн мэдээлэл	10	6	27
Мэдээлэл авах зорилгоор дотоодын эрх бүхий байгууллагуудаас СМА-нд ирүүлсэн хүсэлт	1197	634	1248
Дотоодын эрх бүхий байгууллагуудаас СМА-нд ирүүлсэн хүсэлтийн дагуу явуулсан хариу	1,066	631	1,241

Эх сурвалж: Монголбанк, СМА

СМА нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар олон нийтийн дунд мэдээлэл сурталчилгаа явуулах чиг үүргээ хэрэгжүүлэх хүрээнд тайлант хугацаанд дангаараа болон бусад байгууллагатай хамтран нийт 1022 оролцогчдыг хамарсан 24 сургалт зохион байгуулсан. Үүнээс 30 оролцогчдыг хамарсан 1 удаагийн сургалтыг СМА, 992 оролцогчыг хамарсан 23 удаагийн сургалтыг бусад байгууллагатай хамтран зохион байгуулжээ.

2015 онд зохион байгуулсан сургалтууд нь өмнөх онтой харьцуулбал илүү олон чиглэлийг хамарсан байна. Үүнд:

- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог сайжруулах;
- Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний стратегийг боловсруулах;
- Харилцан үнэлгээ хийх аргачлал;
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тогтолцоог сайжруулах;
- Олон улсын стандартыг танилцуулах;
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхтэй холбоотой батлагдсан хууль, журам зааврын танилцуулга.

Олон улсын Санхүүгийн мэдээллийн албадын холбоо болох Эгмонт бүлгийн гишүүний хувьд СМА нь бусад орны Санхүүгийн мэдээллийн албадтай мэдээлэл солилцож, Монгол Улсаас гадаад руу гарсан, эсвэл гадаад орноос Монгол Улсад орж ирсэн хууль бус мөнгөний урсгал, гэмт хэргээс олсон орлогыг олж илрүүлэхтэй холбоотой хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажилласан болно.

4.5 ДОТООД ХЯНАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Монголбанкны Дотоод хяналт, үйл ажиллагааны эрсдэлийн газар (ДХҮАЭГ) нь Дотоод хяналт, шалгалтын хэлтэс (ДХШХ), Үйл ажиллагааны эрсдэлийн хэлтэс (ҮАЭХ) гэсэн хоёр хэлтэстэйгээр ажиллаж байна. ДХШХ нь Монголбанкны бүтцийн нэгжүүдэд төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд явуулж буй эсэхэд хяналт тавьж, аливаа зөрчлийг илрүүлэн холбогдох арга хэмжээг авах, үүрэг даалгавар өгөх, удирдлагыг мэдээллээр хангах чиг үүргийг, ҮАЭХ нь Монголбанкны үйл ажиллагаанд учирч болзошгүй аливаа эрсдэлийг тогтоох, хянах, урьдчилан сэргийлэх, энэ талаар баримтлах заавар, журам боловсруулах, судалгаа шинжилгээ хийх, санал боловсруулах, мөн Монголбанкны санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийлгэх чиг үүргийг тус тус хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант онд ДХҮАЭГ нь Монголбанкны Ерөнхийлөгчийн баталсан дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу газар дээрх иж бүрэн шалгалтыг 9 газар, хэлтэс, алба, орон нутаг дахь 17 хэлтэс, салбарыг бүрэн хамруулан хийж шалгалтын дүнг Монголбанкны Захирлуудын зөвлөл, Хяналтын зөвлөлд цаг хугацаанд нь тайлагнан ажиллаа.

Үүнээс гадна газар, хэлтэс, албаны зарим үйл ажиллагаанд хэсэгчилсэн болон явцын шалгалт хийх зорилгоор нийт 9 удаа төлөвлөгөөт бус, хэсэгчилсэн шалгалтуудыг хийж, холбогдох шийдвэрүүдийг гаргуулсан болно.

ДХҮАЭГ-ын бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийг илүү боловсронгуй болгох, үйл ажиллагааны үе шат бүрт анхан шатны болон дараалсан хяналтыг тогтмол, тасралтгүй, үр дүнтэй хэрэгжүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлэх, ажилтнуудын мэдлэг боловсролыг дээшлүүлэх, шинэлэг арга барил, хэлбэрээр ажиллах зэрэг ажлуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

4.6 БЭЛЭН МӨНГӨНИЙ ХАНГАЛТ

Монголбанкнаас 2015 онд мөнгөн тэмдэгттэй холбоотой дараах үйл ажиллагааг эрхлэв. Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 706.5 тэрбум төгрөг байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 103.7 тэрбум төгрөг буюу 12.8 хувиар буурсан байна. Оны эцсийн байдлаар гүйлгээнд байгаа бэлэн мөнгө өмнөх оны мөн үетэй харьцуулахад дэвсгэртийн тоогоор 1.88 сая ширхэгээр буюу 0.6 хувиар өссөн байна. Энэхүү өсөлт нь жижиг дэвсгэртүүд болох 1-т, 5-т, 10-т, 20-т, 100-т болон 1000-тын дэвсгэртийн тоо ширхэг өссөнтэй холбоотой байна.

Хүснэгт 16. Бэлэн мөнгөний хангалтын үзүүлэлтүүд

№	Дэвсгэртүүд	2014 оны 12 дугаар сарын 31				2015 оны 12 дугаар сарын 31			
		сая төгрөг	хувь	мянган ширхэг	хувь	сая төгрөг	хувь	мянган ширхэг	хувь
1	1	30	0.0%	29,717	9.0%	30	0.0%	30,302	9.1%
2	5	133	0.0%	26,699	8.1%	136	0.0%	27,242	8.2%
3	10	623	0.1%	62,307	18.9%	680	0.1%	67,958	20.5%
4	20	966	0.1%	48,284	14.6%	1,010	0.1%	50,498	15.2%
5	50	2,016	0.2%	40,318	12.2%	1,982	0.3%	39,641	12.0%
6	100	3,963	0.5%	39,637	12.0%	4,039	0.6%	40,394	12.2%
7	200	34	0.0%	173	0.1%	35	0.0%	176	0.1%
8	500	5,978	0.7%	11,956	3.6%	5,702	0.8%	11,404	3.4%
9	1000	14,756	1.8%	14,755	4.5%	16,278	2.3%	16,279	4.9%
10	5000	50,003	6.2%	10,000	3.0%	43,420	6.1%	8,684	2.6%
11	10000	187,416	23.1%	18,742	5.7%	148,941	21.1%	14,894	4.5%
12	20000	544,274	67.2%	27,214	8.3%	484,264	68.5%	24,213	7.3%
Дүн		810,192	100.0%	329,802	100%	706,517	100.0%	331,685	100%

Хүснэгт 17. Банкуудаас хүлээн авсан, банкинд олгосон бэлэн мөнгөний тоо, үнийн дүн

Он	Банкинд олгосон		Банкуудаас хүлээн авсан	
	Нийт дүн (тэрбум төгрөг)	Мянган ширхэг	Нийт дүн (тэрбум төгрөг)	Мянган ширхэг
2011	1,246.4	181,258	1,310.6	170,460
2012	1,564.2	213,305	1,663.4	198,521
2013	1,601.6	216,394	1,728.7	202,035
2014	1,377.6	143,936	1,536.1	176,422
2015	1,238.9	190,518	1,352.6	187,536
Дүн	7,028.7	945,411	7,591.4	934,974

Тайлант онд Монголбанкны орон нутаг дахь хэлтэс, салбаруудад 132.6 тэрбум төгрөгийн зузаатгал хүргүүлж, 31.3 тэрбум төгрөгийн сайн болон 13.1 тэрбум төгрөгийн муу мөнгөн тэмдэгтийг төвд татан авсан.

4.7 МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ

Монголбанк нь тайлант онд банк хоорондын төлбөр тооцооны систем, цахим арилжааны систем болон байгууллагын дотоод үйл ажиллагаанд ашиглагдаж буй мэдээллийн системүүдийн аюулгүй, найдвартай, тасралтгүй ажиллагааг хангаж ажиллаа.

Монголбанкны Мэдээллийн технологийн газраас ашиглагдаж буй мэдээллийн системүүдийн найдвартай ажиллагааг хангахаас гадна тэдгээрийг сайжруулах, боловсронгуй болгох, шинэ техник, технологийн талаар судалж, үйл ажиллагаанд нэвтрүүлэх ажлууд хийгдлээ. Тухайлбал банк хоорондын захын үйл ажиллагаанд ашиглагдаж буй Засгийн газрын болон ТТөв банкны үнэт цаасны арилжааны програм, банк хоорондын мөнгөний захын програм болон цахим тайлангийн системд нэмэлт өөрчлөлтүүд хийж гүйцэтгэлээ. Байгууллагын дотоод үйл ажиллагаанд ашиглаж буй мэдээллийн системүүдийг өргөтгөх, сайжруулах ажлууд хийгдсэн бөгөөд байгууллага доторх цаасны хэрэглээг багасгахад чиглэгдсэн програм шинээр боловсруулж, эхний хэсгийг ашиглалтад орууллаа.

Мөн мэдээллийн технологийн аюулгүй байдлыг дээшлүүлэх, мэдээллийн технологийн хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн ажлууд хийлээ.

4.8 МОНГОЛБАНКНААС 2015 ОНД БАТАЛСАН ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧГҮҮД

Д/д	Эрх зүйн баримт бичгийн нэр	Огноо	Дугаар	Агуулга
